



МОНГОЛ УЛСЫН АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2021 он

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт 2021

Анхны хэвлэл 2021

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцын 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албан (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу. Олон улсын хөдөлмөрийн товчоо ийм хүсэлтийг хатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшуулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

ISBN: 9789220360330 (хэвлэмэл)

ISBN: 9789220360286 (веб PDF)

Мөн англи хэл дээр: The state of informal employment in Mongolia: Survey report, ISBN: 9789220360279 (веб PDF)

НҮБ-ын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын хэвлэл нийтлэлд ашиглагдсан тодорхойлолт, тусгагдсан материалыуд нь Олон улсын хөдөлмөрийн товчоо, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн зүгээс аливаа улс орон, бүс, газар нутаг, эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаар тогтоохтой холбоотой ямарваа үзэл бодол илэрхийлээгүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа, бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчоо, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш юм.

Байгууллагуудын болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүний нэр, үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчоо, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой байгууллагын нэр, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь ч тэдгээрийг үгүйсгэсэн асуудал биш болно.

ОУХБ-ын хэвлэл, цахим бүтээгдэхүүний талаарх мэдээллийг www.ilo.org/publish хаягаар авах боломжтой.

Монгол Улсад хэвлэв.

Судалгааны багийн ахлагч:

М.Алтансүх Хөдөлмөрийн эдийн засагч, Социологийн докторант, ХНХСИ-ийн дэд захирал

Судалгааны зөвлөх:

Жеофри Дюкейнс Атенео де Манилагийн Их Сургууль, дэд профессор, доктор

Б.Алтанцэцэг МУИС, дэд профессор, доктор

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

Б.Батбаатар ХНХСИ-ийн захирал

С.Батхолбоо ХЭБСС-ын эрхлэгч

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан:

Н.Жаргалсайхан

Д.Алтангэрэл

Г.Мягмардулам

С.Хүрэл-Эрдэнэ

Ш.Дэлгэрхишиг

М.Энхзориг

Ж.Өлзийсайхан

Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан:

Т.Мөнхбат

Гадаад харилцааны мэргэжилтэн:

Б.Үндрам

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: (+976) 77121286

www.rilsp.gov.mn

▶ ӨМНӨХ ҮГ

Монгол улсад тулгамдаж буй нийгмийн олон асуудлуудын нэг нь албан бус хөдөлмөр эрхлэлт юм. Энэ асуудал зөвхөн Монгол улсад төдийгүй хөгжиж буй олон орнуудын хувьд шийдэл хайж байгаа, тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас Албан бусаас албан эдийн засагт шилжих тухай 204 дүгээр зөвлөмжийг 2015 онд батлан гаргасан бөгөөд албан бус эдийн засагт ажиллаж буй хүн бүрийг албажуулах замаар эрхийг хамгаалах, албан салбараас албан эдийн засагт шилжих шилжилтийг дэмжихэд чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхдэд удирдамж, чиглэл болж байна.

Монгол улсын Засгийн газар Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг 2006-2015 онд гурван үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (2016-2025) зэрэг бодлогын баримт бичигт албан бус эдийн засагт ажиллагчдыг бүртгэлжүүлэх, нийгмийн даатгалд хамруулах, албажуулах зэрэг зорилт, арга хэмжээг тусган ажиллаж байна.

Албан бус эдийн засагт ажиллаж буй хүмүүст хөдөлмөрийн суурь эрхээ эдэлж, хэрэгжүүлэх боломж түйлын хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, эвлэлдэн нэгдэж, хамтын хэлэлцээр хийх, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгаж, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт хүчирхийллээс ангид байх, ажлын байрны нөхцөл, аюулгүй байдлаа хангуулах зэрэг олон эрх зөрчигддөг.

Албан бус эдийн засгийг албажуулахад чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, түүнд шаардлагатай мэдээллийг бий болгох судалгаа, шинжилгээний ажил зайлшгүй шаардлагатай байгаа энэ цаг үед энэхүү судалгааг гүйцэтгэж, “Монгол улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал: Судалгааны тайлан”-г танилцуулж байна.

Судалгаанд албан бус хөдөлмөр эрхлэлтийн шалтгааныг тодруулах зорилгоор албан бус хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий төлөв байдлыг тодорхойлж, албан бус эдийн засгийг албажуулах боломж, арга зам, албан бус ажиллагсад, бизнес эрхлэгчдийн хувьд цаашдын хандлага, төлөв ямар байгааг тодорхойлохыг хичээлээ. Түүнчлэн, судалгааг КОВИД-19 цар тахлын үед хийж гүйцэтгэсэн нь түүний албан бус нэгж, албан бус эдийн засагт ажиллагсадын үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг харах, цар тахлын үед авч буй Засгийн газрын арга хэмжээний нөлөө, хүртээмжийг судлах боломж олголоо.

Судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам (ХНХЯ)-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт ОУХБ-ын техникийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны явцад үнэтэй зөвлөмж өгч ажилласан ажлын хэсгийн гишүүд, тэр дундаа Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудад талархал илэрхийлье.

Энэхүү судалгааны үр дүн, зөвлөмж нь төрөөс албан бус эдийн засагт ажиллагсадыг албажуулах замааар хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, цочролд бэлэн байхад чиглээн бодлого, үйл ажиллагааг боловсруулах суурь мэдээлэл болж, Монгол Улсын албан бус эдийн засагт ажиллаж буй мянга мянган хүний ажил, амьдралд бодитой эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцаж, үйл ажиллагаандaa идэвхтэй ашиглаарай. Судалгааны талаарх санал, зөвлөмжөө бидэнд илгээн, хамтран ажиллахыг урьж байна. Бид хамтдаа бүх хүнд зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг олгож чадна гэдэгт гүнээ итгэж байна.

Аюушийн Ариунзаяа

Монгол Улсын Хөдөлмөр,
нийгмийн хамгааллын
сайд

Чан Хи Ли

ОУХБ-ын БНХАУ, Монгол
Улсыг хариуцсан
товчооны
захирал

Филипп Маркарон

ОУХБ-ын Хөдөлмөрийн
зах зээл, хөдөлмөрийн
харилцаа, хөдөлмөрийн
нөхцөлийн хэлтсийн
дарга

► ГАРЧИГ

Өмнөх уг	4
Гарчиг	6
Талархал	12
Товч хураангуй	13
Товчилсон үгийн жагсаалт	21
► Бүлэг 1. Судалгааны үндэслэл ба арга зүй.....	22
1.1 Албан бус эдийн засгийн өнөөгийн байдал, судалгааны үндэслэл	22
1.2 Судалгааны зорилго, ач холбогдол	26
1.3 Сэдэв судлагдсан байдал	27
1.4 Түүврийн дизайн ба аргачлал	31
1.5 Судалгааны ойлголт, тодорхойлолт	33
► Бүлэг 2. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөл, шинж чанар	35
2.1 Судалгаанд оролцогчдын нийгэм-хүн ам зүйн шинж чанар	35
2.2 Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлт	37
2.3 Албан бус хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөрийн харилцаа.....	51
2.4 Нэмэлт статистик дүн шинжилгээ.....	58
► Бүлэг 3. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан эдийн засаг руу шилжихийг дэмжих: бэрхшээл ба боломж	62
3.1 Албан эдийн засагт шилжихэд тулгарч буй бэрхшээл, боломжууд.....	62
3.2 Цахим бүртгэл, цахим төлбөрийн боломжит нөлөө.....	73
3.3 Нэмэлт статистик дүн шинжилгээ.....	78
► Бүлэг 4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрийн хамрагдалт	81
4.1 Албан бус хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчин, хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр	81
4.2 Мэдээллийн эх сурвалж, хамрагдалт.....	85
4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгцээ.....	94
4.4 Нэмэлт статистик дүн шинжилгээ.....	96
► Бүлэг 5. Албан бус хөдөлмөр эрхлэлт дэх цар тахлын нөлөө	98
5.1 Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл ба эдийн засгийн нэгжид үзүүлсэн нөлөө	98

5.2 Тусламжийн төрөл, эх сурвалж, үр нөлөө	107
5.3 Засгийн газраас хэрэгжүүлсэн сэргийлэх арга хэмжээний үзүүлсэн нөлөө.....	108
5.4 Эдийн засгийг дэмжих арга хэмжээний хамрагдалт ба үр дүнгийн үнэлгээ	110
5.5 Ирээдүйн төлөвлөгөө (ажил олгогч ба хувиараа хөдөлмөр эрхлэгчид)	113
5.6 Цахим технологийн хэрэглээ (ажил олгогч ба хувиараа хөдөлмөр эрхлэгчид).....	116
5.7 Нэмэлт статистик дүн шинжилгээ.....	123
Үр дүн, зөвлөмж.....	127
Ашигласан материал	133

► ШИГТГЭЭН ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн олон улсын тодорхойлолт.....	34
Шигтгээ 2. Албан эдийн засагт шилжих: Олон улсын туршлага	76
Шигтгээ 3. Цар тахлын үеийн албан бус хөдөлмөр эрхлэлт	121

► ХУСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Албан бус хөдөлмөр эрхлэгчид хөдөлмөр эрхлэлтийн статусаар (нийт дунд эзлэх хувь)	24
Хүснэгт 2. Албан бус хөдөлмөр эрхлэгчид (ХАА бус), үйл ажиллагааны нэгжээр (нийт дунд эзлэх хувь)	24
Хүснэгт 3. Ажилтнуудын шинж чанар	25
Хүснэгт 4. Өрхийн сарын дундаж орлого (1000 төг.).....	37
Хүснэгт 5. Өрхийн орлогын бүлэг байршлаар /хувь/	37
Хүснэгт 6. Ажиллагсдын хүйс, хөдөлмөр эрхлэлтийн байдал, бус нутгаар /хувь/	39
Хүснэгт 7. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагаа, бус нутгаар /хувь/	40
Хүснэгт 8. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн шалтгаан, мэргэжлээр/хувь/	44
Хүснэгт 9. Ажил олгогч ба хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байр, ажилласан жилээр /хувь/	45
Хүснэгт 10. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7 хоногт ажилласан дундаж өдөр /хувь/	54
Хүснэгт 11. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7 хоногт ажилласан ажлын өдөр, мэргэжлээр /хувь/.....	54
Хүснэгт 12. Ажил, бизнес нь ирээдүйтэй эсэх, ажилласан жилээр /хувь/	64
Хүснэгт 13. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, насны бүлгээр/хувь/.....	74

Хүснэгт 14. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, боловсролын түвшнээр /хувь/.....	75
Хүснэгт 15. Албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомж.....	82
Хүснэгт 16. Бодлого хөтөлбөр.....	83
Хүснэгт 17. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэг /хувь/	85
Хүснэгт 18. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид насны бүлгээр /хувь/	86
Хүснэгт 19. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид боловсролын түвшнээр /хувь/	87
Хүснэгт 20. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалж, бүсээр /хувь/	88
Хүснэгт 21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалж насны бүлгээр /хувь/	89
Хүснэгт 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж чадаагүй шалтгаан насны бүлгээр /хувь/.....	93
Хүснэгт 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж чадаагүй шалтгаан боловсролын түвшнээр /хувь/.....	94
Хүснэгт 24. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хэрэгцээ, эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар /хувь/	95
Хүснэгт 25. Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар /хувь/	100
Хүснэгт 26. Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан аж ахуйн нэгж/ажлын байрны үйл ажиллагааны түвшний өөрчлөлт, оноор /хувь/	101
Хүснэгт 27. Долоо хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, бүс, ХЭ-ийн статусаар /цаг/	102
Хүснэгт 28. Цар тахлын өмнөх үеэс цар тахлын үеийн 7 хоногийн ажлын цагийн өөрчлөлт, ажил үүрэг, ХЭ статусаар /хувь/	102
Хүснэгт 29. Цар тахлын өмнөх үеэс цар тахлын үеийн 7 хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар /цаг/	103
Хүснэгт 30. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогод үзүүлсэн нөлөө, ХЭ-ийн статус, ЭЗҮА-ны салбараар /мян.төг/	105
Хүснэгт 31. Санхүүгийн дэмжлэг, төрөл, Эх сурвалжаар /хувь/.....	108
Хүснэгт 32. Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан хүндрэл /хувь/	109
Хүснэгт 33. Ковид-19-с сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан хүндрэл (дундаас маш хүнд хүртэл хосолсон), ХЭ статусаар /хувь/	109
Хүснэгт 34. Эдийн засгийг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээнд хамрагдсан байдал, ХЭ статусаар /хувь/	111
Хүснэгт 35. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн , ХЭ статусаар /хувь/	112
Хүснэгт 36. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн , by main activity /хувь/	113
Хүснэгт 37. Цаашид тулгарч болзошгүй бэрхшээл, бүс /хувь/	115
Хүснэгт 38. Цар тахлын үед бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад тохиолдож буй зонхилох бэрхшээл, бүсээр /хувь/	116

Хүснэгт 39. Дижитал технологийн хэрэглээ, төрөл /хувь/	119
Хүснэгт 40. Дижитал технологийн хэрэглээ, бус /хувь/.	120

▶ ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улаанбаатар хотын албан бус хөдөлмөр эрхлэлт	22
Зураг 2. Монгол Улс болон Улаанбаатарт албан бус хөдөлмөрийн нийт хөдөлмөрт эзлэх хувь (ХАА-н бус)	23
Зураг 3. Албан бус хөдөлмөрийн эзлэх хувь (ХАА-н бус), хүйсээр	23
Зураг 4. Албан бус хөдөлмөр эрхлэгчид хүйс насны бүлгээр /хувь/	35
Зураг 5. Албан бус хөдөлмөр эрхлэгчид боловсролоор /хувь/	36
Зураг 6. Албан бус хөдөлмөр эрхлэгчид бүсээр /хувь/	36
Зураг 7. Цар тахлын өмнөх ажилд албан бус хөдөлмөр эрхэлсэн дундаж хугацаа /жил/	38
Зураг 8. Хөдөлмөр эрхлэлтийн статус насны бүлгээр /хувь/	39
Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийн статус, боловсролоор /хувь/	40
Зураг 10. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/	41
Зураг 11. Гүйцэтгэж буй ажил мэргэжлийн чиглэл, хүйсээр /хувь/	42
Зураг 12. Ажилтан албан бус хөдөлмөр эрхэлж буй шалтгаан хүйсээр /хувь, олон хариулт өгөх боломжтой/	43
Зураг 13. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхэлж буй шалтгаан /хувь/	43
Зураг 14. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байр байршилаар /хувь/	45
Зураг 15. Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр /хувь/	46
Зураг 16. Ажилтны албан бус хөдөлмөр эрхлэхийн давуу тал /хувь/	47
Зураг 17. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхлэхийн давуу тал /хувь/	47
Зураг 18. Ажилтны албан бус хөдөлмөр эрхлэхийн сүл тал /хувь/	48
Зураг 19. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхлэхийн сүл тал /хувь/	48
Зураг 20. Зээл авахад хүндрэлтэй байгаа шалтгаан /хувь/	49
Зураг 21. Зээл авсан шалтгаан /хувь/	50
Зураг 22. Зээл авсан эх сурвалжаар /хувь/	50
Зураг 23. Авсан зээлийн ажил үйлчилгээнд үзүүлсэн нөлөө /хувь/	51
Зураг 24. Сарын дундаж цалин, хөдөлмөр эрхлэлтийн статусаар /мян.төг/	52
Зураг 25. Сарын дундаж цалин, бус, хүйсээр /мян.төг/	52
Зураг 26. Сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагаагаар /мян.төг/	53
Зураг 27. Ажлын байрны нөхцөл, байршилаар /хувь/	55

Зураг 28. Түрээсийн болон төвлөрсөн зах тусгайлсан ажлын байрны нөхцөл/хувь/	56
Зураг 29. Осол гэмтэлийн төрлөөр /хувь/	56
Зураг 30. Осол гэмтэлд өртсөн үед эмчилгээний зардал гаргасан байдаар /хувь/.....	57
Зураг 31. Хөдөлмөрийн маргааны шалтгаан /хувь/.....	58
Зураг 32. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл /хувь/	63
Зураг 33. Эрхэлж буй ажил, бизнес нь ирээдүйтэй эсэх, статусаар /хувь/	64
Зураг 34. Албан эдийн засагт шилжих сонирхол /хувь/	66
Зураг 35. Албан ёсны бүртгэлтэй болох сонирхол, насын бүлгээр /хувь/	67
Зураг 36. Албан ёсны бүртгэлтэй болох сонирхол, үйл ажиллагаа явуулсан жилээр /хувь/	67
Зураг 37. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид; бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгоход нөлөөлөх үр ашиг /хувь/	68
Зураг 38. Ажилтны албан салбарт хөдөлмөр эрхлэх үр ашиг /хувь/	69
Зураг 39. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан хөдөлмөрт шилжихэд нөлөөлөх хөнгөлөлт, урамшуулал/хувь/	69
Зураг 40. Ажиллагчдын албан салбарт хөдөлмөр эрхлэхэд нөлөөлөх дэмжлэг, арга хэмжээ /хувь/	70
Зураг 41. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид; албан хөдөлмөр/бизнест шилжихэд тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/	71
Зураг 42. Ажил үйлчилгээгээ бүртгүүлэхээс татгалзах шалтгаан /хувь/.....	71
Зураг 43. Ажилтнуудын албан салбарт хөдөлмөр эрхлэхэд тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/.....	72
Зураг 44. Ажилтнуудын албан салбарт хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байгаа шалтгаан /хувь/	72
Зураг 45. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх /хувь/	73
Зураг 46. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, хугацаагаар /хувь/	74
Зураг 47. Цахим бүртгэл нь нийгмийн даатгалд хамрагдахад нөлөөлөх эсэх /хувь/	75
Зураг 48. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн эх сурвалж /хувь/	88
Зураг 49. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан ба хөтөлбөрийн талаар мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид /хувь/.....	90
Зураг 50. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагд оролцогчдын хувь/	91
Зураг 51. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагдсанаар бий болсон давуу тал /хувь/	92
Зураг 52. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний сул тал /хувь/	92

Зураг 53. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж чадаагүй шалтгаан /хувь/	93
Зураг 54. Бизнест ашигтай төрийн дэмжлэг /хувь/	94
Зураг 55. Бизнесийг сайжруулахад шаардлагатай сургалтын хэрэгцээ /хувь/.....	95
Зураг 56. Бизнесийг сайжруулахад шаардлагатай бусад сургалтын хэрэгцээ /хувь/.....	96
Зураг 57. Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан аж ахуйн нэгж/ажлын байрны үйл ажиллагааны өөрчлөлт /хувь/	99
Зураг 58. 7 хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, хүйсээр /хувь/	101
Зураг 59. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн цалин эсвэл цэвэр орлогод үзүүлсэн нөлөө, ХЭ-ийн статусаар /хувь/	104
Зураг 60. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн орлогын өөрчлөлт, хэ-ийн статус, /хувь, мянган төгрөгөөр/	106
Зураг 61. Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өрхийн орлогод гарсан өөрчлөлт /хувь/	106
Зураг 62. Амьжиргааны зардлаа хангахад өрхийн орлого нь хүрэлцээтэй эсэх, ЭЗҮА-ны салбараар /хувь/	107
Зураг 63. Авсан тусламж, төрөл, хөдөлмөр эрхлэлтийн статусаар /хувь/.....	108
Зураг 64. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн /хувь/	111
Зураг 65. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дэмжлэгийн хэрэгцээ /хувь/	114
Зураг 66. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд цар тахлын үед цаашид тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/.....	114
Зураг 67. Цар тахлын үед бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад тохиолдож буй зонхилох бэрхшээл /хувь/	115
Зураг 68. Дижитал технологийн хэрэглээ, боловсролоор /хувь/.....	117
Зураг 69. Дижитал технологийн хэрэглээ, насаар /хувь/	117
Зураг 70. Дижитал технологийн хэрэглээ, үйл ажиллагаа явуулсан жилээр /хувь/	118
Зураг 71. Дижитал технологийн хэрэглээ, ажил мэргэжил /хувь/	118

► ТАЛАРХАЛ

Энэ удаагийн Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа нь олон хүний хичээл зүтгэл, хичээнгүй оролцоо, техник-санхүүгийн тусlamжтайгаар хийгдэж дууслаа.

Манай судалгааг анхнаас нь дэмжиж, судалгааны багийнханд ажиллах бололцоог гаргаж өгсөн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, тус яамны дэд сайд С.Зулпхар, Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, ХЭБХЗГ-ын дарга С.Дамбий, мэргэжилтэн Г.Тэмүүжин, шинжээч Ц.Алтанцацral нарт талархал илэрхийлье.

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгааг гүйцэтгэхэд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын “Монгол Улсын эдийн засгийн төрөлжилт, хүртээмжтэй өсөлтийг хангахад албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” (MNG/18/01/RBS) төсөл нь техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн билээ.

Судалгааны бүхий л баримт бичгүүдэд үнэтэй санал, зөвлөгөө өгч, чин сэтгэлээсээ хамтран ажилласан Бангкок дахь ОУХБ-ын Зохистой хөдөлмөрийн техникийн дэмжлэг үзүүлэх баг болон Женев дэх ОУХБ-ын техникийн хэлтсийн мэргэжилтнүүд, ялангуяа Сандра Ю, Макико Мацуумото, Флоренс Боннет, Жудит ван Дорн нар болон Монгол дахь үндэсний зохицуулагч П.Болормаа, төслийн зохицуулагч А.Лхагвадэмбэрэл, ажилтан Б.Баярцэцэг, мөн өөрсдийн мэдлэг, чадвараа харамгүй хуваалцаж, мэргэжлийн өндөр түвшинд зөвлөгөө өгч, судалгааны тайланг хамтран бичсэн олон улсын зөвлөх Жеофри Дюкеинс, үндэсний зөвлөх Б.Алтанцэцэг нарт гүн талархал илэрхийлье.

Судалгааны бүхий л үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, нөр их ажлыг хамтдаа гүйцэтгэсэн ХНХСИ-ийн хамт олондоо баярлаж талархсанаа илэрхийлж байна.

Судалгааны баг

▶ ТОВЧ ХУРААНГҮЙ

ОРШИЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институттээс (ХНХСИ) 2021 оны дөрөвдүгээр сард гүйцэтгэсэн “Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа”-ны үр дүng танилцуулж байна. Судалгааны мэдээлэл нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ Ковид-19 цар тахлын албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх нөлөөг тодруулах зорилготой юм.

Судалгааг зохион байгуулахдаа Монгол Улсыг засаг захиргааны таван бүсд хуваан албан бус хөдөлмөр эрхлэгчдээс санамсаргүй түүвэрлэн, тоон судалгааны асуулгын аргаар мэдээлэл цуглувансан. Санамсаргүй түүвэрт 2019 оны Ажиллах хүчиний судалгаагаар (YCX, 2019) тооцоолсон зорилтот хүн ам болох 195,000 орчим хөдөө аж ахуйн бус албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төлөөлөх 3,000 хүнийг хамруулсан.

Судалгаанд мөн экспертийн бүлгийн ярилцлага, хоёрдогч мэдээллийн эх сурвалжид баримт бичгийн дүн шинжилгээ хийх зэрэг чанарын судалгааны аргыг ашигласан.

Түүвэр судалгааны мэдээлэл цуглувулалтад цар тахлын нөхцөл, хөл хороо зэргийг харгалзан телефон утасны ярилцлагыг ашигласан. Экспертийн бүлгийн ярилцлагыг төрийн бодлого тодорхойлогчид, хөдөлмөрийн харилцаанд оролцогч гурван тал, мэргэшсэн судлаач, эрдэмтдийг оролцуулан цахимаар зохион байгууллаа.

Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн:

- ▶ 49.7 хувь нь Улаанбаатар хот, 50,3 хувь нь хөдөө орон нутагт (баруун, төв, зүүн бүсэд) байна;
- ▶ 44.0 хувь нь эрэгтэй, 56.0 хувь нь эмэгтэй байна; мөн
- ▶ 7.3 хувь нь албан бус салбарын ажилтан, 42.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 50.5 хувь нь ажил олгогч байна.

СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

• АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, ШИНЖ ЧНАР

Судалгааны үр дүнгээр хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд, харин ажилтнуудын ихэнх эрэгтэйчүүд байна. Ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс залуу байсан бол ажил олгогчид илүү хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол тавны нэг орчим нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нэлээд хувийг эзэлдэг бусад салбаруудад тээвэр, агуулахын үйл ажиллагаа, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбар орсон.

Албан бус хөдөлмөр эрхлэлт нийгмийн угшмал үзэгдлүүдийн нэг болжээ. Албан бус хөдөлмөр эрхэлсэн дундаж хугацаа 11.8 жил, 64.8 хувь нь ажлын байрандаа наймаас доошгүй жил ажилласан байна.

Хувийн хүсэл сонирхол, албан ёсны ажил олоход тохиолдох бэрхшээл, өөр сонголтгүй байх зэрэг нь албан бус хөдөлмөр эрхлэх хамгийн түгээмэл шалтгаан болсон байна. Ялангуяа эмэгтэйчүүд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаанаа өөрийн хүсэл сонирхолтой холбон тайлбарлаж байсан бол эрэгтэйчүүд ажил олоход хүндрэлтэй байна гэжээ. Ажил, олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь өөрсдийн хүсэл сонирхлоос болж албан бус хөдөлмөр эрхэлж байгаа гэж хариулжээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд түрээсийн эсвэл өөрийн эзэмшдэг ажлын байранд ажиллах нь түгээмэл байв. Гэхдээ энэ нь ажил, үйлчилгээ явуулдаг байршилын хувьд зарим ялгаатай байсан. Улаанбаатар хотод тэдний олонх нь түрээсийн байранд ажилладаг бол орон нутагт өөрсдийн эзэмшлийн ажлын байранд ажилладаг байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь байнгын ажилтай боловч хүйсийн ялгаа их байгаа нь ажиглагдсан. Жишээ нь: эмэгтэйчүүдийн 82 хувь нь байнгын ажилтай гэж мэдээлсэн бол эрэгтэйчүүдийн хувьд дөнгөж 39 хувь байна.

Судалгаанд оролцогч албан бус салбарт ажиллагчид ажил олгогчтой албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй бөгөөд 75.5 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй эсвэл ажил олгогчтойгоо зөвхөн амаар тохиролцон ажилладаг.

Ажилтнууд албан бус хөдөлмөрийн давуу талыг уян хатан ажлын цагтай, цалин сайтай, ур чадварт нь тохирдог гэсэн бол сүл талыг нийгмийн хамгаалалд хамрагдахгүй байдал, цалин хөлс тогтвортгүй, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу байгаа гэжээ. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд уян хатан ажлын цаг, ашиг орлого, гэр булийнхэнтэйгээ ажиллах боломж зэргийг давуу тал гэсэн. Харин орлого тогтвортгүй, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй, ажлын байрны баталгаа байхгүй зэрэг нь сүл тал гэж дурджээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн зургааны нэг нь зээлийн барьцаа хүрэлцэхгүй, албан ёсны шаардлага хатуу, хүү өндөр зэргээс шалтгаалан зээл авч чадаагүй. Зээл авч чадсан ихэнх нь албан ёсны эх сурвалжаас (арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага) зээл авсан байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цэвэр орлого 1,709,000 төгрөг байсан, гэхдээ ажил олгогчдын хувьд орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилтнуудтай харьцуулахад өндөр, мөн Улаанбаатар хотод бусад бус нутгийнхаас өндөр байлаа. Ажилтнуудын тавны хоёр нь тогтсон хуваарийн дагуу цалин авдаггүй гэжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид урт цагаар ажиллаж байна. Тэд долоо хоногт дунджаар 58.1 цаг ажилладаг нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цагийн ажлын долоо хоногоос хавьгүй илүү байна.

Мэргэжлээс шалтгаалах осол гэмтлийн тухай цөөн тооны мэдээлэл ирсэн, мөн ажилтнуудын арван хоёрны нэг нь л цалин хөлс, түрээсийн төлбөртэй холбоотой ажлын байрны маргаантай тулгарсан гэжээ.

• АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙГ АЛБАН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХИЙГ ДЭМЖИХ

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь бизнес эрхлэхэд асуудал тулгараагүй гэсэн боловч татвар, хураамж, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын байрны эзэдтэй холбоотой асуудлууд цөөн боловч тохиолдож байжээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь бизнесийнхээ талаар өөдрөг үзэлтэй байгаа бөгөөд ажил олгогчдын тавны дөрөв нь өөрсдийн эрхэлж буй бизнесийг ирээдүйтэй гэж үзэж байна.

Албан эдийн засагт шилжих сонирхол. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь албан эдийн засгийн салбарт шилжих сонирхолтой байгаа ч энэ хандлага нь тэдний ажил эрхлэлтийн байдалтай холбоотой. Албан эдийн засагт шилжих сонирхол хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс, ажил олгогчид, ажилтан гэсэн дарааллаар өсөж байв. Харин арай залуу, богино хугацаанд бизнес эрхэлж байгаа ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид албан эдийн засагт шилжих сонирхолтой байгаагаа илүү илэрхийлсэн. Тэдний дунд барилга, аж үйлдвэр болон бусад салбарынхан түлхүү байна. Тээврийн салбарын хувиараа хөдөлмөр эрхлэгчид бизнесээ бүртгүүлэх сонирхол багатай байсан.

Албан эдийн засагт шилжихийн давуу талын талаарх хүлээлт. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бизнесээ бүртгүүлснээр ашиг орлого, борлуулалтын хэмжээ, үйлчлүүлэгч нэмэгдэнэ, үйл ажиллагаа өргөжиж ажлын байр нэмэгдэнэ гэсэн хүлээлт байна. Ажилтнуудын хувьд албан салбарт ажиллах нь цалин орлого нэмэгдэн тогтмолжих, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдах үр ашигтай хэмээн үзэж байна.

Албан эдийн засагт шилжихэд шаардлагатай дэмжлэгийн талаарх ойлголт. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд бизнесээ албан ёсны болгоход хамгийн чухал дэмжлэг нь бага хүүтэй зээл бол ажилтнуудад өндөр цалинтай албан ажлын байр, хөдөлмөр зуучалын үйлчилгээ хамгийн их хэрэгтэй байна.

Албан эдийн засагт шилжихэд тулгарч буй саад бэрхшээлүүд. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дарамт, татвар, хураамжийн тухай хуулийн мэдлэг дутмаг, нягтлан бодох бүртгэлийн асуудал, бүртгэлийн дүрэм журмын төвөгтэй байдал гэсэн хариултыг өгсөн байна. Харин ажилтнууд учирч буй гол бэрхшээлийг боловсролын шаардлага хангахгүй, мэргэжил, ур чадварт тохирохгүй, ажлын байрны хомсдол, олдоц муу гэжээ.

Албан эдийн засагт шилжих хөшүүрэг. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг гол хөшүүрэг гэжээ. Хөдөлмөр эрхлэлтийн салбараар авч үзвэл барилгын салбарынхан орлогын албан татвараас чөлөөлөх, төрийн худалдан авалтад хамрагдах боломжийг дурдсан бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан төрийн худалдан авалтад хамрагдах боломжийг илүү их дурдсан байна. Ажил олгогчдын хувьд ОАТ-аас тодорхой хугацаанд чөлөөлөх, НӨАТ-аас чөлөөлөх, НДШ-ээс чөлөөлөх, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, бичил бизнесийг дэмжих бага хүүтэй зээл, төрийн худалдан авалтад оролцох боломж зэрэг нь бизнесээ бүртгүүлэх хөшүүрэг болно гэж хариулсан байна.

Цахим бүртгэлийн нөлөө. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн олонх нь цахим бүртгэл бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгоход нөлөөлөх эсэхийг мэдэхгүй гэж хариулсан. Тэдний ихэнх нь ахмад насны хүмүүс байна. Харин аравны гурав нь нөлөөлнө, дөрөвний нэг орчим нь цахим бүртгэлтэй болох нь тэдний бизнесийг албан ёсоор бүртгүүлэхэд нөлөөлөхгүй гэж хариулжээ. Цахим бүртгэл нөлөөлөх магадлал нь ажил олгогчдын хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс өндөр байсан.

• ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Мэдээллийн хүртээмж. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар мэдлэггүй байна. Мэдлэггүй байдал боловсролын түвшин доогуур хүмүүсийн хувьд өндөр байх хандлага ажиглагдсан.

Оролцооны хэмжээ. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү хувь нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл хаанаас авахаа мэддэггүй юм байна. Судалгаанд оролцогчдын тавны нэг нь ажил эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл авахдаа утас, цахим мэдээллийн суваг, тавны нэг орчим нь телевиз, радиог ашигладаг байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны нэг гаруй нь л хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан. Ажилтнуудын дөнгөж хорин хүний нэг нь л хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт оролцох нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй зерэг хамааралтай байна.

Хэдийгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн тоо бага байгаа ч, тэдний ихэнх нь төсөл, хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүнд хүрсэн гэж хариулсан. Хамгийн их дурдагдсан үр ашиг нь ажил, үйлчилгээгээ өргөжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлсэн байв. Харин тавны нэг орчим нь ямар ч үрашиг хүртээгүй гэж мэдээлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хамгийн их дурдагдсан сул тал бол санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал байсан гэжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй хүмүүсийн ихэнх нь мэдээлэл аваагүйгээс болсон гэж хариулсан бол тавны нэг орчим нь шаардлага хангаагүй гэж хариулсан байна.

Төрийн дэмжлэг. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны долоо орчим нь төрөөс ямар нэгэн дэмжлэг авах шаардлагатай гэж хариулсан бөгөөд хамгийн их дурдагдсан дэмжлэг нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, бичил бизнесийн зээл, гарааны бизнесийг дэмжих дэмжлэг зэрэг байв. Төрөөс ямар нэгэн дэмжлэг хэрэгтэй гэж хариулсан оролцогчдын тал хувь нь бизнес эрхлэх сургалт хэрэгцээтэй байгааг дурджээ.

• ЦАР ТАХЛЫН АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Ажлын байр багассан. Судалгааны мэдээлэл цуглуулалт цар тахлын үетэй давхацсан. Цар тахлаас шалтгаалж хөл хорио тогтоосноос албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү нь ажил үйлчилгээгээ явуулаагүй гэжээ. Ажилтнууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үлэмж хэсэг ажил үйлчилгээгээ зогсоосон байна. Статистик шинжилгээгээр харьцангуй өндөр боловсролтой, зочид буудал, байр орон сууц, тээвэр, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилладаг хүмүүс цар тахлын үеэр ажилгүй болсон байх магадлал илүү өндөр байна.

Судалгааны хугацаанд ажилтай байсан хүмүүсийн 70 хувь нь тэдний аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны түвшин буурсан, аравны нэгээс арай илүү нь аж ахуйн нэгж нь түр хаагдсан гэж хариулжээ.

Бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагааны түвшин буурах нь тулхүү ажиглагдсан. Харин зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа түр хаах нь илүү тохиолджээ. Судалгааны хугацаанд ажиллаж байсан бараг бүх оролцогчид цар тахлын өмнө эрхэлж байсан ажлаа үргэлжлүүлэн эрхэлж байна.

Цар тахлын үед долоо хоногийн дундаж ажлын цаг 6-7 цагаар буурчээ. Эмэгтэй ажилтан болон эмэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын цаг нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү буурсан байна. Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, хамгийн их өртсөн нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд, барилгын салбар дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажил олгогчид байв.

Орлого буурсан. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл бүгдийнх нь цэвэр орлого буурсан байна: ажил олгогчдын хувьд 57 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 55 хувиар, ажилтнуудын хувьд 40 хувиар буурав. Эрэгтэйчүүдийн цэвэр орлого эмэгтэйчүүдийнхээс илүү буурчээ. ЭЗҮА-ны салбар болон хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл барилгын салбарын ажил олгогчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид хамгийн их бууралттай байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бараг тал нь цар тахлын үед өрхийн орлого нь амьжиригааны зардлаа нөхөхөд хүрэлцэхгүй байна гэжээ.

Амьжиригаанд эрсдэл учруулсан. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны зургаагаас илүү нь амьжиригааны хэрэгцээний зардлаа нөхөхөд хүрэлцээтэй хэмжээний тусlamж аваагүй гэжээ.

Дийлэнх нь хөл хорионы арга хэмжээний улмаас ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаа багассан, ажил, бизнесээ түр хугацаанд эсвэл бүрмсөн зогсоосон, цалин орлого нь буурсан, үйлдвэрлэлийн орцын үнэ өссөн, зайлшгүй шаардлагатай түүхий эдийн нийлүүлэлт тасалдсан, бизнес, хөрөнгө оруулалтын үр дүнтэй шийдвэр гаргахад хүндрэлтэй байсан зэрэг нь тэдний амьжиригааг хүндрүүлсэн эсвэл маш хүнд байдалд хүргэсэн гэжээ.

Цар тахлын үеийн хөл хорио хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид, залуу ажилтнууд болон бакалаврын болон түүнээс дээш боловсролтой иргэдэд илүү хүндээр нөлөөлсөн байна.

Амьжиргааны дэмжлэг. Албан бус хөдөлмөр эрхлэгчид бараг бүгд цахилгаан, дулаан, усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээнд, аравны долоогоос илүү нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид, зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан арга хэмжээнд тавны нэг орчим нь хамрагджээ. Ихэнх нь засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээг өрхийн орлогыг дэмжсэн, ашиглалтын зардал бууруулсан, цалин, цэвэр орлогыг дэмжсэн зэргээр үр дүнтэй болсон гэж үзсэн, харин ажилтнуудын хувьд ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бага үр ашиг хүртсэн байна. НДШ-ийг бүрэн тэглэсэн арга хэмжээ нь эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд, ажилтнуудаас илүү ажил олгогчдод үр өгөөжтэй байсан.

Орлогын албан татвараас чөлөөлсөн арга хэмжээ нь эмэгтэйчүүдэд үр ашиг багатай байв. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас (ААНОАТ) чөлөөлсөн арга хэмжээ нь ажил олгогчдод ажилчдаас хамаагүй илүү ашигтай байсан ба бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхантай харьцуулбал их ашиг хүртсэн байна. Гүнзгийрүүлсэн шинжилгээгээр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үр ашгийг албан бус салбарт ажилладаг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага хүртдэг байх магадлалтай, мөн 60 ба түүнээс дээш насныхан ашиг хүртэх магадлал хамгийн бага байсан.

Цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээ нь бүх нийтэд ашигтай байсан. Зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан арга хэмжээний хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү ашиг хүртэх магадлалтай, насны бүлгээр нь авч үзвэл 60 ба түүнээс дээш насныхан ашиг хүртэх магадлал хамгийн бага, мөн ажил олгогчид ажилтнуудыг бодвол үр ашиг хүртэх магадлал хамаагүй өндөр байв.

Ажил олгогч, хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд бараг бүгдээрээ бизнесээ үргэлжлүүлэх бодолтой байна. Гэхдээ ихэнхэд нь хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг хэрэгцээтэй, учир нь цар тахлын үед санхүүгийн хомсдол хамгийн ноцтой асуудал болох хүлээлттэй байна.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны дөрөв хүрэхгүй нь бизнестээ дижитал технологийг ашигладаг. Дижитал технологийн хэрэглээ боловсролын түвшин ахих тусам нэмэгдэж, нас, бизнес эрхэлсэн хугацаа ахих тусам буурч байсан.

Хамгийн их ашиглагддаг олон нийтийн цахим сүлжээ бол Facebook, түүнээс хамаагүй бага боловч дараагийнх нь WeChat байв. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны ес гаруй нь мобайл мөнгө, карт (ATM) ашигладаг бөгөөд бараг тал нь онлайн худалдаа хийдэг байна.

• БОДЛОГЫН ҮР ДАГАВАР БА ЗӨВЛӨМЖ

Судалгаагаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн харилцааны нөхцөл тааламжгүй байгаа гэж үзэж болно. Ажилтнуудын хувьд дийлэнх нь албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй, мөн олон тооны ажилтан цалин хөлсөө тогтсон

хуваарийн дагуу авдаггүй нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд бас нэг санаа зовоосон асуудал бол ажлын хэт урт цаг юм.

Албан эдийн засагт шилжүүлэх. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь албан эдийн засагт шилжих сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Энэ нь албан болгох санаачилгыг нэвтрүүлэх эсвэл өргөжүүлэх тохиромжтой эхлэлийн цэг болно. Албан эдийн засагт шилжүүлэх хөтөлбөр, түүний дотор албан болгох зардал, үр ашгийн талаарх мэдээллийг түгээхдээ судалгаанаас илэрсэн албан эдийн засагт шилжих сонирхлын хэв маягийг харгалзан үзэх ёстой. Тухайлбал, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд албан эдийн засагт шилжих сонирхол нь залуу болон илүү өндөр боловсролтой иргэдийн хувьд их, ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс илүү өндөр, мөн барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхны хувьд өндөр байгаа юм.

Албан эдийн засагт шилжих хөтөлбөрийг боловсруулахдаа албан бус хөдөлмөр эрхлэгчдэд тулгарна гэж санаа зовж буй гол бэрхшээлүүдийг тооцож үзэх хэрэгтэй. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид татвар, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, хураамжийн тухай хуулийн мэдлэг дутмаг, нягтлан бодох бүртгэлийн асуудал, бүртгэлийн үйл явцын төвөгтэй байдал зэргийг бэрхшээл учруулж байна гэжээ. Ажилтнуудын хувьд хамгийн их тулгардаг бэрхшээл нь шаардлагатай ур чадварын дутагдал байдаг.

Эдгээрээс дүгнэвэл албан эдийн засагт шилжихийг дэмжих арга хэмжээнд нягтлан бодох бүртгэл, татварын хууль, ажлын ур чадварын сургалт, мэдээлэл түгээх, бүртгэлийн журмыг хялбаршуулах, нийгмийн даатгалын шимтгэл, татварын төлбөрийг түр хөнгөлөх, бүр чөлөөлөх зэрэг орж болно.

Бүртгэлийн үйл ажиллагааг хялбар болгоход цахим бүртгэлийн тогтолцоог бий болгож болох боловч энэ нь түүнийг хэрхэн ашиглах талаар өргөн хүрээнд мэдээлэл түгээх, сургалтад хамруулах ажилтай хамт явах ёстой, учир нь судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн олонх нь түүний үр нөлөөний талаар тодорхой хэлж мэдэхгүй байсан юм.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ялгаатай бүлгүүд албан эдийн засагт шилжихэд дэмжих ялгаатай урамшууллыг илүүд үздэгийг хөтөлбөр боловсруулахдаа анхаарах хэрэгтэй. Ажил олгогчид болон өндөр боловсролтой хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх нь албан эдийн засагт шилжих гол хөшүүрэг болно гэсэн. Өөрөөр хэлбэл тавигдах шаардлага, дүрэм журам нь хэцүү биш бол энэ бүлгийнхэн илүү хурдан албан эдийн засагт шилжих боломжтой байх магадлалтай. Ажил олгогчид болон боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарынхан төрийн худалдан авалтын боломжуудыг мөн дурджээ.

Цахим бүртгэл. Бүртгэлийг нийгмийн тусlamж авах хэрэгцээтэй өрх, хувь хүн (бүх төрлийн ажил эрхэлж байгаа) бүртгүүлэх боломжтой байдлаар хийвэл үр дүнтэй байх болно. Өөрөөр хэлбэл ингэж чадвал хямралын үед нийгмийн тусlamж авах шаардлагатай эмзэг бүлгээс эхлээд хялбаршуулсан журмаар дэмжлэг хүртэх бичил аж ахуйн нэгж, улмаар илүү өндөр шаардлага мөрдөж чадах том компани хүртэл

өргөн хүрээг хамрах боломжтой болно. Албан бус хөдөлмөр эрхэлдэг ажилтан ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бодвол засгийн газраас цар тахалтай холбоотой үзүүлсэн тусlamж, дэмжлэгээс бага үр ашиг хүртсэн болохыг судалгаагаар тогтоожээ.

Мэдээлэл түгээх. Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь хөдөлмөр эрхлэлтийн хууль, бодлого, хөтөлбөрүүдийн талаар мэдлэг дутмаг гэсэн учраас мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар мэдлэг, мэдээлэл их байх тусам ажилчдын оролцоо нэмэгдэх нь судалгааны үр дүнгээс харагдсан. Ажилтнуудын хамгийн их дурдагдсан бэрхшээл бол боловсрол, шаардлагатай ур чадвар дутмаг байх, ажлын байр хомс байх зэрэг байв. Тэд өндөр цалинтай ажил, ажлын байранд зуучлах үйлчилгээг нэмэгдүүлэхийг хүсэж байна.

Мэдээлэл түгээх хөтөлбөр боловсруулахдаа судалгаагаар илэрсэн хэв маягийг харгалзан үзэх ёстой. Боловсролын түвшин багатай иргэд хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрийн талаар бага мэдлэгтэй байх хандлагатай байсан, ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бодвол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах магадлал бага байсан. Мөн албан бус салбарт ажиллагчдын ихэвчлэн ашигладаг мэдээллийн суваг, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг (онлайн болон утас, телевиз, радио, Facebook болон WeChat) харгалзаж үзэх хэрэгтэй.

Хэрэгцээтэй тусlamж. Судалгаанаас харахад цар тахал болон цар тахлын эсрэг засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдалд асар их нөлөө үзүүлсэн байна. Тэдний ихэнх нь амьжирагааны зардлаа нөхөх хэмжээний тусlamж аваагүй гэж хариулсан байна. Хамрах хүрээний хувьд засгийн газраас үзүүлсэн дэмжлэг, тусlamжуудаас цахилгаан дулаан, усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээ хамгийн үр дүнтэй, бусад арга хэмжээний тухайд зарим бүлгүүдийн хүртсэн үр ашиг бусдаасаа илүү байсан байж талаар гүнзгийрүүлсэн шинжилгээгээр илэрсэн бөгөөд үүнийг цаашид нарийвчлан шинжилж үзүүштэй юм.

Цар тахлын үед хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнхэд бизнест нь дэмжлэг шаардлагатай, ялангуяа хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүгийн тусlamж авах шаардлагатай байна. Засгийн газраас ийм дэмжих арга хэмжээг төлөвлөхдөө хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хэрэгцээ, төсвийн боломж, хязгаарлалт, засгийн газрын бусад хэрэгцээ, зарим бизнесийн цар тахлын үед үйл ажиллагаа явуулах чадвар зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

Хувиараа бизнес эрхлэгчид бизнестээ дижитал технологийг хязгаарлагдмал түвшинд хэрэглэж байна. Цар тахлын үед бизнест туслах арга хэмжээний нэг хэлбэр бол дижитал технологийг ашиглах тодорхой сургалт байж болох юм.

► ТОВЧИЛСОН ҮГ


ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АХС	Ажиллах хүчний судалгаа
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДУ	Жижиг дунд үйлдвэрлэл
НДШ	Нийгмийн даатгалыг шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртөгийн албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХСИ	Хөдөлмөрийн судалгааны институт
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр , халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ХЭ	Хөдөлмөр эрхлэгч
ХЭБХЗГ	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
ЭЗҮА	Эдийн засгийн үйл ажиллагaa

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

1.1 АЛБАН БУС ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ


Монгол Улсын хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш гарч ирсэн харьцангуй шинэ үзэгдэл юм. Шилжилтийн үед албан бус бизнесийн үйл ажиллагаа хурдацтай өргөжсөн (Anderson, 1998). Учир нь энэ хэлбэрт нэвтрэхэд хялбар байдаг нь албан бус эдийн засгийг хурдацтай өсгөсөн нэг гол хүчин зүйл юм. Албан бус эдийн засаг нь илүүдэл ажилчдыг шингээж, өрхийн орлогыг бий болгодог. Монголын албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар цөөн хэдэн судалгаа хийгдсэн байдал. Бид энд боломжит эх сурвалжуудийн тоон өгөгдлийг ашиглан албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар ерөнхий мэдээллийг тоймлон, илэрхийлэхийг зорилоо.

► Зураг 1. Улаанбаатар хотын албан бус хөдөлмөр эрхлэлт




Эх сурвалж. 1996 оны албан бус хөдөлмөр эрхлэлтийн тоо нь Андерсон (1998), 1999 оных Бикалс нар. (2000). Үлдсэн мэдээлэл нь Үндэсний статистикийн хороо (YCS), Статистикийн мэдээллийн систем юм.

Улаанбаатар хотын албан бус ажиллагсдын тоог хэд хэдэн эх сурвалжаас авч нэгтгэснийг Зураг 1-д харууллаа. Энэ нь хөдөлмөр эрхэлдэг ажиллагсдын тоо 2017 оноос хойш сүүлийн 3 жил буурч байгаа ч ерөнхийдөө өссөн хандлагатай байгааг харуулж байна. Андерсоны (1998) үнэлгээгээр Монгол Улсын албан бус салбарт хөдөлмөрийн насны хүмүүсийн 22-32 хувь нь ажилладаг гэсэн. Зураг 2-т албан бус хөдөлмөрийн нийт ажиллагсдад эзлэх хувийг 2010-2019 оноор харууллаа. Эзлэх хувь нь вариац ихтэй хэдий ч Улаанбаатар хот болон улсын хэмжээнд тус үзүүлэлт өсөх хандлагатай байна.

Зураг 2.**► Монгол Улс болон Улаанбаатарт албан бус хөдөлмөрийн нийт хөдөлмөрт эзлэх хувь (ХАА-н бус)**

Эх сурвалж. YCSX, Статистикийн мэдээллийн сан.

Албанбуссалбартэрэгтэйчүүдилүүж ажилладаг бөгөөд сүүлийн 10 жилдэмгэгтэйчүүдтэй харьцуулахад илүү хурдацтай нэмэгдэх хандлагатай байна (Зураг 3). 2019 онд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийт ажиллагсадад эзлэх хувь эрэгтэйчүүдийн хувьд 25.6, эмэгтэйчүүдийн хувьд 19.8 хувь байна.

Зураг 3.**Албан бус хөдөлмөрийн эзлэх хувь (ХАА-н бус), хүйсээр**

Эх сурвалж. YCSX, Статистикийн мэдээллийн сан.

YCSX 2007/2008, 2010, 2015 онуудад хувиараа хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийж, тайлан гаргасан. Эдгээр тайлангийн үр дүнг 2019 оны ажиллах хүчиний судалгааны тайлантай нэгтгэн албан бус хөдөлмөр эрхлэлтийн статусыг харьцуулж үзье (Хүснэгт 1). 2007-2019 онд албан бус хөдөлмөрт хувиараа хөдөлмөр эрхлэгчид дийлэнх хувийг эзэлсээр байна. Цалин хөлстэй ажилчдын эзлэх хувь өсөх хандлагатай, ажил олгогчдын эзлэх хувь буурах хандлагатай байна.

► **Хүснэгт 1. Албан бус хөдөлмөр эрхлэгчид хөдөлмөр эрхлэлтийн статусаар (нийт дүнд эзлэх хувь)**

	2007-08	2010	2015	2019
Ажил олгогч	0.046	0.099	0.250	0.027
Бие даасан ажиллагч	0.760	0.680	0.525	0.631
Цалинтай хөлстэй ажиллагч	0.116	0.168	0.122	0.230
Бусад	0.079	0.053	0.102	0.112

Эх сурвалж. YСХ-ны хувиараа хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгаануудын тайлан болон 2019 оны ажиллах хүчиний судалгааны тайлан.

Хайнц (2010) судалгаандаа Монголын 2007/2008 ажиллах хүчиний судалгааны албан хөдөлмөр эрхлэлтийг албан болон албан бус салбараар ангилсан байдаг. Энэхүү ангиллыг 2019 онтой харьцуулбал албан бус хөдөлмөр эрхлэлтэд албан салбарын эзлэх хувь нэмэгдэж, өрхийн нэгжийн эзлэх хувь буурч байна (Хүснэгт 2). Түүнчлэн Хайнцын судалгаагаар 2007-2008 онд Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтэд ХАА-н эзлэх хувь 68.1 байжээ. Харин 2019 оны АХС-ны тайлангаас үзвэл ХАА-н эзлэх хувь 59.0 хувь байгаа нь ХАА-н салбарын эзлэх хувь буурч байгааг харуулж байна.

► **Хүснэгт 2. Албан бус хөдөлмөр эрхлэгчид (ХАА бус), үйл ажиллагааны нэгжээр (нийт дүнд эзлэх хувь)**

	2007-08	2019
Албан салбар	0.363	0.423
Албан бус салбар	0.553	0.565
Өрхийн нэгж	0.084	0.013

Эх сурвалж. Heinz (2010) судалгаа болон YСХ-ны 2019 оны ажиллах хүчиний судалгааны тайлан.

2019 оны АХС-ны тоон өгөгдөл албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өргөн мэдээлэл агуулсан байдаг. Энэхүү тоон өгөгдлийг ашиглан албан болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийн шинж чанарыг харьцуулсан мэдээллийг Хүснэгт 3-д харуулсан. Албан болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хооронд нэлээд ялгаа байгааг хүснэгт 3-ын 1, 2-р баганаас харж болно. Албан бус хөдөлмөр эрхлэгчид албан хөдөлмөр эрхлэгчдийтэй харьцуулахад эрэгтэй, боловсрол багатай, гэрлээгүй, ам бүл олонтой, орон нутагт амьдардаг байх магадлал өндөр байна. Мөн албан бус хөдөлмөр эрхлэгчид тухайн ажлаа арай цөөн жил хийсэн байдаг ба дунджаар долоо хоногт 6 цаг гаруй илүү ажилладаг. Албан бус ажиллагсдын ажлын байр нь арай цөөн ажилтантай байдаг байна.

► Хүснэгт 3. Ажилтнуудын шинж чанар

	Хөдөлмөр эрхлэлт		Албан бус хөдөлмөр эрхлэлт	
	Албан	Албан бус	Албан	Албан бус
	(1)	(2)	(3)	(4)
Эмэгтэй	0.50	0.42	0.48	0.37
Дундаж нас	38.93	39.79	36.72	42.08
Дипломын дээд болон түүнээс дээш	0.52	0.18	0.18	0.19
Гэрлэсэн	0.76	0.71	0.62	0.78
Ам булийн тоо	3.93	4.18	4.23	4.16
Улаанбаатар	0.56	0.51	0.53	0.48
Тухайн ажлыг хийсэн хугацаа	7.94	6.08	3.38	8.17
Ажлын байрны хэмжээ	4.66	2.42	3.66	1.51
Ажлын цаг	48.37	54.62	57.43	52.62

Эх сурвалж. ҮСХ-ны 2019 оны ажиллах хүчиний судалгааны тоон өгөгдөл.

Түүнчлэн албан бус хөдөлмөр эрхлэгчид ямар салбарт ажиллаж байгаагаас хамааран шинж чанар нь ялгаатай байна. Хүснэгт 3-ын 3, 4-р баганад албан болон албан бус салбарт ажилладаг байдлаар нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн шинж чанарыг харьцуулсан. Албан бус салбарт ажилладаг албан бус хөдөлмөр эрхлэгчид албан салбарынхтай харьцуулахад эрэгтэй, насаар илүү, гэрлэсэн, хөдөө орон нутагт амьдардаг байх магадлал өндөр байна. Мөн албан бус салбарт ажилладаг албан бус хөдөлмөр эрхлэгчид тухайн ажлаа илүү олон жил хийсэн байdag ба дунджаар долоо хоногт 5 цаг орчим бага ажилладаг. Албан бус ажиллагсдын ажлын байр нь арай цөөн ажилтантай байdag байна.

Дэлхий нийтэд өнгөрсөн зууны 70-аад он хүртэл албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар ойлголт төсөөлөл бүрхэг явж иржээ. Албан бус салбар хэмээх ойлголт 1970-аад оны эхэн үед үүссэн бөгөөд эдийн засгийн антропологч Кейт Харт (Keith Hart) Гана улсад хийсэн судалгааныхаа явцад албан бус салбар нь тогтмол биш бөгөөд өргөжин тэлдэг болохыг ажигласан байна. 2002 оны Олон Улсын Хөдөлмөрийн Бага Хурлаас гаргасан Зохиристой хөдөлмөр болон албан бус эдийн засгийн тухай тунхаглал нь албан бус салбарын ажилчид, тэдний үйл ажиллагаа, цар хүрээний талаарх ойлголтыг өргөжүүлэхэд томоохон ололт болсон гэж үздэг. Албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хууль тогтоомж, ажлын байран дахь аюулгүй байдлын арга хэмжээнээс орхигдсон байdag. Иймд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн харилцаа болон нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулах тодорхой бодлогын арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага байсаар байна.

Монгол Улсын хувьд Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг УИХ-ын 2006 оны 01 дүгээр тогтоолоор баталж, гурван үе шаттай хэрэгжүүлсэн: нэгдүгээр үе 2006-2008 онд, хоёрдугаар үе 2009-2011 онд, гуравдугаар үе 2012-2015 онд. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2025”, “Гурван тулгуурт

хөгжлийн бодлого”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийт ажиллагсдын хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайжруулахад нөлөөлөх зорилт, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж байгаа ч албан бус хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан бодлогын баримт бичиг одоогоор байхгүй.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаар төрөөс баримтлах бодлого, салбар дундын хамтын үйл ажиллагаа хангалттай биш байгаа нь иргэдийн хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал нь эрсдэлтэй байдалд орох, цаашлаад улсын дотоодын нийт бүтээгдэхүүн болон нийгмийн даатгалын сан, татварын орлого зэрэгт сөрөг нөлөөллийг үзүүлсээр байна.

Эдгээр асуудлыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын “Эдийн засгийг төрөлжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа”-г үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж буй үйл ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, болон хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлуудыг тодорхойлох үндэсний хэмжээний түүвэр судалгааны ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт олон улсын туршлага, статистикийн арга зүйд тулгуурлан зохион байгууллаа.

Цаашид энэхүү судалгааг тодорхой хугацааны давтамжтай тогтмол явуулах нь албан бус салбарын өөрчлөлт, албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг хэмжихийн зэрэгцээ засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээ, хөтөлбөрийн албан бус хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх боломжийг олгоно.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Тус судалгааны үр дүнгээр төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд шаардлагатай мэдээллийг бий болгох, Ковид-19 цар тахлын албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх нөлөөллийг тодруулахыг зорьсон болно.

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг ханган ажилласан:

- ▶ Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн дүр төрхийг гаргах,
- ▶ Албан бус хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн харилцааг тодорхойлох,
- ▶ Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа учир шалтгааныг нарийвчлан илрүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зүгээс албан хэлбэрт шилжих боломж, арга замыг тодорхойлох, бизнесийн ирээдүйн төсөөллийг тодруулах,
- ▶ Төр, захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого, арга хэмжээний талаарх санал бодлыг тодруулах,
- ▶ Ковид-19 цар тахлын албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх нөлөөлэл, цар тахлын үед засгийн газраас хэрэгжүүлж буй дэмжих бодлого, хөтөлбөр албан бус хөдөлмөр эрхлэгчдэд хэр хүртээмжтэй байгаа зэргийг тогтоох.

Судалгааны ач холбогдлын хувьд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нас, хүйс, мэргэжил, үндсэн үйл ажиллагаа, засаг захиргааны бүс зэрэг үзүүлэлтээр нарийвчлан тандсан мэдээлэл цуглувалсаар тэдний нөхцөл, байдлыг бодитойгоор тайлбарлах, ойлгох боломж бүрдэх бөгөөд судалгааны үр дүнг цар тахлын үед бусад судалгааны байгууллагаас хийсэн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлтэй харьцуулан үзэх боломжтой болно. Тус судалгааны арга, аргачлалын дагуу тодорхой хугацаанд давтамжит судалгаа хийснээр албан бус хөдөлмөр эрхлэгчдийн албан эдийн засагт шилжих төлөв, ажлын хэв шинж зэрэг хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг шинэчлэх боломжийг бүрдүүлэх юм.

1.3 СЭДЭВ СУДЛАГДСАН БАЙДАЛ

ОУХБ-ын гаргасан *Албан бус эдийн засаг ба зохицой хөдөлмөр: албан болох шилжилтийг дэмжих бодлогын гарын авлагыг* -д албан бус хөдөлмөр эрхлэлт бол өнөөдөр олон орны өмнө тулгарч байгаа хамгийн гол сорилт хэмээн тэмдэглэсэн байна (ILO, 2013). Албан бус эдийн засаг нь өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад аль алинд нь байдаг нийтлэг үзэгдэл юм. Гэвч албан бус эдийн засгийн мөн чанар нь тухайн улсын нийгэм эдийн засгийн бүтцээс хамаардаг тул хэмжээ, шинж чанарын хувьд эдгээр улсуудад харилцан адилгүй байдаг (Gerxhani, 2004). Хөгжиж буй болон шилжилтийн орнуудын хувьд албан бус эдийн засаг томоохон байр суурь эзэлдэг бөгөөд ажиллах хүчиний бараг тэн хагас нь албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг байна (Slonimczyk, 2014).

Монгол Улсын хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт нь 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш гарч ирсэн. Социалист системд албан бус сектор хуулиар хориотой байсан. Сүүлийн үед хийгдсэн судалгаануудаас үзвэл албан бус салбар Монгол Улсын ДНБ болон хөдөлмөр эрхлэлтэд томоохон хувь нэмэр оруулж байна. YCX-ны тооцоогоор 2015 онд албан бус эдийн засгийн үйлдвэрлэл ДНБ-ний 15.5 хувь, албан бус хөдөлмөр эрхлэлт (ХАА-н салбарыг оруулалгүй) нийт ажиллагдын 14.4 хувьтай тэнцүү байна.

Хэдийгээр албан бус салбарт ач холбогдол өгч ихээхэн анхаарч байгаа ч түүний хэмжээ, хувь нэмрийн талаарх тоон өгөгдөл, мэдээлэл ховор хомс байна. 2006 оноос хойш засгийн газар хэд хэдэн бодлогын баримт бичигт албан бус эдийн засгийн талаарх тоон өгөгдөл, мэдээллийг сайжруулах зорилт тавьсан. “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан зорилтыг хангах зорилгоор YCX-оос “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгаа”-г 2007-2008 онд зохион байгуулсан. Энэ судалгаа нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэмжээг тодорхойлох, улмаар тэдний үйлдвэрлэсэн нэмүү өртгийг хэмжих зорилготой юм. Энэхүү судалгаанаас 175.4 мяняган хүн албан бус салбарт ажилладаг бөгөөд 383.2 тэрбум төгрөгийн нэмүү өртөг үйлдвэрлэдэг гэсэн үнэлгээ хийгдсэн.

“Монгол Улсын үндэсний статистикийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд YCX бүртгэлгүй буюу далд эдийн засгийг үнэлж, энд үйлдвэрлэгдсэн орлогыг ДНБ-д оруулж тооцоолох ажлыг 2010 оноос хойш хийж ирсэн (YCX, 2013; YCX, 2020). “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” нь энэхүү төслийн нэг хэсэг бөгөөд 2010, 2015 онд хийгдсэн. Судалгааны тайланда албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ,

орлого болон дүр төрхийн талаар мэдээлэл өгдөг. 2010, 2015 онуудад 209.9, 156.3 мянган хувиараа хөдөлмөр эрхэлж байжээ. Тэдгээр ажиллагсад 2010, 2015 онуудад 1018.6, 1207.8 тэрбум төгрөгийн нэмүү өртөг үйлдвэрлэсэн байна.

Тоон өгөгдлийн хомс байдлын улмаас Монгол Улсын албан бус эдийн засгийн талаар судалгааны ажил ховор хийгдсэн байдаг. Хамгийн анхны томоохон судалгаа бол 1998 онд хийгдсэн Улаанбаатар хотын албан бус салбарын талаарх Андерсоны судалгаа юм (Anderson, 1998). Энэхүү судалгаа нь албан бус салбарын хандлага, хэмжээ, албан бусын өсөлтийн шалтгаан болон Монгол Улсын хууль эрх зүйн орчныг шинжилсэн байна. Судалгаа нь тоон өгөгдлийн хязгарагдмал байдлыг шийдэхийн тулд мэдээллийн олон тооны эх сурвалжийг ашигласан бөгөөд чанарын ярилцлага, Улаанбаатар хотын 770 албан бус ажиллагдын судалгааны тоон өгөгдөл, хөдөлмөр эрхлэлтийн талаарх албан ёсны статистик гэх мэт. Албан бус салбар нь жижиг хэмжээтэй, голчлон гэр бүлд сууринсан, албан статистикт дутуу эсвэл огт бүртгэгддэггүй бөгөөд албан ёсны бизнес эрхлэгчдэд хамаатай зохицуулалт, татварын гадна байдаг эдийн засгийн үйл ажиллагаа хэмээн өргөн хүрээтэй тодорхойлсон байна. Судлаачид албан бус салбарын хэмжээг хэд хэдэн аргачлалаар үнэлсэн. Гэхдээ албан бус секторын хэмжээнүүд хоорондоо ойролцоо гарсан бөгөөд Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны хүн амын 23-33 хувь нь албан бус салбарт ажилладаг ба өрхийн орлогын 32-38 хувийг үйлдвэрлэдэг гэсэн тооцоолол хийжээ. Албан бус хөдөлмөр эрхлэгчид өөрсдийгөө ажилтай гэж үздэггүйн улмаас Улаанбаатар хотын албан бус салбарт ажиллагдын ойролцоогоор 75-85 хувь нь албан статистикт тусгагддаггүй байна. Гэвч албан бус хөдөлмөрөөс олсон орлого Улаанбаатар хотын өрхийн 15 хувийг ядууралд өртөхөөс сэргийлдэг байна. 1990-ээд оны үеийн албан бус эдийн засгийн огцом өсөлтийн хамгийн гол шалтгаан нь тус эдийн засагт нэвтрэхэд хялбар байдал гэж судалгаанд дүгнэжээ (Anderson 1998). Албан бус салбар бүртгэл, зохицуулалттай (эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, зөвшөөрөл) холбоотой хүнд суртал багатай бөгөөд төрийн хөдөлмөрийн хууль, бодлогоос үүдэлтэй хүн ажиллуулахад гардаг өндөр зардлаас зайлсхийсэн байдаар хөдөлмөрөө зохицуулах боломжтой байdag байна.

2000 онд Бикалис ба хамтрагчид (Bikales et al., 2000) Улаанбаатар хотын албан бус салбарын судалгаа хийж, албан бус салбарыг Андерсоны (1998) судалгаатай адил өргөн хүрээнд тодорхойлсон. Тэд нэмүү өртгийн үнэлгээ хийхийн тулд эдийн засгийн 17 үйл ажиллагааны чиглэлээс албан бус эдийн засгийн 4042 нэгжийг санамсаргүй сонгон, түүвэр судалгаа хийсэн байна. Тэд албан бус салбар ДНБ-д 117.3 тэрбум төгрөгийн хувь нэмэр оруулдаг бөгөөд 50.5 мянган хүнийг ажиллуулдаг гэсэн дүгнэлт хийсэн. Судлаачдын тооцоогоор Улаанбаатар хотын оршин суугчдын 20 хувийн амьжиргааны түвшин ямар нэгэн хэмжээгээр албан бус салбарын үйл ажиллагаанаас хамаардаг гэсэн. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн гол шалтгаан нь албан бус секторт нэвтрэхэд хялбар байдал болон албан салбарын институцийн орчны сул дорийн байдал гэж үзсэн. Тэдний үзэж байгаагаар албан бус сектор нь харьцангуй бага зохицуулалттай бөгөөд авлига багатай, мөн албан сектортой харьцуулахад хөдөлмөрийн зардлыг бууруулах боломжтой байdag байна.

Өмнөх судалгаануудын дараа Morris Монгол Улсын албан бус салбарын шинж чанар, бэрхшээл, боломжийг шинжлэх зорилгоор судалгаа хийсэн (Morris, 2001).

Албан бус салбар нь өрхүүд эзэмшдэг, үйл ажиллагаа явуулдаг бизнесээс бүрдэх бөгөөд хөдөө аж ахуйн бус, бүртгэлгүй, цалинтай цөөн тооны тогтмол ажилтантай байна гэж тодорхойлсон. Судалгаанд мэргэжилтнүүдийн ярилцлага, кейс судалгаа, фокус бүлгийн ярилцлагын мэдээллийг ашигласан. Социализмын уналт, шинээр нээгдсэн зах зээлүүд, эрэлтийн шилжилт, хотжилт болон соёлын хүчин зүйлүүдийн улмаас албан бус сектор өргөжсөн гэж судлаач үзжээ. Төрийн өмчийн үйлдвэрийн газруудын хувьчлал, цомхотголын улмаас олон тооны ажиллагсад албан бус сектор руу явахад хүрсэн. Албан бус эдийн засаг шинэ бүтээгдэхүүний зах зээлүүдийг нээж, чанар үнийн өргөн сонголттой бүтээгдэхүүндээр хангаж байжээ. (Morris 2001).

Түүнчлэн, Монголын нийгмийн соёл, хувь хүний бие даасан байдал болон гэр бүлийн үнэ цэнэд ач холбогдол өгдөг нь албан бус салбарын оролцоонд нөлөөлсөн гэжээ. Албан бус салбар илүүдэл ажилчид, ажилгүйчүүд, ажиллах хүчинд шинээр орсон ажилчид болон нэмэлт ажилчдыг өөртөө шингээж авдаг бөгөөд хүмүүсийн амьжиргааг тэтгэх стратеги ч, бизнесийн боломж ч болдог. Албан секторт ажилладаг нийтлэг шалтгаанууд нь дараах байдалтай гэжээ. Үүнд:

- ▶ амьжиргаагаа тэтгэх;
- ▶ орлого олох боломж;
- ▶ уян хатан хөдөлмөрийн зохицуулалт;
- ▶ хөдөлмөрийн зардал харьцангуй бага;
- ▶ нэвтрэхэд хялбар;
- ▶ жижиг хэмжээ;
- ▶ үйлдвэрлэлийн хэрэгслийн хүртээмж; болон
- ▶ давхар ажиллах боломж.

Албан бус салбарын ажиллагсад дараах бэрхшээлтэй тулгардаг гэж дүгнэжээ. Үүнд:

- ▶ бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийн дутмаг байдал;
- ▶ төрийн байгууллагын дарамт;
- ▶ албан бус салбарын ажиллагсдын нэгдэх боломж хязгаарлагдмал;
- ▶ санхүүгийн хөрөнгө болон шинэ технологи зэрэг бүтэээмжит нөөцүүд хомс;
- ▶ бизнесийг хөгжүүлэх үйлчилгээ байхгүй;
- ▶ эрсдэл тодорхой бус байдал; болон
- ▶ нийгмийн хамгаалал байхгүй (Morris 2001).

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлсон нь. Монгол, Филиппин болон Шри Ланкын албан бус хөдөлмөр эрхлэлтийг эдгээр орнуудын ажиллах хүчиний судалгаанд суурilan шинжилсэн (Heintz, 2010). Албан бус хөдөлмөр эрхлэлт нь албан бус цалинтай ажиллагсад, албан бус хувиараа хөдөлмөр эрхлэгчид, цалин хөлсгүй оролцогч өрхийн ажилчид болон зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувь хүмүүсээс бүрдэнэ гэж тодорхойлсон. Судалгаагаар 2007-2008 онд Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлт (ХАА-н бус) 167.8 мянга бөгөөд нийт ажиллагсадад эзлэх хувь нь 26.3 байжээ. Мөн Хайнцын судалгаа Монголын хувь нийлүүлээгүй өрхийн үйлдвэрлэгчдийн талаар мэдээлэл өгдөг. Албан болон албан бус өрхийн үйлдвэрлэгчдийн хувьд нийтлэг тохиолддог бэрхшээл нь бүтээгдэхүүний борлуулалтын асуудал байна. Тухайлбал, хэрэглэгчид ховор, өрсөлдөөн ихтэй гэсэн хариулт судалгаанд хамгийн их давтагдаж байжээ. Зөвхөн тоног төхөөрөмжийн

дутагдалтай холбоотой бэрхшээлийг албан бус үйлдвэрлэгчдийн арай өндөр хувь мэдээлсэн байна. Албан салбартай харьцуулахад албан бус салбарын өрхийн үйлдвэрлэгчдийн багахан хувь нь асуудал, бэрхшээл тулгардаг гэж мэдээлж байгаа нь албан бус салбарт үйл ажиллагаа явуулах, нэвтрэхэд хялбар байгааг харуулж байна. (Heintz 2010).

Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтийн “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүтэц, төлөв байдлын судалгаа” нь тоон болон чанарын судалгааны баялаг мэдээлэл ашигласан (ХНХСИ 2013). Түүвэрт албан бус хөдөлмөр эрхэлдэг 2950 хүн хамрагдсан. Албан бус хөдөлмөр эрхлэлт нь ажил олгогчид, бие даасан ажиллагсад, албан бус салбарын ажиллагсад, өрхөд хувь нэмэр оруулагч ажилчин болон зөвхөн өөрийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувь хүмүүсийг багтаасан. Судалгаанаас 174.5 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлдэг гэж үнэлсэн. Албан бус салбарт ажилладаг нийтлэг шалтгаан нь амьжиргаагаа тэтгэх болон орлого олох боломж гэж дүгнэсэн байна. 61.0 хувь нь ажил олоход хүндрэлтэйн улмаас албан бус салбарт ажилладаг бол 47.0 хувь нь албан бус салбарын цалин орлого өндөр болохоор ажилладаг гэж хариулжээ. Morrisseyн (2001) судалгаатай адилаар гэр бүлийн үнэт зүйлс нь албан бус салбарын оролцоонд чухал нөлөөтэй байна. 24.0 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ ажиллахыг албан бус хөдөлмөр эрхлэхийн давуу тал гэж хариулжээ. Судалгаанаас үзэхэд нийгмийн хамгаалал дутагдалтай, цалин орлого тогтвортгүй байдаг нь албан бус салбарын хамгийн гол сүл талууд юм байна.

С.Галбадрах (2011) Дархан-Уул аймгийн албан бус секторын төлөв байдлыг албан бус секторт үйл ажиллагаа явуулж буй 300 гаруй хүнийг хамруулан судалсан байна. Албан бус бизнес эрхлэгчдийн дийлэнх нь (73%) худалдаа, үйлчилгээ, зуучлалын салбарт ажилладаг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа нь тогтмолжоогүй (56%) байна.

Монголын албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар сүүлийн үед хийгдсэн хэд хэдэн судалгаанд (Shatz et al., 2015) албан бус хөдөлмөр эрхлэлтийг өмнөх судалгаануудаас арай өөрөөр буюу нийгмийн даатгалд хамрагддаггүй, хүүхдийн асаргааны урьдчилгаа авдаггүй, цалин дээр нэмж ямар нэгэн шагнал, урамшуулал, нэмэгдэл авдаггүй, хүнд хортой нөхцөлийн нэмэгдэл авдаггүй цалин хөлстэй ажиллагдыг албан бус хөдөлмөр эрхлэлтэд оруулна гэж тодорхойлсон. Тэдний үнэлгээгээр, албан бус хөдөлмөр эрхлэлтийн нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь 2006-2013 онд буурсан байна. Гассман, Франсуа, Триндад нар Монголын хүн амын бүлгүүдийн хөдөлмөрийн зах зээл дээрх үр дүнг 2015 онд судалсан (Gassmann et al., 2015). Албан бус хөдөлмөр эрхлэлт (ХАА-г оруулсан) нь хувиараа хөдөлмөр эрхлэлт болон цалин хөлсгүй ажил гэсэн тодорхойлолтоор 2012 онд албан бус хөдөлмөр эрхлэлт нийт ажиллагдын 39 хувьтай тэнцүү гэж үнэлсэн. Эцэст нь 2013-2015 оны Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд богино хугацаат сургалтын үзүүлэх нөлөөллийн судалгаанд (Alzúa et al., 2019) богино хугацаат мэргэшил олгох сургалт нь залуучуудын хувиараа хөдөлмөр эрхлэлтэд богино хугацаанд эерэг нөлөөтэй гэж дүгнэжээ.

1.4 ТҮҮВРИЙН ДИЗАЙН БА АРГАЧЛАЛ

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгааг улсын хэмжээнд тоон судалгааны асуулгын аргаар зохион байгуулсан. Мөн судалгаанд чанарын судалгааны бүлгийн ярилцлагын арга, хоёрдогч мэдээллийн эх сурвалжид баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглалаа.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР, АСУУЛГЫН БҮТЭЦ

Судалгааны зорилтот эх олонлог нь хөдөө аж ахуйн бус салбарын албан бус хөдөлмөр эрхлэгчид юм. Үндэсний статистикийн хорооны 2019 оны Ажиллах хүчиний судалгааны дүнгээр ХАА-н ажилчдыг оруулахгүйгээр 195 мянган албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тодорхойлсон (ILO 2019).

Судалгаанд албан бус хөдөлмөр эрхлэлтийн шинж чанар нийслэлээс алслагдсан байдаасхамаарна гэсэн таамаглалдэвшигүүлэн судалгаандоролцогчдыг Улаанбаатар хот, Баруун, Хангай, Төв, Зүүн гэсэн таван бүсээр бүлэглэн санамсаргүй түүврээр сонгосон. Түүврийн хэмжээг тооцоходо бүс бүрт пропорцын үнэлгээ нь 95.0 хувийн итгэлийн түвшинд хамгийн ихдээ 5 хувийн алдааны хязгаартай байхаар тооцсон. Нийт түүврийн хэмжээ 3000 иргэн бөгөөд түүвэрт Улаанбаатар хотын оролцогчид хамгийн их хувийг эзэлжээ.

Түүврийн хэмжээ тооцсон томъёо:

$$n_i = \frac{N_i * X}{X + N_i - 1}$$

Эдгээр хүчин зүйлсийг харгалzan түүврийн хэмжээг хэрхэн тодорхойлсныг дараах хүснэгтэд харуулж байна.

			Бүс	N _i	Түүвэр
a	=	5%	Баруун	22 545	378
Z _{a/2}	=	1.96	Хангай	31 579	380
p	=	0.5	Төв	29 363	379
MoE	=	5%	Зүүн	12 509	373
X	=	384	Улаанбаатар	99 245	1 491
Нийт				195 241	3 000

Түүврийн хүрээг 2017 онд ХНХЯ-аас гүйцэтгэсэн “Орлогыг орлуулан тооцох аргачлалаар өрхийн амьжирагааны түвшнийг тодорхойлох судалгаа”-ны 600 мянга гаруй өрх, 2.7 сая иргэний мэдээлэл бүхий “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-аас тогтоосон. Өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч болон өрхийн аж ахуйд цалин хөлсгүй оролцогчдыг сонгож, 38.8 мянган иргэний жагсаалтыг үүсгэн, тухайн хүмүүсийн мэдээллийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийн мэдээллийн сан, хalamжийн мэдээллийн сантай тулгаж оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаарыг шинэчлэн, түүврийн хүрээг бэлтгэсэн.

СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Цар тахлын нөхцөл, хөл хорио зэргээс шалтгаалан судалгааны мэдээлэл цуглуулалтыг тоон судалгааны асуулгын аргаар утсаар мэдээллээ цуглуулсан. Утсаар мэдээлэл цуглуулж байгаа тул асуулгыг энэхүү аргад тохиромжтой энгийн, респондент ойлгож хариулахад хялбар, сунжирсан биш байхаар боловсруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах явцад асуулгыг хэрхэн бөглөх талаар зааварчилсан гарын авлагыг тусгайлан боловсруулж, ашигласан.

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид өөрсдийн онцлогтой учир бид асуулгыг хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч болон цалин хөлстэй ажилтанд ялгаатай байдлаар хариулах боломжийг бүрдүүлэхийг хичээсэн болно.

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд мэдээлэл цуглуулах болон мэдээллийг хянах судлаачдад зориулж судалгааны арга зүй, түүвэрлэлтийн талаар ойлголт өгөх, гарын авлага, асуулгын хуудастай яаж ажиллах, судалгааны мэдээлэл цуглуулалтыг хэрхэн гүйцэтгэх, хяналт хийх талаар 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Сургалтын үр дүнг дүгнэх, судалгааны асуулгыг шалгах, мэдээлэл цуглуулалтын хугацааг тооцоолох зорилгоор багийн ахлагчид болон судалгааны багийн гишүүдийн оролцоотой туршилтын судалгааг зохион байгуулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад CSPro, мэдээллийн боловсруулалтад STATA программыг ашигласан болно.

Чанарын судалгаа болон бүлгийн ярилцлагыг тухайн асуудлаар төрийн бодлого боловсруулагчид, хөдөлмөрийн харилцаанд оролцогч гурван тал, мэргэшсэн судлаач, эрдэмтдийг оролцуулан цахимаар зохион байгуулсан.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь дараах хязгаарлалтыг өөртөө агуулсан болно.

Өмнө нь дурдсанчлан түүврийн хүрээг 2017 оны Орлогыг орлуулан тооцох аргачлалаар өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааны “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-аас бэлтгэсэн тул тус судалгаанд хамрагдаагүй албан бус хөдөлмөр эрхлэгчид энэ судалгаанд хамрагдаагүй. Түүнчлэн тус мэдээллийн сангаас түүвэрлэлт хийхдээ хувиараа хөдөлмөр эрхлэгч статустай хүмүүсийг сонгосноор цалин хөлстэй албан бус хөдөлмөр эрхлэгчид цөөн орсон байж болно.

Хөдөө аж ахуйн салбар болон зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхийн цалин хөлсгүй ажиллагчид болон хаяг байршил тодорхойгүй холбогдох боломжгүй зэрэг албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тус судалгаанд хамруулаагүй.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад эрхэлж байсан бизнес үйл ажиллагаагаа явуулаагүй болон мэдээлэл өгөхөөст татгалзсан, ярилцлагын дундаас судалгааг орхиж мэдээлэл дутуу өгсөн зэрэг албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг тайланд тусгаагүй болно. Хорогдлын шинжилгээ хийж үзэхэд судалгаанд оролцоогүй иргэд боловсрол өндөр, орон сууцанд амьдардаг, баруун бүсийн болон Улаанбаатарын иргэн бөгөөд цалин хөлсгүй ажиллагч байх магадлал өндөр байсан.

1.5 СУДАЛГААНЫ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү судалгаанд албан бус хөдөлмөр эрхлэгч гэдэгт дараах ангиллын оролцогчийг авч үзсэн болно. Үүнд:

- ▶ аж ахуйн нэгж нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлгүй, төрийн өмчтэй үйлдвэрийн газар, орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, төсвийн байгууллага, төрийн бус байгууллага (ТББ), олон улсын байгууллагын ангилалд хамаарахгүй хөдөө аж ахуйн бус хувиараа хөдөлмөр эрхлэгчид;
- ▶ ажил олгогч нь тэтгэврийн сан эсвэл эрүүл мэнд/ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг төлдөргүй, ээлжийн амралт, өвчний цалинтай чөлөө авдаггүй хөдөө аж ахуйн бус ажилтан.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн энэхүү судалгаанд гэр бүлд хувь нэмэр оруулагч ажилчдыг хамруулаагүй. (Албан бус хөдөлмөр эрхлэлтийн олон улсын тодорхойлолтыг доорх хайрцаг 1-ээс үзнэ үү)

Иймд энэхүү тайланда дараах бүлгийн албан бус хөдөлмөр эрхлэгчдийг оруулсан болно. Үүнд:

- ▶ Хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, ажил олгогчоос өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч.
- ▶ Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч.
- ▶ Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч

Тус судалгаанд дараах нэр томъёог дараах байдлаар ашигласан болно. Үүнд:

Албан бус ажил олгогч. Тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч. Өөрийн хөрөнгөөрөө бие даан эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг “хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч. Хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

Шигтгээ 1

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн олон улсын тодорхойлолт

Албан бус хөдөлмөр эрхлэлт нь Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 17-р бага хурлын (ICLS) тодорхойлолтоор ажилчдын дараах бүлгүүдээс бүрдэнэ:

- ▶ албан бус салбарын өөрийн аж ахуйн нэгжид ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид;
- ▶ гэр бүлд хувь нэмэр оруулагч эсвэл цалингүй гэр бүлийн гишүүд;
- ▶ албан бус үйлдвэрлэгчдийн хоршооны гишүүд;
- ▶ зөвхөн өөрийн өрхийн эцсийн хэрэгцээнд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувиараа хөдөлмөр эрхлэгчид; ба
- ▶ албан бус ажил эрхэлдэг ажилтан. (энд, ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь хууль тогтоомжид эсвэл практикт үндэсний хөдөлмөрийн хууль тогтоомж, орлогын албан татвар, нийгмийн хамгаалал, эсвэл хөдөлмөр эрхлэлтийн тодорхой олговорууд авах эрхгүй тохиолдолд албан бус ажил эрхэлдэг гэж үзнэ).

Ажилтан. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) нь ажил олгогчийн тэтгэврийн санд оруулах шимтгэл, цалинтай ээлжийн амралт, өвчний чөлөө авах боломжийг албан бус хөдөлмөр эрхэлдэг ангилалд оруулах шалгохыг санал болгосон юм.

Ажил эрхэлдэг хүн албан байдлаараа ялгаатай хэд хэдэн ажлын байртай байж болох учраас олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 17-р бага хурлаас хувь хүн гэхээсээ ажлын байрыг дүн шинжилгээ хийх нэгж болгон ашигладаг болсон. Тус хурлаар хөдөө аж ахуйн салбарын ажилчдыг албан бус хөдөлмөр эрхлэлтийн тооцоонд хамруулах эсэх асуудлыг улс орнууд өөрсдөө шийдвэрлэхээр үлдээсэн.

Албан бус салбарын аж ахуйн нэгж /өрхийн нэгж. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлолтод албан бус салбарын аж ахуйн нэгжүүдийн тухай ойлголт багтдаг болохыг анхаарах хэрэгтэй. Албан бус салбарын аж ахуйн нэгжүүдийг бие даасан хуулийн этгээдээр байгуулагдаагүй өрхийн өмчлөлийн аж ахуйн нэгж гэж (өрхийн аж ахуйн нэгж) тодорхойлдог. Өрхийн аж ахуйн нэгжүүдийн албан ёсны аж ахуйн нэгжүүдээс ялгарах онцлог гэвэл тэд тусдаа хуулийн этгээд хэлбэрээр байгуулагдаагүй бөгөөд өрхийн өмчлөгчдөөс тусдаа данс хөтөлдөггүй юм. ОУХБ нь тухайн аж ахуйн нэгж нь албан бус салбарт байгаа эсэхийг тодорхойлохын тулд аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн мэдээлэл, улсад тайлан гаргах данс хөтөлдөг эсэх зэргийг ашиглахыг санал болгодог.

Албан бус хөдөлмөр эрхлэлт, албан бус салбар, албан бус эдийн засаг. Албан бус хөдөлмөр эрхлэлт, албан бус салбарын хөдөлмөр эрхлэлт, албан бус эдийн засгийн хөдөлмөр эрхэлт гэсэн ойлголтууд хоорондоо няйт уялдаатай боловч ижил биш юм. Албан бус салбарын хөдөлмөр эрхлэлт гэдэг нь дээр дурдсан албан бус салбарын аж ахуйн нэгжийн хөдөлмөр эрхлэлт юм. Албан бус салбарт байсан ч албан ёсны ажил эрхэлдэг байх боломжтой. Үүний нэгэн адил албан ёсны салбарт байсан ч албан бус хөдөлмөр эрхлэх боломжтой. Албан бус эдийн засгийн ажилчид нь албан бус хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарын ажилчдын хослол юм.

Ихэнх орон ОУХБ-аас санал болгосон уйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрддөг боловч албан бус хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлолтыг ялгаатай байдлаар хэрэглэдэг. Албан бус хөдөлмөр эрхэлдэг ажилчдыг ангилахад ашигладаг шалгуурын хувьд зарим ялгаа гардаг: Тухайлбал Вьетнам улсад цалинтай ээлжийн амралт, өвчний чөлөө гэхээсээ илүүтэйгээр хөдөлмөрийн гэрээний хугацааг гол шалгуур болгодог байхад Тайланداد зөвхөн нийгмийн даатгалд хамрагдсан эсэхийг л хардаг бөгөөд өөр нэмэлт шалгуур байдаггүй. Түүнчлэн ямар мэдээлэл цуглардагаас шалтгаалан албан бус салбарын аж ахуйн нэгжүүдийг хэрхэн тодорхойлох талаар ялгаа бий. Гишигүүн ихэнх орнууд ОУХБ -аас санал болгосны дагуу байгууллагын салбар, бүртгэл, хөтөлдөг дансны төрлийг хардаг бол зарим нь хэмжээ, татвар төлөлт эсвэл бусад шалгуур үзүүлэлтийг авч үздэг.

Ашигласан материал. Hussmanns (2004); Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны нарийн бичгийн дарга нарын газар, (ASEAN 2019).

БҮЛЭГ 2. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, ШИНЖ ЧАНАР


2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НИЙГЭМ-ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ ЧАНАР

Энэ хэсэгт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нас, хүйс, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, газар зүйн байршил, өрхийн шинж чанаруудаас танилцуулж байна.

Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүд (56.0 хувь) эрэгтэйчүүдээс (44 хувь) олон байв. Насны бүлгээр харьцуулбал судалгаанд оролцогсдын 70.2 хувь нь 36-55 насныхан, 17.6 хувь нь 35 хүртэл насныхан байна (Зураг 4). 46-с дээш насны бүлгийнхэнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс (тус тус 52.1 хувь, 44.1 хувь байна) илүү байв.

Зураг 4.

► Албан бус хөдөлмөр эрхлэгчид хүйс насны бүлгээр (нийт дунд хүйсээр эзлэх хувь)



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Боловсролын түвшний хувьд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 9.9 хувь нь суурь ба түүнээс бага, 51.4 хувь нь бүрэн дунд, 9.8 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 28.4 хувь нь дээд боловсролтой байна. (Зураг 5). Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү боловсролтой; эмэгтэйчүүдийн 32 хувь, эрэгтэйчүүдийн дөнгөж 25 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

► **Зураг 5.**
Албан бус хөдөлмөр эрхлэгчид боловсролоор /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Судалгаанд хамрагдагчдын 83.0 хувь нь албан ёсоор батлуулсан гэр бүлтэй, 3.0 хувь нь огт гэр бүл болоогүй, 5.6 хувь нь батлуулаагүй боловч хамт амьдардаг байна. Өрхийн ам бүлээр авч үзвэл 30.7 хувь нь 1-3, 28.6 хувь нь 4 гишүүнтэй, 24.7 хувь нь 5 гишүүнтэй, 16.0 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлийн гишүүдтэй байна.

Судалгаанд оролцогчдыг бүсээр доорх графикаас харна уу.

► **Зураг 6.**
Албан бус хөдөлмөр эрхлэгчид бүсээр /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээнээс өмнөх үед албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн сарын дундаж орлого 1.937 мянган төгрөг байсан (Хүснэгт 4). Нийт өрхийн 14.4 хувь нь 750 мянга хүртэлх, 43.5 хувь нь 750 мянгаас 1.5 сая хүртэлх, 22.5 хувь нь 1.5-2.5 сая төгрөг хүртэлх, 19.6 хувь нь 2.5 сая төгрөгөөс дээш орлоготой гэж хариулжээ.

► **Хүснэгт 4. Өрхийн сарын дундаж орлого /1,000 төг/**

Орлогын бүлэг	Өрхийн хувь
420 ба түүнээс доош	3.8
420-750 хүртэл	10.5
750-1000 хүртэл	24.0
1000-1500 хүртэл	19.6
1500-2000 хүртэл	17.1
2000-2500 хүртэл	5.3
2500 ба түүнээс дээш	19.6

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсээр харьцуулбал цар тахлын өмнөх албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн сарын дундаж орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр, харин Баруун бүсэд хамгийн бага байлаа (Хүснэгт 5).

► **Хүснэгт 5. Өрхийн орлогын бүлэг байршилаар /хувь/**

Өрхийн орлого /1,000 төг/	Байршил бүсээр					Эзлэх хувь
	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
420 буюу түүнээс доош	5.6	4.7	6.6	3.8	2.3	3.8
420-750 хүртэл	14.8	13.7	10.0	19.0	7.7	10.5
750-1000 хүртэл	28.3	22.1	25.9	24.7	23.0	24.0
1000-1500 хүртэл	20.6	21.1	18.7	20.4	19.0	19.6
1500-2000 хүрэл	14.6	13.7	17.9	15.8	18.7	17.1
2000-2500 хүрэл	4.5	7.1	3.4	0.8	6.1	5.3
2500 ба түүнээс дээш	11.6	17.6	17.4	15.5	23.2	19.6

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

2.2 АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн одоогийн эрхэлж байгаа үндсэн ажил үйлчилгээ, хугацаа, албан бус хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, ажлын байр, ажил үйлчилгээг эрхлэх давуу болон сүл тал зэрэг албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ерөнхий төлөв байдлыг нэгтгэн үр дүнг энэ дэд бүлэгт танилцуулж байна.

Судалгаанд оролцогчид албан бус салбарт дунджаар 11.8 жил ажил үйлчилгээ эрхэлж байгаа нь албан бус хөдөлмөр эрхлэлт угшмал нийгмийн үзэгдэл болсныг илэрхийлж байна. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй жилээр бүлэглэвэл судалгаанд хамрагдсан хүмүүсийн 30.5 хувь нь 16 ба түүнээс дээш жил, 34.3 хувь нь 8-15 жил, 35 хувь нь 7 хүртэлх жил албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хэмээн хариулсан байна.

Ажил мэргэжлээр нь авч үзвэл тавилга болон модон эдлэлийн мужааны ажил эрхэлж буй ажиллагчид хамгийн олон жилээр буюу дунджаар 15.3 жил эрхэлж байна (Зураг 7). Барилгын засалчин, будагчин болон оёдолчин, гар урлал, дархан зэрэг ажил үйлчилгээ эрхэлдэг албан бус хөдөлмөр эрхлэгчид дунджаар 12.1-13.8 жил ажил үйлчилгээгээ эрхэлсэн байна. Зураг 7-д мөн хөдөлмөр эрхлэлтийн статусаар харуулав. Ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчидтой харьцуулахад богино хугацаанд тухайн ажилдаа ажилласан байна.

Зураг 7.

► Цар тахлын өмнөх ажилд албан бус хөдөлмөр эрхэлсэн дундаж хугацаа / жил/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР

Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7.3 хувь нь ажилтан, 42.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 50.5 хувийг ажил олгогч бүрдүүлж байна. Ажил олгогч болон хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү, харин ажилтнуудын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү ажиглагдсан.


► **Хүснэгт 6. Ажиллагсдын хүйс, хөдөлмөр эрхлэлтийн байдал, бүс нутгаар/хувь/**

Байршил бүсээр	Ажилтан		Хувиараа ХЭ		Ажил олгогч		Нийт	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Нийт	52.2	47.8	43.2	56.8	43.8	56.2	43.5	56.48
Баруун бүс	6.5	1.8	11.9	12.7	10.5	13.0	10.7	12.20
Хангайн бүс	14.6	18.4	12.1	17.0	15.6	18.4	14.1	17.83
Төвийн бүс	13.6	16.0	18.5	19.4	10.0	13.1	13.8	15.99
Зүүн бүс	1.4	2.0	8.1	7.9	4.2	7.0	5.6	7.07
Улаанбаатар	64.0	61.9	49.4	42.9	59.7	48.4	55.8	46.91

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан бус салбарын ажилтанд 26-45 насныхан зонхицаж байгаа бол ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 36-55 насныхан зонхилох хандлагатай байгааг Зураг 8-аас харж болно.


► **Зураг 8.
Хөдөлмөр эрхлэлтийн статус насны бүлгээр /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Боловсролын түвшнээр ажил олгогчдын дунд дээд боловсролтой иргэд харьцангуй өндөр хувийг эзлэж байна (Зураг 9). Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү хувь нь дор хаяж бүрэн дунд боловсролтой байна.

► **Зураг 9.**
Хөдөлмөр эрхлэлтийн статус, боловсролоор /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 53.7 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний, 19.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн 8.7.4 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 6.3 хувь нь үйлчилгээний бусад салбарт, үлдсэн нь зочид буудал, нийтийн хоол болон бусад салбарт ажил үйлчилгээ эрхэлдэг байна. Мэдээллийг доорх хүснэгт 7-д үзүүлэв.

► **Хүснэгт 7. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагаа, бус нутгаар /хувь/**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Баруун бус	Хангайн бус	Төвийн бус	Зүүн бус	Улаанбаатар	Нийт
Боловсруулах үйлдвэрлэл	21.7	20.5	17.2	18.5	19.9	19.7
Барилга	2.6	2.4	3.2	1.3	4.4	3.5
Бөөний болон жижиглэн худалдаа	55.3	54.2	52.0	55.0	53.6	53.7
Тээвэр, агуулахын ажиллагаа	7.1	5.8	11.9	7.5	6.6	7.4
Зочид буудал, нийтийн хоол	5.6	5.8	6.6	8.3	3.8	5.0
Үйчилгээний бусад	5.8	7.9	5.0	7.8	6.1	6.3
Бусад	1.9	3.4	4.2	1.6	5.6	4.3
Нийт	100	100	100	100	100	100


Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Жижиглэн болон бөөний бараа бүтээгдэхүүний худалдаа эрхлэгчид хамгийн өндөр хувийг бүрдүүлж байгаа учраас худалдаалж буй бараа бүтээгдэхүүний төрлийг задлан авч үзлээ. Тэгэхэд худалдаа эрхлэгчдийн 37.6 хувь нь хүнсний бараа бүтээгдэхүүн, 29.3 хувь нь хувцас болон бараа бүтээгдэхүүн, 8.2 хувь нь машин тоног төхөөрөмж, сэлбэгийн худалдаа, 9.5 хувь нь гэр ахуйн бараа, барилгын материал зарж, борлуулдаг байв. Үлдсэн 25.4 хувь нь ХАА болон бусад бараа бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг гэжээ.

Барилгын ажилчдын ихэнх нь (63.9 хувь) Улаанбаатар хотод, харин зочид буудал, нийтийн хоолны салбарын ажилчдын ихэнх нь (61.5 хувь) хөдөө орон нутагт ажиллаж байна (Зураг 10). Боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, агуулахын ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа болон бусад үйлчилгээний ажилчид Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт харьцангуй жигд хуваарилагдсан байна. Мөн Улаанбаатарт бусад салбар буюу хүүхэд гэрээр харах, гэрээр багшлах, хувиараа хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, цахим төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагааны чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид олон байна.

Зураг 10.

► Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил мэргэжлийн ангиллаар жижиглэн болон бөөний барааны худалдаа эрхлэгчид (50.5 хувь), оёдол, гар урлал, дархан (13.6 хувь), зорчигч болон ачаа тээврийн чиглэлээр (7.6 хувь) ажил үйлчилгээ эрхэлдэг албан бус хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр хувийг эзэлж байна. Бусад 5.8 хувийг хүүхэд харах, асрах, хүүхдэд гэрээр багшлах, ардын уламжлалт бария засал хийх, хувиараа хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, цахим төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээ эрхлэгчид эзэлж байна.



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажил мэргэжлийн онцлогоос хамааран хүйсийн харьцаа өөр өөр байгаа юм. Жишээ нь үсчин гоо сайхны чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлж байгаа ажиллагчдын 89.6 хувь нь эмэгтэйчүүд, харин машин, механизмын засвар үйлчилгээний ажил үйлчилгээ эрхлэгчдийн 91.6 хувийг эрчүүд бүрдүүлж байна.

АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШАЛТГААН

Энэ хэсэгт албан бус хөдөлмөр эрхлэлтийн шалтгааныг хүйс, үндсэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзсэн.

Онлайн фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон экспертуудийн үзэж байгаагаар Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлт оршин байгаагийн шалтгаан нь дараах байдалтай байна:

- ▶ эдийн засгийн төрөлжилт хангалтгүй;
- ▶ албан ёсны салбарт зохистой ажлын байр цөөхөн;
- ▶ албан ёсны болгохын тулд тавьдаг шаардлага хэт өндөр;
- ▶ хууль тогтоомж, түүний хэрэгжилт хангалтгүй.

Хамгийн түгээмэл шалтгаан бол албан сектор дахь зохистой ажлын байрны хомсдол гэж үздэг. Албан салбар хангалттай хөгжөөгүй, эдийн засаг солонгорч чадаагүйн үр дагавар нь албан бус хөдөлмөр эрхлэлт юм.

Н.Аюуш /Нийгмийн халамж, хөдөлмөрийн яамны (НХХЯ) Стратеги төлөвлөлтийн газрын дарга асан/


Албан бус хөдөлмөр эрхлэлт удаан хугацаанд оршин байгаагийн шалтгаан нь эдийн засаг төрөлжсүж хөгжсүж чадаагүй байгаатай холбоотой.

М.Нямдаваа /МҮЭХ-ны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого төлөвлөлтийн газрын дарга/

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн 45.4 хувь, эмэгтэйчүүдийн 30.8 хувь нь ажилд ороход бэрхшээлтэй буюу ажил олдохгүй байсан шалтгаанаар албан бус хөдөлмөр эрхэлж байна (доорх Зураг 12). Харин эмэгтэйчүүдийн 46.5 хувь, эрэгтэйчүүдийн 31.3 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор албан бус хөдөлмөр эрхэлж буй гэсэн хариултыг сонгосон байна.

Зураг 12.

► Ажилтан албан бус хөдөлмөр эрхэлж буй шалтгаан хүйсээр (хувь, олон хариулт өгөх боломжтой)



Эх сурвалжк. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 64.1 хувь нь, ажил олгогчдын 62.2 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор албан бус хөдөлмөр эрхлэх болсон гэж хариулсан байна (Зураг 13).

Зураг 13.

► Ажил олгогч, хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхэлж буй шалтгаан /хувь/



Эх сурвалжк. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил мэргэжлээр авч үзвэл ажилчдын дийлэнх нь, ялангуяа үсчин гоо сайханчдын 73.2 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор тухайн ажил үйлчилгээг хийж байгаа гэж хариулсан. Харин зорчигч болон ачаа тээврийн ажил эрхлэгчдийн хувьд ажилд орох бэрхшээлтэй (39.1 хувь), мөн өөр боломжит хувилбар байгаагүй (33.9 хувь) шалтгааныг олонтаа тоочсон байлаа. Түүнчлэн одоо гүйцэтгэж буй ажил эзэмшсэн мэргэжилд нь нийцсэн гэж барилгын засал чимэглэл, будагчин (34.3 хувь), үсчин болон гоо сайхны чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэгчид (30.5 хувь) илүү хариулсан. Мөн ур чадварт нийцсэн ажил үйлчилгээ гэсэн шалтгааныг мужааны 43.5 хувь, оёдолчин, гар урлал, дарханы 41.5 хувь, барилгын засал чимэглэл, будагчны 40.1 хувь нь сонгожээ.

► **Хүснэгт 8. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн шалтгаан, мэргэжлээр/хувь/**

Албан бус хөдөлмөр эрхлэх шалтгаан	Бусад	Цай хоол байр буудлын ажилтан	Үсчин, гоо сайханч	Жижиглэн болон бөөний худалдаа эхлэгч	Барилгын засалчин, будагчин	Оёдолчин, гар урлал, дархан	Машин, механизмын засварчин	Мужаан, тавилга болон мөдөн эдлэлийн Зорчигч ба ачаатээврийн жолооч	Нийт	
Гэр булийн бизнес, ажил үйлчилгээ байсан	11.2	16.5	7.8	18.1	7.5	18.0	8.0	19.9	3.7	15.6
Найз нөхөд, хамтрагчид санал болгосон	2.1	1.8	2.9	3.7	2.1	1.7	3.2	1.5	4.4	3.1
Ашиг орлого сайтай	13.5	18.1	14.9	20.4	25.6	9.7	8.7	7.9	13.1	16.9
Мэргэжилд нийцсэн	34.1	14.3	30.5	3.6	34.3	26.8	12.8	19.4	17.4	13.2
Ур чадварт нийцсэн	32.9	23.4	34.2	6.5	40.1	41.5	31.3	43.5	19.7	19.6
Өөрийн хүсэл сонирхлоор	69.8	64.2	73.2	61.5	57.8	66.5	67.3	60.1	58.7	63.1
Ажилд орох бэрхшээлтэй байсан	5.0	17.0	14.5	25.6	17.1	16.5	27.7	8.7	39.1	22.2
Өөр сонголт байхгүй	9.7	18.4	13.5	28.2	15.1	17.6	26.8	20.9	33.9	24.1
Бусад	9.0	12.1	9.2	14.1	13.1	6.1	11.9	11.2	13.4	12.1

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАХ ХУГАЦАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛБЭР

Энэ хэсэгт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажлын тодорхой нөхцөлийг авч үзнэ.

Нийт ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 29.4 хувь нь түрээсийн ажлын байранд үйл ажиллагаа эрхэлдэг бол 24.4 хувь нь тусгайлсан өөрийн ажлын байранд ажил үйлчилгээ эрхэлдэг байна (Зураг 14). Харьцангуй их хувь нь мөн төвлөрсөн зах, үйлчилгээний төвд (18.3 хувь) эсвэл гэртээ (14.1) ажиллаж байв. Ажил үйлчилгээ эрхэлж буй байршилаар нь задлан авч үзвэл Улаанбаатар хотын ажил олгогчид,

хувиараа хөдөлмөр эрхлэгчид орон нутгийнхантай харьцуулахад түрээсийн байранд ажиллах хандлагатай байсан, харин орон нутгийнхан тусгайлсан өөрийн ажлын байранд ажиллах нь илүү байв (Зураг 14). Ажилтнуудын бараг тал хувь нь ажил олгогчийн ажлын байранд ажилладаг байсан бол 19.4 хувь нь тодорхой байршилгүй (зураг дээр үзүүлээгүй).

Зураг 14.
► Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байр байршилаар / хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажлын байр болон ажилласан хугацааны хооронд хамаарал ажиглагдсан (Хүснэгт 9). Ажил олгогч ба хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажилласан жил нь их байхын хэрээр өөрийн ажлын байранд ажиллах нь илүү байсан бол ажлын туршлага багатай хүмүүс түрээсийн байранд ажиллаж байна.

► Хүснэгт 9. Ажил олгогч ба хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байр, ажилласан жилээр /хувь/


Ажлын байр	1-3 жил	4-7 жил	8-11 жил	12-15 жил	16+ жил	Нийт
Тусгайлсан өөрийн ажлын байртай	14.5	23.1	26.3	28.6	25.9	24.4
Өөрийн гэрт /ажлын байртай/	17.7	13.1	13.0	10.9	15.4	14.1
Түрээсийн ажлын байранд	35.1	33.2	28.1	28.2	26.2	29.4
Харилцагчийн ажлын байранд	2.5	2.0	0.9	0.4	1.2	1.4
Гудамж, талбайд /нийтийн эзэмшлийн/	2.9	2.0	3.7	1.9	2.3	2.6
Төвлөрсөн зах, үйлчилгээний төв	14.2	16.4	17.2	22.3	20.3	18.3
Тодорхой байршилгүй	11.1	9.2	9.6	6.7	7.5	8.7
Бусад	2.0	1.0	1.3	1.1	1.2	1.3

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Нийт ажилтны 64.0 хувь нь байнгын, 26.7 хувь нь түр хугацаатай, улирлын чанартай харин 9.3 хувь нь тохиолдлын буюу цагийн ажил эрхэлдэг байна (Зураг 15). Харин эрэгтэй, эмэгтэй ажилтны хооронд мэдэгдэхүйц ялгаа харагдаж байв: эмэгтэй ажилтнуудын 81.9 хувь нь байнгын ажлын байртай бол эрэгтэйчүүдийн ердөө 47.6 хувь нь байнгын ажилтай байсан.

► Зураг 15.

Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Мөн судалгаанд хамрагдсан нийт ажилтны 39.0 хувь нь ажил олгогчтой хөдөлмөрийн ямар ч гэрээ байгуулдаггүй, 36.5 хувь нь аман гэрээ буюу тохиролцсоны үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэдэг байна. Судалгаанд оролцсон ажилтнуудын 78.9 хувь нь ажил олгогчтой ураг төрлийн ямар нэг холбоогүй байсан.

АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ

Судалгаанд хамрагдсан ажилтнуудын хамгийн их дурдсан давуу тал нь ажил амралтын цагийг зохицуулах боломжтой (37.1 хувь), ашиг орлого, цалин сайтай (23.8 хувь), ур чадварт нь тохирсон (16.8 хувь) гэж хариулсан байна (Зураг 16).

Зураг 16.**Ажилтны албан бус хөдөлмөр эрхлэхийн давуу тал /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд албан бус хөдөлмөр эрхлэлтийн давуу тал нь ажил амралтын цагийг зохицуулах боломж (58.6 хувь), ашиг (33.8 хувь), гэр бүлээрээ хөдөлмөрлөх боломж (30.6 хувь), ямар нэг гэрээ, хэлэлцээрт баригддаггүй (25.5 хувь) гэж хариулжээ (Зураг 17). Ажил мэргэжлийн бүлгээр авч үзвэл гэр бүлээрээ хамтран ажиллах нь албан бус хөдөлмөр эрхэлж байгаагийн давуу тал гэж хариулсан оролцогчдын эзлэх хувь цай хоолоор үйлчилдэг (40.9 хувь), жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчид (37.5 хувь), тавилга модон эдлэлийн мужаан хийдэг иргэдийн (34.7 хувь) дунд харьцангуй өндөр байв.

Зураг 17.**Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхлэхийн давуу тал /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажилтнуудын хамгийн их дурдсан сул тал нь нийгмийн хамгаалалд хамрагдахгүй байх (32.8 хувь), дараа нь ("бусад" гэсэн ангиллыг оруулаагүй) цалин орлого тогтмол биш (32.3 хувь), эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж муу (22.3 хувь) зэрэг байв (Зураг 18).

► Зураг 18.

Ажилтны албан бус хөдөлмөр эрхлэхийн сул тал /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ашиг орлого тогтмол биш (49.0 хувь), нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа (29.8 хувь), ажлын байрны баталгаагүй байдал (19.5 хувь) нь хамгийн том сул тал болдог гэж хариулсан байна.

Зураг 19.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан бус хөдөлмөр эрхлэхийн сул тал/хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


АЖИЛ ОЛГОГЧ, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ЗЭЭЛ, АШИГЛАЛТ, ХЭМЖЭЭ

Энэ хэсэгт ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн зээлийн хүртээмж, Эх сурвалж, ашиглалттай холбоотой асуудлыг авч үзнэ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 57.9 хувь нь бизнес эрхлэх зорилгоор зээл авсан бол 42.1 хувь нь ямар нэгэн зээлгүй байна. Зээл аваагүй иргэдийн 59.4 хувь нь зохих хэмжээний өөрийн хөрөнгөтэй тул зээл аваагүй гэсэн бол 40.6 хувь нь зээл авахад хүндрэлтэй байсан гэж хариулжээ.

Зээл авахад ямар хүндрэл байсныг тодруулбал, хамгийн их дурдагдсан нь барьцаа хөрөнгө хангалтгүй (88.5 хувь), бичиг баримт бүрдүүлэх шаардлага (85.9 хувь), зээлийн хүү өндөр (78.2 хувь) гэсэн хариу байв (Зураг 20).

► Зураг 20. Зээл авахад хүндрэлтэй байгаа шалтгаан /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Судалгааны энэ үр дүн Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал түүвэр судалгааны үр дүнтэй (Монголбанк 2018 он) нийцэж байна. Уг судалгаанд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид (ЖДҮ) зээлийн нөхцөл, тухайлбал шимтгэл, барьцаа хөрөнгийн шаардлага, баталгаа, зээлийн хэмжээ болон хүү нь хүндрэлтэй гэж үзжээ. Мөн судалгаагаар өнгөрсөн хугацаанд зээл авах эрмэлзэлтэй байсан хэдий ч зээлийн нөхцөл чанга байснаас зээл авч чадаагүй 249 ЖДҮ эрхлэгчдээс зээлийн ямар нөхцөл чанга байсныг тодруулан асуухад, дийлэнх нь зээлийн хүү өндөр (43%), зээлийн хугацаа богино (20%) болон барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус (20%) гэж хариулсан. Баримт бичгийн бүрдүүлэлт, шаардлага зээл авахад хүндрэлтэй болгодог бас нэг чухал хүчин зүйл болж байжээ.

Зээл авсан ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд зээл авах гол шалтгаан нь бизнесээ өргөжүүлэх (67.7 хувь) байсныг Зураг 21-ээс харж болно. Үүний дараа түүхий эд (30.8 хувь), тоног төхөөрөмж (15.1 хувь) худалдан авах гэсэн шалтгаан байжээ.

► **Зураг 21.**
Зээл авсан шалтгаан /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн Жижиг дунд үйлдвэрлэл ба түүний санхүүжилт судалгаанд ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад бэрхшээл учруулж буй хүчин зүйлсэд гадаад орчны таагүй нөхцөл байдал, дотоодын эдийн засгийн хүндрэл, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хөгжил сүл зэргийг тоочсон байдаг (СЗХ 2020 он).

Зураг 22-оос харахад зээл авсан ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид ихэвчлэн арилжааны банкнаас (83.7 хувь), дараа нь банк бус санхүүгийн байгууллагаас (12.1 хувь), хувь хүн, найз нөхдөөс (3.6 хувь) зээл авдаг байна. Тэд дунджаар 25.3 сая төгрөгийн зээл авчээ; энэ хэмжээ нь Энэ нь Улаанбаатар хотод (29.8 сая төгрөг) хөдөө орон нутгаас (22 сая төгрөг) өндөр байв.


► **Зураг 22.**
Зээл авсан эх сурвалжаар /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Зээл авсан ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 60.0 хувь нь зээл авснаар ажил, үйлчилгээгээ өргөжүүлсэн; 31.5 хувь нь зээл нь борлуулалтадаа нэмэгдүүлсэн; 20.6 хувь нь энэ зээл санхүүгийн хүндэрлийг даван туулахад тусалсан гэж хариулжээ.

3ураг 23.
Авсан зээлийн ажил үйлчилгээнд үзүүлсэн нөлөө /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

2.3 АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НӨХЦӨЛ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА


Энэ хэсэгт албан бус хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөрийн харилцааг судалж үзсэн. Хөдөлмөрийн харилцааны хяналт хязгаарлагдмал эсвэл огт хяналтгүй бүртгэлгүй ажлын байранд ажилладаг тул албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөрийн харилцааг судлах нь нэн чухал юм.

АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого 1.709 мянган төгрөг байна (орлого гэдэгт ажилтнуудын хувьд цалин, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд цэвэр орлого хамаарна). Орлого нь гэхдээ хөдөлмөр эрхлэлтийн статусаар ихээхэн ялгаатай байна (Зураг 24). Сарын орлого нь ажил олгогчдын хувьд хамгийн өндөр буюу 2,131 мянган төгрөг, дараа нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид (1,330 мянган төгрөг), ажилтнуудын сарын орлого арай бага (979 мянган төгрөг) байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд ялгаа мөн ажиглагддас (Зураг 24). Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс дунджаар илүү орлого олж байсан бөгөөд энэ нь ажилтнуудын хувьд илүү тод ажиглагдсан (эмэгтэйчүүдийн орлого нь эрэгтэйчүүдээс 36 хувиар бага). Гэхдээ тус судалгаагаар тооцоолсон дундаж орлого нь Үндэсний Статистикийн Газраас 2020 оны дөрөвдүгээр улиралд тооцоолсон улсын дундаж цалин буюу 1,328,100 төгрөгөөс нэлээд өндөр байгааг анхаарууштай.¹

¹ <http://www.1212.mn>.

► **Зураг 24.**
Сарын дундаж цалин, хөдөлмөр эрхлэлтийн статусаар /1,000 төг/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Нийт ажилтнуудын 58.7 хувь нь тогтсон хуваарийн дагуу цалин хөлс авдаг, 41.3 хувь нь цалингийн тогтсон хуваарьгүй байна.

Улаанбаатарт хамгийн өндөр буюу 1.950 мянган төгрөг, хангайн бүсэд хамгийн бага байгаа ч хүйсээр нь авч үзвэл баруун бүсэд эмэгтэйчүүдийн дундаж орлого, зүүн бүсэд эрэгтэйчүүдийн дундаж орлого хамгийн бага байна.

► **Зураг 25.**
Сарын дундаж цалин, бүс, хүйсээр /мян.төг/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


Цагийн болон захиалгат ажил эрхэлдэг уул уурхай, техник мэргэжлийн чиглэл, санхүү, даатгал, ус хангамж, боловсрол зэрэг салбаруудыг бусад салбар гэсэн ангилалд

нэгтгэсэн бөгөөд хөдөлмөрийн хөлсний үнэлгээ өндөр байдаг нь энэ салбарын дундаж цалинд нөлөөлсөн байх магадлалтай. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл бусад салбар гэсэн ерөнхий ангиллыг хасаад тооцоход, дундаж орлого нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбарт хамгийн өндөр буюу 2,058,000 төгрөг байсан (Зураг 26).

Сарын дундаж орлогыг ажил мэргэжлээр харьцуулан авч үзэхэд машин механизмын засвар үйлчилгээний ажил эрхэлдэг ажил олгогчдын сарын дундаж орлого 2.481 мянган төгрөг, жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дундаж орлого 1.431 мянган төгрөг, зорчигч ба ачаа тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчдийн дундаж орлого 1.394 мянган төгрөг байна.

► Зураг 26.

Сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагаагаар /1,000 төг/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

ДОЛОО ХОНГОЙН АЖЛЫН ЦАГ БА ӨДӨРТ АЖИЛЛАСАН ДУНДАЖ ЦАГ

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 60 хувь нь ажлын тогтсон хуваарийн дагуу ажилладаг бөгөөд 7 хоногт дунджаар 58.09 цаг ажиллаж байгаа нь (хүснэгт 10) Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1-д заасан ердийн өдрийн ургэлжлэх хугацаанаас дунджаар 18 цаг илүү байна. Ажил олгогчдын ажлын цаг дунджаар хамгийн их (60 цаг), дараа нь ажилтнууд (56.9 цаг), хувиараа хөдөлмөр эрхлэгчид (56.1 цаг) орж байна. Эрэгтэйчүүдийн ажлын цаг эмэгтэйчүүдийнхээс дунджаар арай олон (тус тус 58.4 ба 57.9 цаг) байсан. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд өөр, тэдний дунд эмэгтэйчүүд арай илүү цагаар ажилладаг.

► **Хүснэгт 10. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7 хоногт ажилласан дундаж цаг**

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
Ажилтан	59.17	54.30	56.85
Ажил олгогч	60.58	59.55	60.00
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	55.72	56.32	56.06
Нийт	58.41	57.85	58.09

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

► **Хүснэгт 11. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7 хоногт ажилласан ажлын өдөр, мэргэжлээр**

Ажил мэргэжил	1-4	5	6	7	Нийт
Цай хоол байр буудлын ажилтан	4.9	11.1	5.4	5.7	6.2
Үсчин, гоо сайханч	1.6	4.8	4.4	4.1	4.1
Жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгч	23.4	25.5	66.7	47.3	50.5
Барилгын засалчин, будагчин	6.8	5.3	2.8	4.6	4.1
Оёдолчин, гар урлал, дархан	11.6	18.6	10.7	14.7	13.6
Машин, механизмын засварчин	4.6	3.1	1.4	4.5	3.2
Мужаан, тавилга болон модон эдлэлийн	5.1	7.6	2.9	5.6	4.9
Зорчигч ба ачаа тээврийн жколооч	30.8	12.8	2.3	7.8	7.6
Бусад	11.3	11.4	3.4	5.7	5.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь ажлын байрны нөхцөлөө ердийн гэж тодорхойлсон (Улаанбаатарт 59 хувь, хөдөө орон нутагт 62.5 хувь). Улаанбаатарт 20 гаран хувь, орон нутагт 18.7 хувь нь хүйтэн сэргүүн, Улаанбаатар хотын албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 18 хувь, орон нутгийнхны 17.8 хувь нь халуун нөхцөлд ажилладаг гэжээ.

► **Зураг 27.**
Ажлын байрны нөхцөл, байршилаар /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Зураг 27-д үзүүлээгүй ажил мэргэжлийн хэв маягт дараах зүйл орсон. Үүнд:

- ▶ барилгын засалчин, будгийн ажил эрхлэгчдийн 48.6 хувь, зорчигч ба ачаа тээврийн жолооч нарын 34.6 хувь нь ажлын байрны нөхцөл нь хүнд гэж үзсэн;
- ▶ тавилга модон эдлэлийн мужааны ажил эрхлэгчдийн 35.9 хувь, машин, механизмын засварчдын 34.6 хувь, барилгын засалчин, будагчин нарын 33.7 хувь нь ажлын байраа тоосжилттой гэж тодорхойлсон; ба
- ▶ цай хоол байр буудлын ажил үйлчилгээ эрхлэгчдийн 36 орчим хувь нь халуун нөхцөлд ажиллаж байна гэжээ.

Төвлөрсөн зах, түрээсийн байр, бизнесийн тодорхой байр гэсэн гурван төрлийн ажлын байрны нөхцөлийг Зураг 28-д харьцуулан харууллаа. Ерөнхийдөө төвлөрсөн зах ердийн ажлын нөхцөлтэй байх магадлалтай хамгийн бага, хүйтэн сэргүүн эсвэл халуун гэж тодорхойлогдох магадлал өндөр байв.

► **Зураг 28.**
Түрээсийн болон төвлөрсөн зах тусгайлсан ажлын байрны нөхцөл /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Үйлдвэрлэлийн осол гэмтлийн тохиолдол бага, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дөнгөж 3.6 хувь нь ямар нэгэн осол гэмтэлд өртөж байсан гэж хариулсан бол 95.1 хувь нь тийм явдал гарч байгаагүй гэсэн байна.

Осол гэмтэл өртсөн гэж хариулсан иргэдийн 55.9 хувь нь өнгөц гэмтэл, ил шарх, 25.5 хувь нь хугарч гэмтэж байжээ (Зураг 29). Тухайн гэмтэлд биеийн дээд мөч буюу гар хуруугаа гэмтээх явдал хамгийн элбэг (44.1 хувь) тохиолддог байна. Гэмтэж бэртсэн ч 52.1 хувь нь эрхэлж байгаа ажил үйлчилгээгээ зогсоогоогүй үргэлжлүүлсэн байна.


► **Зураг 29.**
Осол гэмтлийн төрлөөр /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

► **Зураг 30.**

Осол гэмтэлд өртсөн үед эмчилгээний зардал гаргасан байдлаар /хувь/



■ Даатгал ■ Бусад эх сурвалж ■ Ажил олгогч ■ Хувь хүн өөрөө

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Миний бодлоор бүртгэлгүй байдаг учраас хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зөрчил далд хэлбэртэй байдаг байх.

Э.Энхжаргал /Монголын Ажил Олгогч Эздийн Холбооны газрын дарга/

Албан бус салбарын ажлын орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, осол гэмтэл бүгд бүртгэлгүй явж байгаа.

Н.Аюуш /НХХЯ-ны Стратеги төлөвлөлтийн газрын дарга асан/

Бичил уул уурхайг судалж байхад албан болон албан бус гэсэн хэсэгтэй. Нөхөрлөл хоршоо гээд бүртгэлтэй нь татвараа төлөөд явдаг.


Бүртгэлтэй хэсэг 1/10 нь байна. Үлдсэн хэсэг нь албан бусаар хөдөлмөр эрхэлж хөдөлмөр хамгаалал, ажлын байрны нөхцөл гэсэн ойлголтыг бараг мэддэггүй.

П.Цэрэнбазар /МУИС-ийн багши/

АЖЛЫН БАЙРАНД ГАРАХ МАРГААН, ДАРАМТ

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 8.5 хувь нь ажил дээр нь ажлын байрны маргаан гарч байсан гэж хариулсан. Тэдний 47.6 хувь нь цалинтай, 34.4 хувь нь түрээсийн төлбөртэй, 13.2 хувь нь ажлын орчин нөхцөлтэй холбоотой маргаан байна. (Зураг 31).

► **Зураг 31.**
Хөдөлмөрийн маргааны шалтгаан /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

2.4 НЭМЭЛТ СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭ

Бусад тайлбарлагч хувьсагчдын нөлөөг хянасны дараа хамааран хувьсагчтай хүчтэй хамаарал бүхий тайлбарлагч хувьсагч аль нь байна вэ гэдгийг мэдэх нь илүү ач холбогдолтой.²

Бид энэ тайланда шинжилгээний техникийн нарийвчилсан зүйлийг оруулаагүй, зөвхөн гол үр дүн, түүний бодлогод нөлөөлөх үр дагаврыг танилцуулж байна. Хамааран хувьсагчийг хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үйл ажиллагаанаас хамааруулан регрессийн шинжилгээ хийсэн.

- **Ажилтнуудын цалин хөлс.** Ажилтнуудын цалин хөлс нь хүйс, насны бүлэг, боловсролын түвшингээс хамаардаггүй зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягтуялдаатай байдаг. Тодруулбал, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр зэрэг салбарын ажилтнууд бөөний болон жижиглэнгийн худалдаа, засвар (худалдаа, засвар) -ынхнаас хамаагүй их орлого олдог нь тогтоогдсон. Түүнчлэн тээврийн салбарын ажилтнууд хүйс, насны бүлэг, боловсролын түвшнийг хянасны дараа худалдаа, засварынхнаас 62 хувиар, барилгын салбарынхнаас 32 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхнаас 20 хувиар илүү цалин авдаг гэж тооцоологдсон. Өөрөөр хэлбэл, худалдаа, засварын салбарын ажилтнууд тээвэр, барилга, аж үйлдвэрийн салбарынхнаас хамаагүй бага орлого олдог ажээ. Бусад салбар (зочид буудал, байр, бусад үйлчилгээ, бусад) дахь ажилтнууд худалдаа, засварын салбарынхнаас төдийлөн ялгаагүй цалинтай байсан.

² Үүнийг регресс шинжилгээний аргаар хийж болдог. Хамааран хувьсагчийн шинж чанараас шалтгаалан бид регресс шинжилгээний хэд хэдэн терлийг ашиглах боломжтой. Цалин, ажлын цаг зэрэг тасралтгүй хувьсагчийг авч үзэхдээ хамгийн бага квадратын аргын (OLS) регрессийг ашиглах нь тохиромжтой. Логит регрессийг хоёр боломжит утгатай хувьсагчийг авч үзэхдээ (тухайлбал "албан ёсны болох сонирхолтой" эсвэл "сонирхолгүй") ашигладаг. Харин категоричилсон болон ердийн эрэмбийн хувьсагчийг авч үзэхдээ (жишээлбэл цар тахлын эсрэг арга хэмжээний нөлөөллийг хэмжээг судлахдаа) ординал регрессийн аргыг ашиглаж болно.

- ▶ **Ажилтнуудын ажлын цаг.** Нийт ажилтнуудын ажлын өдөр дунджаар 9.7 цаг байгаа нь хэт өндөр байна. Ажлын цагийг багасах нь хөдөлмөрийн дутуу ашиглалт гэхээсээ ажиллах нөхцөл сайжруулах үндэс болно. Ажилтнуудын ажилласан цаг нь боловсролын түвшин болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааралтай байна. Тухайлбал бакалаврын зэрэгтэй ажилтан дунд болон түүнээс бага боловсролтой ажилтнаас 3.3 цагаар бага, харин тусгай мэргэжлийн боловсролтой ажилтан бараг 2 цагаар бага ажилладаг нь тогтоогдсон. Үүний зэрэгцээ боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд худалдаа, засварын ажилтнуудаас бараг нэг цагаар бага ажилладаг байна.
- ▶ **Ажилтнуудын цалингийн болон ажлын хуваарийн тогтмол байдал.** Эмэгтэй ажилтан эрэгтэй ажилтантай харьцуулахад цалин, ажлын хуваарь тогтмол байх магадлал илүү өндөр байв. Хүйсээс гадна эдийн засгийн үйл ажиллагааны салбар гол нөлөөлөгч хүчин зүйл байсан. Барилга, тээврийн салбарын ажилтнууд цалин хөлс, ажлын хуваарь тогтмол байх магадлал нь худалдаа, засварын ажилчидтай харьцуулахад хамаагүй бага байсан юм.
- ▶ **Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ашиг орлого.** Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого нь хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байна. Эмэгтэйчүүдийн ашиг орлого эрэгтэйчүүдтэй харьцуулахад дунджаар 19 хувиар бага байна. Ашиг орлого нь наснаас сөрөг хамааралтай байсан ба 50 ба түүнээс дээш насынхны орлого хамаагүй бага байсан юм. Боловсролын түвшний хувьд бүрэн бус дундаас бага боловсролтой хүмүүстэй харьцуулбал бакалаврын болон түүнээс дээш боловсролтой бол 45 хувиар, тусгай мэргэжлийн боловсролтой бол 26 хувиар, бүрэн дунд боловсролтой бол 13 хувиар илүү байсан. Худалдаа, засварын салбартай харьцуулахад бусад үйлчилгээ (38 хувиар бага), тээврийн (16 хувиар бага) салбарт ашиг орлого нэлээд доогуур байсан бол барилга (20 хувиар илүү), зочид буудлын (20 хувиар илүү) салбарын ашиг нэлээд өндөр байв.
- ▶ **Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын цаг.** Нийт ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өдрийн дундаж ажлын цаг 9.3 байгаа нь мөн л өндөр байна. Худалдаа, засварын салбартай харьцуулахад тээвэр (1.23 цагаар илүү), барилга (0.91 цагаар илүү), зочид буудлын (0.45 цагаар илүү) салбарын ажиллагсдын ажилласан цаг нь харьцангуй өндөр байв. Харин бусад үйлчилгээ (0.57 цагаар бага), боловсруулах үйлдвэрлэл (0.31 цагаар бага), бусад салбарынхны (0.48 цагаар бага) ажилласан цаг нэлээд бага байв. Ахмад настай ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид арай бага цагаар ажилладаг (0.57 цагаар бага). Эмэгтэйчүүдийн хувьд ажлын цаг мөн арай бага байсан.
- ▶ **Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын цагийн хуваарийн тогтмол байдал.** Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын цагийн хуваарь тогтмол байх нь хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байна. Эрэгтэйчүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүд ажлын цагийн хуваарь тогтмол байх магадлал илүү өндөр. Насны бүлгээр авч үзвэл 40-49 насынхан ажлын цагийн тогтсон хуваарътай байх магадлал өндөр. Боловсролын түвшин нэмэгдэх тутам ажлын цагийн тогтсон

хуваарьтай байх магадлал өндөр байв. Тээвэр, боловсруулах үйлдвэрлэл, барилга болон бусад салбарын ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид худалдаа, засварын салбарынхнаас тогтмол ажлын цагийн хуваарьтай байх магадлал бага байсан.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээр хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд, харин ажилтнуудын ихэнх эрэгтэйчүүд байна. Ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс залуу байсан бол ажил олгогчид илүү өндөр боловсролтой байх хандлагатай байв. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол тавны нэг орчим нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нэлээд хувийг эзэлдэг бусад салбаруудад тээвэр, агуулахын үйл ажиллагаа, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбар орсон.

Албан бус хөдөлмөр эрхлэлт нийгмийн угшmal үзэгдлүүдийн нэг болжээ. Албан бус хөдөлмөр эрхэлсэн дундаж хугацаа 11.8 жил, 64.8 хувь нь ажлын байрандаа найман жилээс доошгүй хугацаанд ажилласан байв.

Хувийн хүсэл сонирхол, албан ёсны ажил олоход тохиолдох бэрхшээл, өөр сонголтгүй байх зэрэг нь албан бус хөдөлмөр эрхлэх хамгийн түгээмэл шалтгаан болсон байна. Ялангуяа эмэгтэйчүүд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаанаа өөрийн хүсэл сонирхолтой холбон тайлбарлаж байсан бол эрэгтэйчүүд ажил олоход хүндрэлтэй байна гэжээ. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь өөрсдийн хүсэл сонирхлоос болж албан бус хөдөлмөр эрхэлж байгаа гэж хариулжээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд түрээсийн эсвэл өөрийн эзэмшдэг ажлын байранд ажиллах нь түгээмэл байв. Байршилын хувьд зарим ялгаа байсан. Улаанбаатар хотод тэдний олонх нь түрээсийн байранд ажилладаг бол орон нутагт өөрсдийн эзэмшлийн ажлын байранд ажилладаг.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь байнгын ажилтай боловч хүйсийн ялгаа их байгаа нь ажиглагдсан. Жишээ нь: эмэгтэйчүүдийн 82 хувь нь байнгын ажилтай гэж мэдээлсэн бол эрэгтэйчүүдийн хувьд дөнгөж 39 хувь байна.

Судалгаанд оролцогч албан бус салбарт ажиллагчид ажил олгогчтой албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй бөгөөд 75.5 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй эсвэл ажил олгогчтойгоо зөвхөн амаар тохиролцон ажилладаг.

Ажилтнууд албан бус хөдөлмөрийн давуу талыг уян хатан ажлын цагтай, цалин сайтай, ур чадварт нь тохирдог гэсэн бол сүл талыг нийгмийн хамгаалалд хамрагдахгүй байдал, цалин хөлс тогтвортгүй, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу байгаа гэжээ. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд уян хатан ажлын цаг, ашиг орлого, гэр бүлийнхэнтэйгээ ажиллах боломж зэргийг давуу тал гэсэн. Харин орлого тогтвортгүй, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй, ажлын байрны баталгаа байхгүй зэрэг нь сүл тал гэж дурджеэ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн зургааны нэг нь зээлийн барьцаа хүрэлцэхгүй, албан ёсны шаардлага хатуу, хүү өндөр зэргээс шалтгаалан зээл авч

чадаагүй. Зээл авч чадсан ихэнх нь албан ёсны эх сурвалжаас (арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага) зээл авсан байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цэвэр орлого 1,709,000 төгрөг байсан, гэхдээ ажил олгогчдын хувьд орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилтнуудтай харьцуулахад өндөр, мөн Улаанбаатар хотод бусад бус нутгийнхаас өндөр байлаа. Ажилтнуудын тавны хоёр нь тогтсон хуваарийн дагуу цалин авдаггүй гэжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид урт цагаар ажиллаж байна. Тэд долоо хоногт дунджаар 58.1 цаг ажилладаг нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цагийн ажлын долоо хоногоос хавьгүй илүү байна.

Мэргэжлээс шалтгаалах осол гэмтлийн тухай цөөн тооны мэдээлэл ирсэн, мөн ажилтнуудын арван хоёрны нэг нь л цалин хөлс, түрээсийн төлбөртэй холбоотой ажлын байрны маргаантай тулгарсан гэжээ.

Нэмэлт статистик дүн шинжилгээгээр дараах зүйлийг харуулав. Үүнд:

- ▶ ажилтнуудын цалин нь эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт холбоотой байсан бөгөөд боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээврийн салбарт цалин нэлээд өндөр байсан;
- ▶ ажилтнуудын ажилласан цаг нь боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байсан бөгөөд илүү сайн боловсролтой болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудын ажлын цаг мэдэгдэхүйц бага байсан;
- ▶ ажилтнуудын дунд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү тогтмол цалинтай, тогтмол ажлын хуваарьтай байх магадлал өндөр, барилга, тээврийн салбарт ажилладаг иргэд худалдааны салбарынхантай харьцуулахад тогтмол цалин, тогтмол ажлын цагийн хуваарьтай байх магадлал баатай байсан;
- ▶ ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд эмэгтэйчүүд, ахмад насны ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролтой болон тээврийн салбарт ажиллагсдын ашиг бага байсан; харин барилга, байр сууцны салбарын хувьд ашиг орлого илүү өндөр байсан;
- ▶ ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд тээвэр, барилга, байр сууцны ажилчид илүү олон цагаар ажилласан бол эмэгтэйчүүд болон 60 ба түүнээс дээш насныхан арай бага цаг ажилласан;
- ▶ ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүд болон илүү өндөр боловсролтой иргэдийн хувьд тогтмол ажлын хуваарьтай байх магадлал илүү өндөр, харин тээвэр, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарт бага байдаг.

БҮЛЭГ 3. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙГ АЛБАН ЭДИЙН ЗАСАГ РУУ ШИЛЖИХИЙГ ДЭМЖИХ: БЭРХШЭЭЛ БА БОЛОМЖ

Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх нь тухайн хөдөлмөр эрхлэгчдийн ч, улс орны эдийн засгийн өсөлт хөгжилд ч ач холбогдолтой. Тиймээс албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн нэгдсэн бодлого, дэмжлэгээр албан хэлбэрт шилжүүлэх, аливаа эрсдэлээс хамгаалах суурь нөхцөлийг бүрдүүлэх нь нэн чухал. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Женевд хуралдсан 104-р чуулганаар сая сая ажилчин, эдийн засгийн нэгжийг албан бус байдлаас гарч, албан эдийн засагт шилжихэд туслах Олон улсын хөдөлмөрийн шинэ хэм хэмжээг баталсан байdag. Чуулганаар дэлхийн ажиллах хүчний талаас илүү хувь нь албан бус эдийн засагт хамрагдаж байгааг цохон тэмдэглэж, энэ нь эдийн засгийн хүрээнд дараах асуудлыг бий болгож байна гэж дүгнэжээ. Үүнд:

- ▶ чанартай ажил эрхлэх хангалттай боломжийг бүрдүүлж чадахгүй байх,
- ▶ нийгмийн хамгаалал хангалтгүй байх,
- ▶ нийгмийн яриа хэлцэлд саад учруулдаг,
- ▶ бага бүтээмжийн эх сурвалж болдог,
- ▶ аж ахуйн нэгжийн тогтвортой хөгжилд томоохон саад тогтор болох зэрэг.

Энэ хэсэгт дараах асуултуудыг авч үзнэ. Үүнд:

- ▶ албан бус хөдөлмөр эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл;
- ▶ эдгээр ажилчдын албан эдийн засагт шилжих боломж, хүсэл сонирхол.

3.1 АЛБАН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, БОЛОМЖУУД

Хорин жилийн өмнөх судалгаанд Монгол дахь албан бус салбарт тулгардаг бэрхшээлүүдийг дурдсан байdag (Моррис 2001). Үүнд:

- ▶ түүхий эд, нийлүүлэлтийн өндөр өртөг;
- ▶ хэрэглэгчдийн худалдан авах чадвар бага;
- ▶ засгийн газрын шахалтаас үүдэлтэй хүндрэл, бэрхшээл;
- ▶ түүнчлэн хулгай, залилан мэхлэлт зэрэг болно.


Харин тус албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас дараах үр дүн гарсан. Үүнд:

- ▶ ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 12.8 хувь нь татвар, хураамжтай холбоотой асуудалтай тулгарсан;
- ▶ 11.4 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагуутай холбоотой асуудалтай тулгарсан;
- ▶ 62.3 хувь нь ямар ч асуудалтай тулгараагүй гэж хариулжээ.

Хүндрэл бэрхшээл ажил мэргэжлээс хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал хоол, цай, байр, буудлаар үйлчилдэг албан бус хөдөлмөр эрхлэгчид мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой бэрхшээлийг голчлон дурдсан бол үсчин, гоо сайханч, жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчид татвар, төлбөр, ажлын байр түрээслүүлэгч, эзэмшигчтэй холбоотой бэрхшээл ихэнхдээ тулгардаг гэжээ. Харин зорчигч болон ачаа тээвэр эрхлэгчдийн хувьд цагдаа хүчний байгууллагатай холбоотой бэрхшээл тулгардаг гэсэн.

► Зураг 32.


Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Эрхэлж буй бизнесийнхээ талаар өөдрөг үзэлтэй байх нь ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хооронд харилцан адилгүй байна. Ажил олгогчид илүү өөдрөг байх хандлагатай байсан бөгөөд 79.0 хувь нь бизнесээ ирээдүйтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн бол хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 63.7 хувь нь ирээдүйтэй гэжээ (Зураг 33). Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 26.9 хувь нь бизнесээ эргэлзээтэй гэж үзсэн бол ажил олгогчдын 16.3 хувь нь ийм бодолтой байна. Багахан хувь нь (хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд илүү өндөр) бизнесээ ирээдүйгүй гэж хариулжээ.

► **Зураг 33.**
Эрхэлж буй ажил, бизнес нь ирээдүйтэй эсэх, статусаар /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Өөдрөг байдлыг нь ажилласан жилээр харьцуулбал сонирхолтой дүр төрх харагдсан: ажилласан хугацаа нь бага байвал илүү өөдрөг, харин жил ахих тутам эрхэлж буй ажил, бизнесийнхээ ирээдүйд итгэлгүй байх хандлага ажиглагдсан (Хүснэгт 12).

► **Хүснэгт 12. Ажил, бизнес нь ирээдүйтэй эсэх, ажилласан жилээр /хувь/**

	1-3	4-7	8-11	12-15	16+
Ирээдүйтэй	75.3	73.5	72.5	71.3	69.9
Эргэлздэг	18.6	19.9	21.9	22.0	22.1
Ирээдүйгүй	6.1	6.7	5.6	6.8	8.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

АЛБАН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ СОНИРХОЛ

Онлайн фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон экспертуудийн үзэж байгаагаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хэлбэрт шилжүүлэхэд янз бүрийн арга хэмжээ авч болно. Үүнд:

- Макро түвшинд эдийн засгийн төрөлжилт, албан ёсны салбарын өсөлт нь албан бус ажилчдыг албан ёсны салбарт шилжүүлэхэд тусална.
- Микро түвшинд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дэд бүлгүүдэд анхаарлаа хандуулж, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг ойлгож, эдгээр бэрхшээлийг даван туулахад туслах дэд бүлгүүдэд тохирсон тусгай хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар албан ёсны болгоход тодорхой хугацаа шаарддаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал бөгөөд ингэснээр урт хугацааны зорилгоо тодорхойлох, түүнийгээ биелүүлэхэд хүргэх завсрын үе шатуудыг тодорхойлох нь чухал юм.

“ХНХЯ-аас Халамжсаас хөдөлмөрт гэсэн зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна. Иргэдийн хөдөлмөр эрхлэх үндсэн эрхийг хангаж байж халамжид хамрагдагсдын тоог бууруулна гэж харж байна.”

Б.Алтантулга /ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга/

“Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тухайн хүн ямар секторт ажиллаж байгаагаас үл хамааран хөдөлмөрийн хуулийн хамгаалалтад хамрагдах зарчмыг баримталсан. Бид хөдөлмөрийн хуулийн хамрах хүрээгээ өргөжүүлж ажиллагсдын суурь дөрөвөн эрх буюу эвлэлдэн нэгдэх эрх, албадан хөдөлмөр эрхлэлтээс ангид байх, хүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хориглох, ялгаварлан гадуурхалтай холбоотой эрхийг суурь зарчим болгож оруулсан байгаа.”

Ш.Маяа /ХНХЯ-ны ахлах шинжээч/

“Төрөөс баримтлах бодлого маш тодорхой байх хэрэгтэй. Аль салбарт, ямар арга хэмжээг хэнд зориулж хэрэгжүүлээд, ямар үр дүнд хүрэх вэ гэдэг нь тодорхой байгаад хөдөлмөрийн харилцаанд оролцогчид бүрэн мэдээлэлтэй байх хэрэгтэй болов уу.”

Ц.Отгонтунгалааг /МУЭХ-ны Хөдөлмөрийн хяналт, хуулийн бодлогын газрын дарга/

“Төрөөс албан бус салбарт баримтлах бодлого гаргах нь зөв. Гэхдээ энэ баримт бичгийг боловсруулахдаа олон талын оролцоог хангах, салбар дундын уялдаа холбоог сайжруулж, иновчтой бодлогыг гаргаж хэрэгжүүлэх, боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагуудын чадварыг сайжруулах хэрэгтэй.”

Э.Энхжаргал /Монголын Ажил Олгогч Эздийн Холбооны газрын дарга/

“Албан бус салбарт ажиллагчдыг нэг цаг хугацаанд, нэг цохилтоор албан сектор руу шилжүүлж чадахгүй. Асуудал бүрийг судалж үзээд хамгийн нэн тэргүүний асуудлаас нь ээлж дараатайгаар шийдэх замаар хийх болно. Ингэхдээ бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид дараах хандлагыг анхааралдаа авах ёстой:

- нэгд, албан салбарт дөхсөн хэсгийг албан салбарт шилжүүлэх
- хоёрт, албан салбарт шилжих болоогүй хэсгийг эхлээд нийгмийн хамгаалалт хамруулах, бүртгэлд хамруулах чиг баримжaa байна гэж ойлгосон.


Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүлгүүдийг цааш нь задалж хамгийн бага хэсэг бүрд нь шаардлагатай бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Одоо албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого гарах ёстой. Гэхдээ олон талын оролцоотой, төрийн бодлогуудыг нэгтгэсэн, цогц байх ёстой гэж бодож байна.”

Н.Аюуш /НХХЯ-ны Стратеги, бодлого төлөөвлөлтийн газрын дарга асан/

Судалгааны бас нэг зорилго нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан ёсны бүртгэлд бүртгүүлэх боломж, нөхцөл байдал, нөгөө талаас тэдний албан эдийн засагт шилжих хүсэл сонирхол, үзэл бодлыг тандах явдал байсан.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 50 хувь, ажил олгогчдын 57.3 хувь, ажилтны 61.7 хувь нь албан эдийн засагт шилжих сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.


**► Зураг 34.
Албан эдийн засагт шилжих сонирхол /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


Хөдөлмөрийн Судалгааны Институтийн 2013 оны “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүтэц, төлөв байдлын судалгаа”-аар ажил олгогчдын 42.1 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 25.0 хувь нь албан эдийн засагт шилжих бодолтой гэсэн байна. Хэрэв хоёр судалгааг харьцуулах боломжтой гэж үзвэл албан болох сонирхол нэмэгдсэн байна гэж дүгнэж болох юм.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд насны бүлгээр сонирхолтой хэв маяг харагдаж байна (Зураг 35). Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн албан эдийн засагт шилжих шийдвэр, хүсэл сонирхолд тухайн иргэний нас урвуу хамааралтай буюу өөрөөр хэлбэл нас ахих тусам шилжих сонирхол буурч байгаа нь ажиглагдсан.

Зураг 35.**Албан ёсны бүртгэлтэй болох сонирхол, насны бүлгээр /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Тухайн ажил, бизнест ажилласан жил ба албан эдийн засагт шилжих сонирхлын хоорондын хамаарлыг судлахад ижил хандлага ажиглагдаж байна: албан эдийн засагт шилжих сонирхол нь бизнест ажилласан жилтэй урвуу хамааралтай байна. 1-7 жилийн туршлагатай ажил олгогчдын 61.7 хувь, 8-11 жил үйл ажиллагаа явуулж буй бол 62.6 хувь нь албан болох сонирхолтой. Харин 16 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулж буй ажил олгогчдын 52.8 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 60.2 хувь нь албан салбарт шилжих сонирхолгүй байгаагаа илэрхийлжээ.

Зураг 36.**Албан ёсны бүртгэлтэй болох сонирхол, үйл ажиллагаа явуулсан жилээр /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бизнес, үйл ажиллагаагаа албан ёсны бүртгэлтэй болгосноор хүлээх үр ашгийг тодруулахад ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь ашиг орлого, борлуулалтын хэмжээ, үйлчлүүлэгч нэмэгдэнэ (19.6 хувь), үйл ажиллагаа өргөжиж, ажлын байр нэмэгдэнэ (19.5 хувь) гэж хариулжээ.

Зураг 37.

► Хувиараа хөдөлмөр эрхлэгчид: бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгоход нэлөөлөх үр ашиг /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан салбарт ажиллах сонирхолтой ажилтны 23.9 хувь нь цалин орлого нэмэгдэж, тогтмол цалинтай болно, 28.5 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдах гэсэн үр ашигтай хэмээн үзжээ. Мөн тэдний 2.7 хувь нь албан салбарт ажиллах нь ямар үр ашигтайг тодорхой хэлж мэдэхгүй ч ашигтай байх гэж үзсэн бол 8.6 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн нь тэдэнд энэ төрлийн мэдээлэл дутагдаж байдаг төдийгүй, албан салбарт шилжсэнээр ямар ач холбогдолтой болох талаар ойлголт муу байдгийг харуулж байна. Цөөн тооны ажиллагчид албан салбарт ажиллах сонирхолтой хэдий ч одоогийн нөхцөл байдал нь ашиггүй, албан бус салбарт ажиллах нь илүү ашигтай гэж хариулжээ.

► **Зураг 38.**
Ажилтны албан салбарт хөдөлмөр эрхлэх үр ашиг /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хэлбэрт шилжихэд албан ёсны зохицуулалт, төрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагаагаар дэмжих, цаашид өргөжин хөгжих таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Судалгаагаар энэ талаарх албан бус хөдөлмөр эрхлэгчдийн үзэл бодол, сонирхлыг тодрууллаа. (Тодруулах асуулт нь олон сонголттой болно). Ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаага албан ёсны болгоход нөлөөлөх хамгийн их хэрэгцээтэй дэмжлэг бол бичил бизнесийг дэмжих бага хүйтэй зээл гэжээ (Зураг 39). Бага хүйтэй зээлээс гадна хамгийн их дурдагдсан урамшуулал, хөнгөлөлтөд дараах зүйлс багтсан болно. Үүнд:

- санхүүгийн дэмжлэг эсвэл буцалтгүй тусламж;
- орлогын албан татвараас тодорхой хугацаагаар чөлөөлөх;
- НӨАТ-аас чөлөөлөх; мөн
- гарааны бизнесийг дэмжих.

► **Зураг 39.**
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан хөдөлмөрт шилжихэд нөлөөлөх хөнгөлөлт, урамшуулал
/хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо

Ажилтны 45.8 хувь нь албан салбарт хөдөлмөр эрхлэхэд цалин өндөртэй ажлын байрыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзсэн бол 35.8 хувь нь мэргэжилд албан ёсны ажилд зуучлуулах, 31.2 хувь нь ур чадвар олгох сургалт зэрэг арга хэмжээг дурджаэ.

Зураг 40.

► Ажиллагчдын албан салбарт хөдөлмөр эрхлэхэд нөлөөлөх дэмжлэг, арга хэмжээ /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ БҮРТГҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэх гол шалтгаанууд нь энэ бүлэгт орж, гарахад хялбар бөгөөд зохицуулалт багатай байдаг гэж Андерсон (1998) дүгнэсэн байдаг. Дэлхийн банкнаас бизнес эрхлэхэд учирч байгаа саад бэрхшээлийг хэрхэн арилгаж буй тухай Бизнес эрхлэх нь судалгааг 2003 оноос эхлэн жил бүр хэвлүүлж байна. 2020 оны тайланд Монгол Улс 67.8 оноогоор 190 орноос 81-р байранд эрэмбэлэгдсэн байна. Бизнес эхлүүлэх гэсэн үзүүлэлтээр 86.7 оноогоор 100 дугаар байранд эрэмбэлэгдсэн нь Монгол Улсад албан салбарт үйл ажиллагаа эрхлэх, ялангуяа эхлүүлэх нь ихээхэн хүндрэлтэй байдгийг илтгэж байна. Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгааны дунд төсөөтэй дүгнэлт хийж болно.

Ажил үйлчилгээгээ албандаа шилжүүлснээр ямар хүндрэл бэрхшээл тулгарна гэж бодож байгааг ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс тодруулахад 63.5 хувь нь татвар, шимтгэлийн дарамт /НДШ, ОАТ, НӨАТ, ХАОАТ, нөхөн олговор/, 31.8 хувь нь татвар, хураамжийн тухай хуулийн мэдлэг дутмаг, 28.6 хувь нь нягтлан бодох бүртгэл тооцооны хүндрэл, 26.8 хувь нь бүртгэлийн дүрэм журмын төвөгтэй байдал, 25.3 хувь нь үндсэн хөрөнгө /тоног төхөөрөмж/ дутмаг байдал гэсэн хариултыг өгсөн байна (Зураг 41).

Зураг 41.**► Хувиараа хөдөлмөр эрхлэгчид: албан хөдөлмөр/бизнест шилжихэд тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Эдгээр хариултууд албан ёсоор бизнесээ бүртгүүлэхийг хүсэхгүй байгаа шалтгаантай нягт холбоотой байв (Зураг 42). Зарим нь НДШ, татварын дарамт нэмэгдэнэ гэсэн бол бусад нь эрх зүйн мэдлэг, мэдээллийн дутмаг байдлыг дурдав. Мөн багагүй хувь нь одоогийн нөхцөлөө өөрчлөх сонирхолгүй байна гэжээ. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар ялгамжтай байдал ажиглагдсан. Тухайлбал ажил олгогчид эрхэлж буй ажил үйлчилгээгээ бүртгүүлэхээс татгалзахад хүргэж буй үндсэн шалтгаан НДШ, татварын дарамт нэмэгдэнэ (21.7 хувь) гэж үзэж байхад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд хамгийн их дурдсан шалтгаан нь одоогийн нөхцөл байдлаа өөрчлөхийг хүсэхгүй байгаа (15.4 хувь) гэсэн юм.


Зураг 42.**► Ажил үйлчилгээгээ бүртгүүлэхээс татгалзах шалтгаан /хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажилтнуудаас албан салбарт хөдөлмөр эрхлэхэд ямар хүндэрэл бэрхшээл тулгарч болзошгүй талаар тодруулахад (Зураг 43) 36.3 хувь нь боловсролын шаардлага хангахгүй, 32.2 хувь нь мэргэжил, ур чадвар дутмаг, 24.1 хувь нь ажлын байрны хомсдол, олдоц муу гэж үзжээ

Зураг 43.

► Ажилтнуудын албан салбарт хөдөлмөр эрхлэхэд тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан ажилд шилжих сонирхолгүй байгаа шалтгааныг нарийвчлан тодруулахад нас ахисан, тэтгэвэрт гарсан, шаардлагагүй гэсэн шалтгаанаар 19.0 хувь нь, ажлын цагт баригдмал, дарамт шахалт их гэсэн шалтгаанаар 17.0 хувь албан салбарт ажиллах сонирхолгүй гэжээ. Үүнээс гадна тэдний нэлээдгүй хувь нь цалин бага, ажлын байр хомс, тавигдах шаардлага өндөр, нас заадаг гэх мэтчилэн өөрийн хүсэл сонирхлоос үл шалтгаалах шалтгаанаар албан салбарт хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байdag байна.

Зураг 44.

► Ажилтнуудын албан салбарт хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байгаа шалтгаан /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

3.2 ЦАХИМ БҮРТГЭЛ, ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БОЛОМЖИТ НӨЛӨӨ

Монгол улсын засгийн газраас иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор төрийн үйлчилгээг цахимжуулах бодлого баримталж байна. Судалгаанд мөн бүртгэл мэдээллийн цахим хэлбэрийг ашиглах нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн албан хэлбэрт шилжих хүсэл сонирхолд хэрхэн нөлөөлөхийг тодрууллаа.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 30.2 хувь нь үйл ажиллагаагаа албан ёсны болгоход цахим хэлбэрийн бүртгэлийн систем нь нөлөөлнө, 24.3 хувь нь нөлөөлөхгүй, 45.5 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 45.

► Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


Хөдөлмөр эрхлэлтийн статус, ажилласан жилээр:

- Ажил олгогчид
 - 1-3 жилийн ажлын туршлагатай ажил олгогчдын 41.4 хувь нь цахим бүртгэл нь бүртгүүлэх хүсэлд эергээр нөлөөлнө гэж хариулсан; болон
 - 16 ба түүнээс дээш жилийн ажлын туршлагатай ажил олгогчдын 28.3 хувь нь энэ нь тэдний бүртгүүлэх хүсэлд нөлөөлнө гэжээ
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид.
 - 1-3 жилийн туршлагатай хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 26.2 хувь; болон
 - 16 жилийн туршлагатай иргэдийн 20 хувь нь энэ нь тэдний бүртгүүлэх хүсэлд нөлөөлнө гэж хариулжээ.

Ерөнхийдөө илүү ахмад насны иргэд цахим бүртгэл нь бүртгүүлэх хүсэлд нь нөлөөлөхгүй гэж хэлэх нь их байсан.

Зураг 46.

► Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, хугацаагаар /хувь/



■ Нөлөөлнэ ■ Нөлөөлөхгүй ■ Мэдэхгүй

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг насны ангиллаар нь ангилахад мөн адил хэв маяг ажиглагдаж байна (Хүснэгт 13). Нас ахихын хэрээр цахим бүртгэл бизнесээ албан болгох хүсэлд нөлөөлөхгүй гэх хандлага нэмэгдэх зүй тогтол ажиглагдлаа.

► Хүснэгт 13. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, насны бүлгээр/хувь/

	15-35	36-45	46-55	56+
Нөлөөнэ	40.5	32.4	26.9	20.9
Нөлөөлөхгүй	24.2	23.0	24.9	26.0
Мэдэхгүй	35.4	44.6	48.2	53.1

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүртгүүлэх хүсэл сонирхолд цахим бүртгэлийн хүртээмжийн үзүүлэх нөлөөлөл нь боловсролын түвшинтэй мөн холбоотой байв (хүснэгт 14). Илүү өндөр боловсролтой иргэд цахим бүртгэл нь бүртгүүлэх хүсэлд нь нөлөөлнө гэж хариулах магадлал өндөр байв.


► **Хүснэгт 14. Цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгох хүсэлд нөлөөлөх эсэх, боловсролын түвшнээр /хувь/**

Боловсролын түвшин	Нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Мэдэхгүй
Дээд	37.6	25.8	36.6
Техникийн ба тусгай мэргэжлийн	28.7	26.0	45.3
Бүрэн дунд	28.0	22.7	49.3
Суурь ба түүнээс доош	21.1	25.9	53.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажилтнуудаас ажил олгогчоос хамааралгүйгээр сайн дурын даатгалд хамрагдахад цахим бүртгэлийн үйлчилгээ хэр нөлөөлөхийг тодруулахад тэдний 30.8 хувь нь нөлөөлнө, 24.6 хувь нь нөлөөлөхгүй, 44.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ

► **Зураг 47.
Цахим бүртгэл нь нийгмийн даатгалд хамрагдахад нөлөөлөх эсэх /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Шигтгээ 2.

Албан ёсны эдийн засагт шилжих талаарх олон улсын туршлага

ОУХБ -ын 2015 оны [Албан бус байдаас албан эдийн засагт шилжих тухай](#) 204-р зөвлөмжид албан хэлбэрт шилжихийг дэмжих боломжтой арга хэмжээг тайлбарласан байдаг. Үүнд татварын болон хөдөлмөрийн хуулийг хэрэгжилтийг хангах, бүртгэлийн зардал, хугацааг багасгах, албан хөдөлмөр эрхлэлтэд шилжихэд урамшуулалт олгох, санхүү, технологи, төрийн худалдан авалт, сургалтын хүртээмжийг сайжруулах болон бусад арга хэмжээнүүд ордог.

Доорх хүснэгтэд албан эдийн засагт шилжихэд ашиглах боломжтой стратеги, арга хэмжээг ангилах арга замыг харуулсан болно. Бүтээмжийн стратегид эдийн засгийн өсөлтийг дэмжих, эдийн засгийн өөр өөр салбаруудын уялдаа холбоог сайжруулах бодлого орно. Дүрэм журам гэдэгт бүртгэлийн журмыг хялбарчлах, мэдээлэл түгээх үйл ажиллагаа зэрэгийг оруулж үздэг. Урамшуулалт хөнгөлөлтөд бүртгэлд хамрагдахтай холбоотой санхүүгийн татаас, татварын буцаан олголт, нийгмийн даатгалд хамрагдлал, төрийн үйлчилгээний хүртээмж зэрэг багтдаг бол хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт гэдэгт татварын болон хөдөлмөр эрхлэлтийн дүрэм журмын хэрэгжилтийг чангатгах зэрэг арга хэмжээ ордог.

Хүснэгт	
Албан ёсны эдийн засагт шилжих үед ашиглах үндсэн стратегиуд	
Bүтээмж	Таатай орчныг бүрдүүлэх макро бодлого Салбарын болон сүлжээний дунд түвшний бодлого Бичил компанийн түвшний арга хэмжээ Мэдээлэл сургалт
Дүрэм журам	Дүрэм журмыг хялбарчлах Нийгмийн хэлэлцүүлгээр дамжуулалт хийх Санхүүгийн татаас
Урамшуулалт хөнгөлөлт	Татварын буцаан олголт Нийгмийн даатгалын хамрах хүрээ Төрийн үйлчилгээ/улсын худалдан авалтын хүртээмж
Хэрэгжилтийг хангах	Хууль, дүрэм журмыг дагаж мөрддөг соёл Автоматжуулалт/шинэчлэлт Тусгай дэглэмүүд

Эх сурвалж. Chacaltana et al. (2018).

Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрснийг улс орнуудын жишээн дээр тайлбарлая.

Дүрэм журам. Технологийг ашиглах, албан хэлбэрт шилжихдээ цахим платформ хэрэглэх боломжтой байх нь албан бус хөдөлмөр эрхлэлтийг албанад шилжүүлэхэд нөлөөлнө гэсэн зарим нотолгоо бий. Тухайлбал татварын тайлангаа онлайнаар бөглөх, бизнесээ онлайнаар бүртгүүлэх зэрэг нь албан хэлбэрт шилжих ажиллагааг дэмжихэд тодорхой хэмжээгээр үр дүнтэй болох нь тогтоогджээ. Бизнесийг бүртгэх нэг цэгийн үйлчилгээг хэд хэдэн оронд туршиж үзсэн. Гэхдээ Индонезид хийсэн судалгаагаар технологи хэрэглэх нь тус болох боловч албанад шилжихийг дангаараа мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд хүрэлцэхгүй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Хэрэгжилтийг хангах. Бангладеш улсад татварын албанаас албан бус аж ахуйн нэгж дээр очиж албан ёсоор бүртгүүлэх шаардлага тавьж эсвэл торгууль ногдуулах болно гэсэн албан ёсны анхааруулга өгснөөр бүртгэгдсэн татвар төлөгчдийн тоо хоёр дахин нэмэгдсэн байна, гэхдээ энэ нь ихэвчлэн томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд хэрэгжсэн. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тодорхой хэсгийг нийгмийн хамгаалалт хамруулахаар хуульд өөрчлөлт оруулан, хэрвээ зөрчсөн тохиолдолд шийтгэл оногдуулах арга хэрэглэсэн нь зарим улс оронд амжилттай хэрэгжсэн. Жишээлбэл, хууль хэрэгжсэнээр Тайландад гэрийн ажилчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах хууль батлагдсан. Өмнөд Африкт гэрийн ажилчдыг ажилгүйдлийн даатгалын санд хамрагдаг болсон.

Урамшуулалт хөнгөлөлт. Улс орнууд албан хэлбэрт шилжих олон төрлийн урамшууллыг амжилттайгаар туршиж үзсэн:

- ▶ Вьетнам улсад, хөрөнгө оруулалтын урамшуулал, татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл хэлбэрийн засгийн газрын санхүүгийн дэмжлэгийг хэрэгжүүлсэн;
- ▶ Энэтхэгт, нийгмийн хамгааллын ажил олгогчийн шимтгэлд төрөөс татаас өгсөн;
- ▶ Энэтхэг, Тайланд, Вьетнам улсад, бага орлоготой албан бус ажилчдыг нийгмийн даатгалд хамруулахад төрөөс шууд татаас өгөх, Шри Ланкад бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд төлбөр төлсөн (нөгөө талаас бүртгэлийн явцын тухай мэдээлэл өгөх, бүртгэлийн шууд зардлыг нөхөн төлөх нь Шри Ланкад үр дүн өгсөнгүй гэсэн туршлага бий).

Бусад улс орнуудын албан хэлбэрт шилжүүлсэн туршлагаас суралцах нь чухал боловч дээрх стратегиудын үр нөлөө тухайн орны нөхцөл байдлаас ихэхэн хамаарах нь ойлгомжтой. Аль нэг стратеги өөр оронд үр дүнтэй байсан гээд Монголд тийм байх болно гэсэн уг биш юм.

Эх сурвалж. Chacaltana et al. (2018); ILO (2015) ; Mehrotra (2019).

3.3 НЭМЭЛТ СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭ

Өмнөх хэсгийн нэгэн адил бид сонирхсон гол хамааран хувьсагчдыг хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааруулан регрессийн шинжилгээ хийсэн.

Албан ёсны ажлын байранд шилжих сонирхол. Ажилтны хувьд албан ёсны ажлын байранд шилжих сонирхол нь ямар нэг хамааралгүй байна, өөрөөр хэлбэл тайлбарлагч хувьсагчдын аль нь ч албан ёсны ажлын байранд шилжих сонирхлыг тайлбарлаж чадахгүй байна гэсэн үг.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бизнесээ бүртгүүлэх сонирхол нь нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байна. Ахмад насны ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид бизнесээ бүртгүүлэх сонирхол багатай. Тээврийн салбарынхан бизнесээ бүртгүүлэх сонирхол бага, барилга, боловсруулах үйлдвэрлэл болон бусад салбарынхан бизнесээ бүртгүүлэх сонирхол нь илүү байна.

Цахим бүртгэлийн хүртээмж нь тэтгэврийн санд сайн дураараа шимтгэл төлөхөд үзүүлэх нөлөө. Ажилтнуудын дунд болзошгүй нөлөөллийг мэдэхгүй эсвэл цахим бүртгэлийн нөлөөллийн талаар ямар ч ойлголтгүй хүмүүс ихэвчлэн эрэгтэйчүүд ба ахмад насны хүмүүс байна.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд цахим бүртгэл нь бизнесээ албан ёсны болгоход ямар нөлөө үзүүлэх талаар ямар ч ойлголтгүй хүмүүс ихэвчлэн ахмад насны хүмүүс байсан.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бизнесээ албан ёсны болгон бүртгүүлэхэд юу нөлөөлөхийг асуухад:

- ▶ “Тодорхой хугацаанд орлогын албан татвараас чөлөөлөх” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд техникийн мэргэжлийн болон түүнээс дээш боловсролтой, барилгын салбарынхан голдуу байсан. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан орлогын албан татвараас чөлөөлөх тухай дурдсангүй. Мөн ажил олгогчид орлогын албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх бодлогод илүү хариу үзүүлэх хандлагатай байв.
- ▶ “НӨАТ-аас чөлөөлөх, урамшуулал олгох” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд өндөр боловсролтой, боловсруулах үйлдвэрлэлийн салбараас бусад ажил олгогчид их байсан.
- ▶ “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх эсвэл урамшуулал олгох” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд өндөр боловсролтой залуу хүмүүс түлхүү байсан. Мөн ажил олгогчид нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, урамшуулал олгох талаар илүү дурдсан байна.
- ▶ “Хөрөнгө, тоног төхөөрөмжийн туслалцаа, дэмжлэг” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд бага боловсролтой, эрэгтэйчүүд голдуу байв.
- ▶ “Бичил бизнест зориулсан бага хүйтэй зээл” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд 49 ба түүнээс доош насныхан их байсан. Мөн ажил олгогчид бичил бизнест зориулсан бага хүйтэй зээл хариу үзүүлэх хандлагатай байсан.

- ▶ “Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд техникийн мэргэжлийн болон түүнээс дээш боловсролтой, бусад үйлчилгээний салбарынхан их байсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид мөн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт чухал нөлөөтэй гэсэн хариулт өгөх магадлал өндөр байв. Харин барилга, тээврийн салбарт ажиллаж байгаа иргэд ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн талаар дурдах нь бага байсан.
- ▶ Эцэст нь, “төрийн худалдан авалтад хамрагдах боломж” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн дунд боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын ажилчид. Мөн ажил олгогчид төрийн худалдан авалтад хамрагдах боломжийн талаар илүү их дурдаж байсныг тэмдэглэмээр байна.

ДҮГНЭЛТ

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь бизнес эрхлэхэд асуудал тулгараагүй гэсэн боловч татвар, хураамж, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын байрны эзэдтэй холбоотой асуудлууд цөөн боловч тохиолдож байжээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь бизнесийнхээ талаар өөдрөг үзэлтэй байгаа бөгөөд ажил олгогчдын тавны дөрөв нь өөрсдийн эрхэлж буй бизнесийг ирээдүйтэй гэж үзэж байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь албан эдийн засгийн салбарт шилжих сонирхолтой байгаа ч энэ хандлага нь тэдний ажил эрхлэлтийн байдалтай холбоотой. Албан эдийн засагт шилжих сонирхол хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс, ажил олгогчид, ажилтан гэсэн дарааллаар өсөж байв. Харин арай залуу, богино хугацаанд бизнес эрхэлж байгаа ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид албан эдийн засагт шилжих сонирхолтой байгаагаа илүү илэрхийлсэн.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бизнесээ бүртгүүлснээр ашиг орлого, борлуулалтын хэмжээ, үйлчлүүлэгч нэмэгдэнэ, үйл ажиллагаа өргөжиж ажлын байр нэмэгдэнэ гэсэн хүлээлт байна. Ажилтнуудын хувьд албан салбарт ажиллах нь цалин орлого нэмэгдэн тогтмолжих, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдах үр ашигтай хэмээн үзэж байна.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд бизнесээ албан ёсны болгоход хамгийн чухал дэмжлэг нь бага хүйтэй зээл бол ажилтнуудад өндөр цалинтай албан ажлын байр, хөдөлмөр зуучлалын үйлчилгээ хамгийн их хэрэгтэй байна.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дарамт, татвар, хураамжийн тухай хуулийн мэдлэг дутмаг, няглан бодох бүртгэлийн асуудал, бүртгэлийн дүрэм журмын төвөгтэй байдал гэсэн хариултыг өгсөн байна. Харин ажилтнууд учирч буй гол бэрхшээлийг боловсролын шаардлага хангахгүй, мэргэжил, ур чадварт тохиорохгүй, ажлын байрны хомсдол, олдоц муу гэжээ.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн олонх нь цахим бүртгэл бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгоход нөлөөлөх эсэхийг мэдэхгүй гэж хариулсан. Тэдний ихэнх нь ахмад насны хүмүүс байна. Харин аравны гурав нь нөлөөлнө, дөрөвний нэг

орчим нь цахим бүртгэлтэй болох нь тэдний бизнесийг албан ёсоор бүртгүүлэхэд нөлөөлөхгүй гэж хариулжээ. Цахим бүртгэл нөлөөлөх магадлал нь ажил олгогчдын хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс өндөр байсан. Цахим бүртгэл нь залуучуудын хувьд ахмадуудтай харьцуулбал бүртгүүлэх хүсэлд илүү нөлөөлөх төлөвтэй байна.

Нэмэлт статистик шинжилгээгээр дараах зүйл илэрлээ. Үүнд:

- ▶ Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд нас, эдийн засгийн үйл ажиллагааны салбар бизнесээ бүртгүүлэх сонирхолтой холбоотой байсан бөгөөд залуучууд голцуу барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан илүү их сонирхолтой байна.
- ▶ Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ахмад насны бүлэг тэтгэврийн санд сайн дураараа шимтгэл төлөх (ажилтнуудын хувьд) эсвэл бизнесээ бүртгүүлэх (ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд) шийдварт цахим бүртгэл хэрхэн нөлөөлөх талаар ямар ч санал бодолгүй байх магадлал өндөр байна. Мөн эрэгтэйчүүд цахим бүртгэл нь тэтгэврийн санд хамрагдахад ямар нөлөө үзүүлэх талаар ямар нэгэн санал бодолгүй байх магадлал өндөр байв.
- ▶ Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бизнесээ бүртгүүлэхэд ямар урамшуулал, хөнгөлөлт нөлөөлөх талаар тодруулахад тэдний зарим шинж чанараас хамааран ялгаатай байв. Үүнд:
 - ▶ Ажил олгогчид болон харьцангуй өндөр боловсролтой иргэд орлогын албан татвараас тодорхой хугацаагаар чөлөөлөгдөх, НӨАТ-аас чөлөөлөх, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт зэргийг илүү дурдсан байна. Мөн бичил бизнес эрхлэхэд бага хүйтэй зээл, төрийн худалдан авалтад хамрагдах нь ажил олгогчдод бизнесээ бүртгүүлэхэд нөлөөлж чадна гэжээ.
 - ▶ Эрэгтэйчүүд болон боловсрол багатай иргэд хөрөнгө, тоног төхөөрөмжийн тусlamж, дэмжлэгийг илүү ихээр дурдсан.
 - ▶ Хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг илүү их дурдаж байсан.
 - ▶ Барилгын салбарынхан орлогын албан татвараас чөлөөлөгдөх, төрийн худалдан авалтад хамрагдах боломжийг бизнесээ бүртгүүлэхэд нөлөөлж чадна гэсэн бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан мөн төрийн худалдан авалтад хамрагдах боломжийн талаар илүү их дурдсан байна.

БҮЛЭГ 4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАГДАЛТ

Энэ хэсэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээллийг авч үзнэ. Үүнд:

- ▶ албан бус хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчин;
- ▶ хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрүүд;
- ▶ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн эх сурвалж, хүртээмж;
- ▶ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үр дүн;
- ▶ цаашдын хэрэгцээ.

4.1 АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЖ БҮЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Албан бус хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан авч үзсэн хууль тогтоомж одоогоор байхгүй байна. Гэвч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудал ямар нэг хэмжээнд тусжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн даатгалд хамруулах талаар тодорхой заалтууд эдгээр хуульд орсон байна.

- ▶ **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд** хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдана гэж заасан байдаг. Хуулийн 12 дугаар зүйлд эдгээр иргэдэд чиглэсэн арга хэмжээний тухай заасан. Дэмжих арга хэмжээ нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалт, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг болон бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслийг багтаасан.
- ▶ **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд** хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэн гэж өргөн хүрээнд тодорхойлсноор албан бус хөдөлмөр эрхлэгчид хамрагдах боломж бүрдсэн бөгөөд ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй хэмээн зааж өгсөн. Албан салбарт ажиллаж байгаа албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд энэ хууль ажил олгогчид үүрэг хүлээлгэснээр хэрэгжих боломжтой ч албан бус салбарт ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд хэрэгжилтэд тодорхой асуудал, хийдэл байна.

- ▶ **Нийгмийн даатгалын тухай хуульд** албан бус хөдөлмөр эрхлэгчид сайн дураар нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалгаалсан өвчний даатгал) хамрагдаж болно гэж зааж өгсөн. Ингэснээр албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн хамгаалалд хамрагдах боломжийг нээсэн.

▶ **Хүснэгт 15. Албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомж**

Хуулийн нэр	Он	Товч танилцуулга
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль / шинэчилсэн найруулга/	2011	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдана гэж зааж өгсөн бөгөөд эдгээр иргэдийг дэмжих бие даасан бүлэг оруулсан.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008	Хуулийн үйлчлэх хүрээг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэн гэж өргөн хүрээнд тодорхойлсноор албан бус хөдөлмөр эрхлэгчид хамрагдах боломж бүрдсэн. Хуулинд ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй гэж зааж өгсөн.
Нийгмийн даатгалын тухай хууль	1994	Албан бус хөдөлмөр эрхлэгчид сайн дураар нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалгаалсан өвчний даатгал) хамрагдаж болно гэж зааж өгсөн. Ингэснээр албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн хамгаалалд хамрагдах боломж нээж өгсөн.
Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /шинэчилсэн найруулга/	2019	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг ард иргээдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй байна гэж заасан.

ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ БОДЛОГО ХӨТӨЛБӨР

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар нэгдсэн эрх зүйн зохицуулалт байхгүй боловч олон тооны бодлого, хөтөлбөрүүдэд тодорхой асуудлууд тусгагдсан байдаг:

- ▶ Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичигт 2021-2030 онд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулах зорилт тавьсан. Мөн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд хамруулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасан.
- ▶ Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилт тавьсан.
- ▶ Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2026 онд хоёр үе шаттай хэрэгжиж байна. Уг бодлогод зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тодорхой зорилт тавьсан байна. Тухайлбал, албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувийг 2020 онд 14.1, 2025 онд 11.7 болгооэр заажээ. Мөн нийгмийн даатгал төлөгчдийн тоог өсгөж 2020 онд 1129.3, 2025 онд 1220.1 мянга болгох зорилт тавьсан.

- ▶ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан 2021-2022 онуудад хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой арга хэмжээнүүд орсон. Ковид-19 цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох, эргэлтийн хөрөнгийн дэмжлэг, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа зэрэг арга хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхлэгчийг хамруулахаар заасан байна.
- ▶ Төрөөс тэтгэврийн шинэчлэлтийн талаар баримтлах бодлогыг 2015-2030 онд хэрэгжүүлэхээр баталсан байдаг. Уг бодлогод малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгааг сайжруулах зорилт тавьсан. Уг зорилтод хүрэхийн тулд тэтгэврийн даатгалын тусгай сан байгуулах, тэтгэврийн даатгалын харилцааг тусгай хуулиар зохицуулах, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50-ас багагүй хувийг төрөөс хариуцах, хариуцах хугацааг хуулиар зохицуулах зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.
- ▶ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдвартгийн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж зааж өгсөн.

► **Хүснэгт 16. Бодлого хөтөлбөр**

Нэр	Он	Товч зорилт
Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	2020	Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсслэл, иргэдийн амьдралын чанараар Азиid тэргүүлэгч орнуудын нэг болно.
Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2016	Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцлийг бүрдүүлж, ажиллах хүчиний мэргэклийн ур чадварыг тасралтуй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулахад чиглэнэ.
Төрөөс тэтгэврийн шинэчлэлтийн талаар баримтлах бодлого	2015	Бодлогын зорилго нь хүн амын насны бутцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсслэлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өснөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхaa үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжираанд хүрэлцхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэх юм.
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2020	Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд эзлэтий хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаагаа сэргээх хөтөлбөр	2021	Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн телөгдэх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачлагыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх

ӨМНӨ НЬ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Өнөөгийн зохицуулалтуудаас гадна өмнө нь хэрэгжүүлээд дууссан бодлого, хөтөлбөрүүдэд албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн байдаг.

- ▶ Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод сууринсан үндэсний хөгжлийн цогц бодлогод (2007-2021) албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, дараах зорилгоор арга хэмжээнүүдийг цогц байдлаар хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:
 - ▶ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулах;
 - ▶ төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх; мөн
 - ▶ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.
- ▶ Үүнтэй адилаар, 2006-2015 онд хэрэгжүүлсэн албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого бол энэ секторт чиглэсэн томоохон арга хэмжээнүүдийг агуулсан баримт бичиг юм. Уг бодлого нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн үйлчилгээгээр дамжуулан албан хэлбэрт шилжүүлэх, аливаа эрсдэлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгох зорилготой бөгөөд бодлогод албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх, аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил үйлчилгээ эрхлэгч хувь хүн, өрх, хамтлагийг хамруулахаар зааж өгсөн. Үүнд дараах арга хэмжээнүүдийг тусгаж өгсөн:
 - ▶ албан бус хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулалтад орох боломжийг өргөжүүлэх;
 - ▶ үндэсний бүртгэл тооцооны системд хамруулах; ба
 - ▶ нийгмийн хамгааллыг сайжруулах.
- ▶ Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөрт (2006-2010) албан бус хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, ойлголт, тодорхойлолтыг олон улсын нийлэг стандарт, арга зүйд нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэх арга хэмжээ авахаар, гурван тулгуурт хөгжлийн бодлогод (2018-2020) дараах зорилт дэвшүүлсэн:
 - ▶ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажиллах нөхцөлөө сайжруулах, бүтээмжээ нэмэгдүүлэх;
 - ▶ хөдөлмөрөө оновчтой хорших боломжийг дэмжих; ба

- ▶ үйл ажиллагаагаа албан хэлбэрт шилжүүлэхийг дэмжих.
- ▶ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчин бурдүүлнэ гэж зааж өгсөн байна.

4.2 МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, ХАМРАГДАЛТ

Төрөөс хүн амын хөдөлмөрийг дэмжихтэй холбоотой хэрэгжүүлж буй бодлого, хөдөлмөрийн болон холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн талаарх албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдлэг, мэдээллийн түвшнийг үнэлэх зорилгоор энэхүү судалгаа Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаарх ажиллагсдын мэдлэгийн түвшнийг тодруулсан юм.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эдгээр бодлого, хөдөлмөрийн хууль, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн талаарх мэдлэгийн түвшингээ хангалтгүй гэж дүгнэсэн (хүснэгт 17). Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн статусаас үл хамааран ижил байсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх мэдлэг нь бусад хөдөлмөрийн бодлого, хууль тогтоомжтой харьцуулахад бүх хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд харьцангуй өндөр байсан ч хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд энэ нь хуулиас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр төслийн талаарх мэдлэгтэй ойролцоо түвшинд байсан. Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн талаарх мэдлэг хамгийн бага байв

► Хүснэгт 17. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэг /хувь/

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Хууль, бодлогын баримт бичиг	Хөдөлмөрийн тухай хууль	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	ХАБЭА тухай хууль	Төрөөс ХЭД талаар баримтлах бодлого	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр
Ажил олгогч	Мэдэхгүй	68.5	76.2	62.6	80.7	66.7
	Бага зэрэг	27.7	21.5	28.6	17.6	25.1
	Мэднэ	3.8	2.3	8.8	1.7	8.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Мэдэхгүй	72.1	78.7	66.6	82.0	66.7
	Бага зэрэг	23.8	18.5	27.0	16.0	27.3
	Мэднэ	4.2	2.8	6.4	2.1	6.1
Ажилтан	Мэдэхгүй	77.6	83.2	67.2	85.0	80.0
	Бага зэрэг	19.9	14.2	24.7	13.6	14.5
	Мэднэ	2.5	2.6	8.1	1.4	5.5

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгийн талаарх мэдээлэл мэдлэгийн түвшнийг насны бүлгээр (хүснэгт 18) задлан үзвэл сонирхолтой зүй тогтол гарчээ. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэг насны бүлэгтэй И хэлбэрийн хамаарал ажиглагдаж байна. Энэ нь хамгийн залуу болон хамгийн ахмад насны хүмүүсийн дунд ийм мэдлэг харьцангуй өндөр, харин эдгээр хоёрын бүлгийн дунд байгаа иргэдийн мэдлэг бага байсан гэсэн үг юм. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг ахмад насны бүлэгт, ялангуяа 56 ба түүнээс дээш насыхны хувьд өндөр байсан.

► **Хүснэгт 18. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид насны бүлгээр /хувь/**

Хууль, эрх зүй	Насны бүлэг	15–35	36–45	46–55	56+
Хөдөлмөрийн тухай хууль	Мэдэхгүй	68.6	73.7	69.8	67.7
	Бага зэрэг	27.4	22.9	26.2	27.7
	Мэднэ	4.0	3.4	4.0	4.6
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Мэдэхгүй	75.4	80.4	77.2	75.7
	Бага зэрэг	21.9	17.6	20.3	20.4
	Мэднэ	2.7	2.0	2.5	3.9
ХАБЭА тухай хууль	Мэдэхгүй	60.2	67.1	65.4	61.5
	Бага зэрэг	30.1	26.5	27.0	29.0
	Мэднэ	9.7	6.4	7.6	9.3
Төрөөс ХЭД талаар баримтлах бодлого	Мэдэхгүй	81.6	84.8	80.3	76.3
	Бага зэрэг	16.8	13.7	18.0	20.4
	Мэднэ	1.6	1.5	1.7	3.3
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр	Мэдэхгүй	72.4	70.0	65.5	61.4
	Бага зэрэг	22.3	24.1	26.6	28.5
	Мэднэ	5.4	6.1	8.0	10.1

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Боловсролын түвшин өндөр байх тусам албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хууль эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх ерөнхий мэдлэг нэмэгдэх хандлагатай байна (хүснэгт 19).

► Хүснэгт 19. Хууль, бодлогын баримт бичгүүдийн талаарх мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид боловсролын түвшнээр /хувь/


Хууль, эрх зүй	Боловсрол	Суурь ба түүнээс бага	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Хөдөлмөрийн тухай хууль	Мэдэхгүй	74.0	78.3	67.7	57.2
	Бага зэрэг	23.5	19.9	28.9	34.8
	Мэднэ	2.5	1.8	3.4	8.1
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Мэдэхгүй	80.3	83.8	80.3	65.6
	Бага зэрэг	17.9	15.3	18.7	28.3
	Мэднэ	1.8	0.9	1.0	6.1
ХАБЭА тухай хууль	Мэдэхгүй	69.5	71.8	55.5	53.5
	Бага зэрэг	25.5	22.9	32.0	35.1
	Мэднэ	5.0	5.3	12.6	11.4
Төрөөс ХЭД талаар баримтлах бодлого	Мэдэхгүй	84.4	86.3	82.7	71.9
	Бага зэрэг	14.1	13.0	15.0	24.3
	Мэднэ	1.5	0.7	2.2	3.8
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр	Мэдэхгүй	72.4	71.1	64.9	61.0
	Бага зэрэг	22.1	23.6	25.3	29.1
	Мэднэ	5.5	5.4	9.9	9.9

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Эрхэлж буй ажил мэргэжлийн хувьд Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хууль, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын талаар цай хоол, буудлаар үйлчлэх ажил эрхлэгчид, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар барилгын засалчин, будагчин, гагнуурчид, хамгийн сайн мэддэг. Харин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаар оёдол, гар урлал, дархан болон цай хоол байр буудлаар үйлчлэх үйлчилгээ эрхлэгчид хамгийн сайн мэддэг гэсэн судалгааны дүн гарсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг багтана. Мөн түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр хэлбэрээр хэрэгждэг.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалжийг тодруулахад 24.2 хувь нь утас, цахим мэдээллийг суваг, 21.4 хувь нь телевиз, радиогоос гэсэн хариултыг голчлон дурджээ. Уг асуултад нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 50.5 хувь нь хаанаас ч мэдээлэл авч чадаггүй гэж хариулсан байгаа нь энэ чиглэлийн мэдээлэл дутагдалтай байдгийг харуулж байна.

Зураг 48.**► Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн эх сурвалж / хувь/**

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсээр, Хангайн бүсийнхний утас цахим мэдээллийн сувгаар мэдээлэл хүлээн авах байдал Улаанбаатар хотынхноос өндөр хувьтай байна. Улаанбаатар хотын албан бус хөдөлмөр эрхлэгчид хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг харьяа дүүргийн XXXYX-ээс авах хувь аймгуудтай харьцуулахад бага хувьтай байна.

► Хүснэгт 20. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалж, бүсээр /хувь/

Мэдээллийн эх сурвалж	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Утас цахим мэдээллийн суваг	19.8	30.8	19.8	20.6	24.8
Хэлтсийн мэргэжилтэн /XXXYX, XXҮҮГ/	19.8	17.6	10.0	24.4	9.1
Брошур хэвлэмэл материал	1.3	5.0	0.8	1.1	1.5
Сонин, хэвлэл	3.4	3.2	1.6	2.7	2.4
Найз, нөхөд танилаас	17.5	10.5	21.4	11.8	11.7
Гэр бүлээс	5.0	3.2	4.5	1.1	2.6
Телевиз, Радио мэдээгээр	24.6	17.4	23.7	14.5	22.1
Төрийн бус байгууллага	1.3	0.3	0.5	0.0	0.3
Хаанаас ч авч чаддаггүй	44.2	46.6	53.3	47.5	52.7
Бусад	4.0	1.1	2.1	1.1	3.4

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Насны бүлгийн хувьд бүх насны бүлэгт утас, цахим мэдээллийн суваг болон телевиз, радио голлох үүрэгтэй байна. Гэвч нас ахих тусам утас, цахим мэдээллийн суваг ашиглах нь багасаж эсрэгээрээ телевиз, радиогоор мэдээлэл хүлээн авах хандлагатай байна.

► **Хүснэгт 21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалж наасны бүлгээр /хувь/**

Мэдээллийн эх сурвалж	15-35	36-45	46-55	56+
Утас, цахим мэдээллийн суваг	33.0	25.0	22.0	15.2
Хэлтсийн мэргэжилтэн /ХХХХ, ХХҮГ/	6.9	13.2	14.2	16.5
Брошур хэвлэмэл материал	3.0	1.3	1.8	2.2
Сонин, хэвлэл	1.9	1.7	3.0	4.7
Найз, нөхөд танилаас	14.0	12.1	15.2	13.0
Гэр бүлээс	2.7	3.0	3.4	4.5
Телевиз, радио мэдээгээр	16.8	17.6	23.7	31.6
Төрийн бус байгууллага	0.0	0.7	0.3	0.8
Хаанаас ч авч чаддаггүй	53.0	52.8	48.9	45.2

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЛТ

Нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 10.7 хувь нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан гэж судалгааны дүн харуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар ажил олгогчдын 11.9 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 10.3 хувь, ажилтны 5.1 хувь хамрагдсан байна. Хүйсийн хувьд судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 9.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ямар нэг хөтөлбөрт хамрагдажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг ойлголтыг хөтөлбөрт хамрагдаж байсан эсэхтэй нь хамаарал бодож үзвэл ажил мэргэжлийн түвшинд хамаарал нь өндөр эерэг хамааралтай (0.8) байна (Зураг 49). Тухайлбал, жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар мэдлэгтэй байдаг ч хөтөлбөрт хамрагдах нь бага байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хамрагдахаар тогтоодогтой холбоотой байж болох юм.

Зураг 49.

► **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан ба хөтөлбөрийн талаар мэдлэгтэй албан бус хөдөлмөр эрхлэгчид /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсээр авч үзвэл, Улаанбаатар хотын албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 6.4 хувь, Хангайн бүсийн 14.7 хувь, Баруун бүсийн 18.8 хувь, Төвийн бүсийн 11.9 хувь, Зүүн бүсийн 17.7 хувь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ямар нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөтөлбөр бүрээр авч үзвэл 50.7 хувь нь жижиг зээлийн арга хэмжээнд, 21.9 хувь нь ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан нь дийлэнх хувийг эзэлж байна.

2019 онд аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн газар хэлтсээс орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээ, хүн амын тоо, нийгэм, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын болон амьжиргааны түвшин зэрэг холбогдох үзүүлэлтүүдэд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилтот төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн газар, хэлтсээс сонгон шалгаруулж, дэмжлэг үзүүлсэн. ХХҮЕГ-ын мэдээгээр Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төсөлд 2019 онд 33.3 хувь нь Хангайн бүсээс, 27.7 хувь нь Төвийн бүсээс, 20.9 хувь нь Баруун бүсээс, 10.7 хувь нь Зүүн бүсээс, 7.3 хувь нь Улаанбаатар хотоос тус тус хамрагджээ.

Харин судалгаанд хамрагдсан Хангайн бүсийн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 14.3 хувь нь энэхүү орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төсөлд хамрагдсан нь бусад бүстэй харьцуулахад өндөр хувьтай байна.

Эдгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийг 2019, 2020 онд улсын хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн дүнтэй харьцуулахад маш бага хувьтай байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ БА СУЛ ТАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдээс эдгээр хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан эсэх, хөтөлбөрүүдэд ямар давуу болон сул тал байсныг нарийвчлан тодруулсан юм.

Хөтөлбөрт хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 62.8 хувь нь (ажил олгогчдын 64.3 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 60.6 хувь), хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан гэж хариулжээ.

Зураг 50

► Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан эсэх /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагдсан оролцогчдын хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Түүнчлэн эдгээр хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсанаар тэдэнд ямар давуу тал бий болсныг тодруулахад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 48.7 хувь нь ажил үйлчилгээгээ өргөжүүлж чадсан, 21.2 хувь нь борлуулалтын хэмжээ нэмэгдсэн гэж хариулжээ. Гэвч албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 21.2 хувь нь мэдэхгүй, 19.2 хувь нь ямар нэгэн давуу тал үүсээгүй хэмээн хариулсан байна.

Зураг 51.

► **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээнд хамрагдсанаар бий болсон давуу тал /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсанаар ямар ч төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ажил үйлчилгээгээ өргөжүүлсэн, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн, түүнийг дагаад санхүүгийн хүндрэлээс гарсан давуу талууд бий болжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдээс сул тал байсан эсэхийг тодруулахад 28.3 хувь нь ямар нэг сул тал байхгүй хэмээн хариулсан байна. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ бага байдаг (30.9 хувь) нь хамгийн том сул тал гэж үзсэн.

Зураг 52.

► **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний сул тал /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ямар нэг төсөлт хөтөлбөрт хамрагдаагүй албан бус хөдөлмөр эрхлэгчдээс ямар шалтгаанаар хамрагдаагүй талаар тодруулахад, дийлэнх нь буноо 68.6 хувь нь энэ талаар мэдээлэл байхгүйгээс болоод хамрагдаж чадаагүй, 18.7 хувь нь тухайн үед тавигдах шаардлага (жишээлбэл нас, үйл ажиллагааны чиглэл) хангаагүй, 10.9 хувь нь төрийн албан хаагчийн хүнд суртлыг, 10.0 хувь нь хэрэгцээт арга хэмжээ байгаагүй гэжээ (Зураг 53).

Зураг 53.

► Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж чадаагүй шалтгаан /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Насны бүлгээр нь авч үзвэл, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамрагдаж чадаагүй ахмадуудын (46-55 ба 56+ насны) дунд зохих шаардлагыг хангаагүй гэсэн шалтгаан арай илүү байсан бол залуучуудын хувьд (15-35, 36-45 насны) мэдээлэл дутмаг байна гэсэн шалтгаан арай илүү байв.

► Хүснэгт 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж чадаагүй шалтгаан насны бүлгээр /хувь/

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж чадаагүй шалтгаан	15-35	36-45	46-55	56+
Хамрагдахад тавигдах шаардлага	17.7	17.2	20.3	19.5
Өмнө нь өөр хөтөлбөрт хамрагдсан	0.4	0.2	0.4	0.2
Хүнд суртал	12.4	9.8	11.4	10.4
Мэдээлэл байхгүй	69.1	72.5	65.3	66.9
Тухайн үед ажилтай байсан	7.8	7.7	9.4	6.6
Хэрэгцээт арга хэмжээ байгаагүй	9.8	9.5	10.4	10.1
Бусад	6.8	5.7	6.3	7.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Боловсролын түвшнээр үзвэл хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамрагдаж чадаагүй техникийн болон тусгай мэргэжлийн дунд, бакалаврын болон түүнээс дээш боловсролтой албан бус хөдөлмөр эрхлэгчид зохих шаардлагыг хангаагүй гэж хэлэх магадлал өндөр байсан бол бүрэн дунд, түүнээс доош боловсролтойчууд нь мэдээлэл дутмаг байна гэж дурдах нь арай илүү байлаа (Хүснэгт 23).

► **Хүснэгт 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж чадаагүй шалтгаан боловсролын түвшнээр /хувь/**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж чадаагүй шалтгаан	Суурь ба түүнээс бага	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Хамрагдах үед тавигдах шаардлага	15.9	17.4	22.4	20.6
Өмнө нь өөр хөтөлбөрт хамрагдсан	0.6	0.2	0.5	0.3
Хүнд суртал	10.9	10.6	11.86	11.11
Мэдээлэл байхгүй	69.9	71.4	64.4	64.7
Тухайн үед ажилтай байсан	8.7	7.8	9.8	8.2
Хэрэгцээт арга хэмжээ байгаагүй	8.8	9.4	7.7	12.1
Бусад	6.1	5.8	8.0	6.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

4.3 ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭ

Судалгааны үр дүнгээр албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 71.9 хувь нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ямар нэг дэмжлэг хэрэгтэй гэж үзсэн байна. Дэмжлэг тус бүрийг нарийвчлан үзвэл тэдний 88.6 хувь нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг, дараа нь 86.4 хувь нь бичил бизнесийн зээлийг, дараа нь 63.7 хувь нь гарааны бизнесийн дэмжлэг хамгийн их шаардлагатай гэж үзжээ (Зураг 54).

► **Зураг 54. Бизнест ашигтай төрийн дэмжлэг /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Шаардлагатай төрийн дэмжлэгийн хамгийн их дурдагдсан хэлбэрүүд эдийн засгийн үйл ажиллагааны өөр өөр салбаруудад адил байв: эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг ба бичил бизнесийн зээл (Хүснэгт 24).


► **Хүснэгт 24. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хэрэгцээ, эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар /хувь/**

Эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбар	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг	Бичил бизнест зориулсан зээл	Ажлын байрны түрээсийн дэмжлэг	Борлуулалтын дэмжлэг	Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ
Боловсруулах үйлдвэр	87.9	87.3	59.4	58.3	64.3
Барилга	80.6	69.2	42.6	37.7	69.2
Бөөний болон жижиглэн худалдаа	90.1	88.4	57.2	58.1	63.1
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	86.4	81.0	35.1	28.8	67.4
Зочид буудал	90.8	81.8	54.3	45.7	56.7
Үйлчилгээний бусад	84.8	85.6	67.5	46.9	66.8
Бусад	86.6	84.6	56.4	39.7	62.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцох шаардлагатай гэж хариулсан оролцогчдын 48 хувь нь бизнес эрхлэх сургалт, 38 хувь нь ажлын байран дээрх сургалт, 37 хувь нь мэргэжлийн сургалтад хамрагдах шаардлагатай гэж хариулсан байна (Зураг 55).


► **Зураг 55.
Бизнесийг сайжруулахад шаардлагатай сургалтын хэрэгцээ /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Тэднээс өөр ямар сургалтын хэрэгцээ байгаа талаар нээлттэй асуулт асуухад хамгийн их дурдагдсан нь мэргэжлийн сургалт, нягтлан бодох бүртгэлийн сургалт, бизнес эрхлэх сургалт байв (Зураг 56). Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулах, сурталчлах зорилгоор онлайн маркетинг, худалдааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрхэн үр дүнтэй ашиглах талаарх сургалт дутагддаг байна. Тухайлбал дэлгүүр, худалдааны үйл ажиллагаа эрхлэгчид хэрэглэгчдээ и-баримт гаргаж өгснөөр өрсөлдөх чадвар сайжрах давуу талтай бөгөөд үүнтэй холбоотойгоор татварын тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн талаар анхан шатны мэдээлэл авах, сургалтад хамрагдах хэрэгцээ багагүй гардаг гэжээ.

► Зураг 56. Бизнесийг сайжруулахад шаардлагатай бусад сургалтын хэрэгцээ /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

4.4 НЭМЭЛТ СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭ

Өмнөхтэй адилаар регрессийн шинжилгээ хийсэн. Шинжилгээнээс харахад өдгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, хөтөлбөрийн талаарх мэдлэг нь нас, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байна.

- Эдгээр хууль, хөтөлбөрийн талаар харьцаангуй бага мэдлэг, мэдээлэлтэй байх магадлалтай албан бус хөдөлмөр эрхлэгчид нь залуучууд, их дээд сургууль төгсөөгүй иргэд, эмэгтэйчүүд, худалдаа, засвар, тээвэр, бусад үйлчилгээний салбарынхан болон ажилтнууд орж байна.

ДҮГНЭЛТ

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар мэдлэггүй байна. Мэдлэггүй байдал боловсролын түвшин доогуур хүмүүсийн хувьд өндөр байх хандлага ажиглагдсан.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү хувь нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл хаанаас авахаа мэддэггүй юм байна. Судалгаанд

оролцогчдын тавны нэг нь ажил эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл аваадаа утас, цахим мэдээллийн суваг, тавны нэг орчим нь телевиз, радиог ашигладаг байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны нэг гаруй нь л хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан. Ажилтнуудын дөнгөж хорин хүний нэг нь л хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт оролцох нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй зэрэг хамааралтай байна.

Хэдийгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн тоо бага байгаа ч, тэдний ихэнх нь төсөл, хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүнд хүрсэн гэж хариулсан. Хамгийн их дурдагдсан үр ашиг нь ажил, үйлчилгээгээ өргөжүүлж, борлуулалтыг нэмэгдуулсан байв. Харин тавны нэг орчим нь ямар ч үрашиг хүртээгүй гэж мэдээлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хамгийн их дурдагдсан сул тал бол санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал байсан гэжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй хүмүүсийн ихэнх нь мэдээлэл аваагүйгээс болсон гэж хариулсан бол тавны нэг орчим нь шаардлага хангаагүй гэж хариулсан байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны долоо орчим нь төрөөс ямар нэгэн дэмжлэг авах шаардлагатай гэж хариулсан бөгөөд хамгийн их дурдагдсан дэмжлэг нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, бичил бизнесийн зээл, гарааны бизнесийг дэмжих дэмжлэг зэрэг байв. Төрөөс ямар нэгэн дэмжлэг хэрэгтэй гэж хариулсан оролцогчдын тал хувь нь бизнес эрхлэх сургалт хэрэгцээтэй байгааг дурджээ.

Нэмэлт статистик дүн шинжилгээгээр дараах зүйлийг харуулав. Үүнд:

Дараах бүлгүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаарх мэдлэг харьцангуй бага байсан:

- ▶ залуучууд;
- ▶ эмэгтэйчүүд;
- ▶ дээд боловсролгүй;
- ▶ ажилчид;
- ▶ худалдаа засвар, тээвэр, бусад үйлчилгээний салбарынхан.

БҮЛЭГ 5. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ДЭХ ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Цар тахал албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтэд их нөлөө үзүүлсэн, одоо ч үзүүлж байна. Урт хугацаатай хөл хорио хүмүүсийг орлогогүй болгож, цөөнгүй тохиолдолд тэдэнд түрээсээ төлөх, зээлээ төлөх, хэрэглээ буурах, худалдан авагчгүй болох гэх мэт бэрхшээлүүд тохиолдож байна. Энэ бүлэгт дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил, бизнесийн үйл ажиллагаанд цар тахал хэрхэн нөлөөлсөн;
- эдгээр ажилчдад тулгарч буй тодорхой бэрхшээл;
- хүлээн авсан дэмжлэг туслалцаа;
- цаашид шаардлагатай дэмжлэг.

5.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БА ЭДИЙН ЗАСГИЙН НЭГЖИД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Цар тахлын албан бус хөдөлмөр эрхлэлтэд үзүүлсэн нөлөөллийн судалгаагаар Ковид-19 албан бус салбарын оролцогчдод онцгой хүндээр тусчээ гэж дүгнэсэн байна (Franziska Ohnsorge and Shu Yu, 2021). Албан бус салбарын ажилчид албан ёсны салбарын ажилчдаас бага цалинтай, санхүүжилт, нийгмийн хамгаалалд хамрагдах боломж багатай байдаг (Loayza, 2018; Perry et al, 2007) бөгөөд албан бус бизнесийн хувь түгээмэл байдаг ихэвчлэн хөл хөдөлгөөн ихтэй нөхцөлд ажиллаж, амьдарч, бүх гүйлгээг бэлэн мөнгөөр хийдэг нь өвчний тархалтыг өдөөх хүчин зүйл болдог (Chodorow-Reich et al, 2020; Surico, Galeotti 2020).

Харин албан бус нэгжүүд нь хөдөлмөр их шаарддаг үйлчилгээний салбарт илүү зонхилох хандлагатай байдаг бөгөөд нийгмийн харилцааг хязгаарлах арга хэмжээ тэдэнд хүндээр туссан. Хөгжих буй орнуудын үйлчилгээний салбарын 72.0 орчим хувь нь албан бус байдаг бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 33.0 хувьтай байдаг (Amin, Ohnsorge, Okou, 2019).


Манай судалгаанд оролцсон албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 53.9 хувь нь судалгааны мэдээлэл цуглувалалтын 7 хоногт ажил, бизнесээ эрхэлсэн бол 46.1 хувь нь цар тахлын хөл хорио болон бусад шалтгаанаар ажил, бизнесээ эрхлээгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь авч үзвэл, албан бус салбарт ажилтнуудын 49.4 хувь, ХХЭ-ийн 50.3 хувь, ажил олгогчдын 57.6 хувь нь тухайн хугацаанд ажил, бизнесээ эрхэлж байсан байна. Ажил, бизнесээ эрхлээгүй байсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 51.2 хувь нь тогтмол ажилтай ч тухайн хугацаанд ажлаа хийгээгүй байсан. Энэ нь засгийн газрын хөл хорионы улмаас ажил, бизнесээ хэвийн явуулах боломжгүй болсонтой холбоотой.

ЭДИЙН ЗАСГИЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан ажил үйлчилгээнд нь өөрчлөлт гарсан эсэхийг судалгааны үед ажил хөдөлмөр эрхэлж байсан оролцогчдоос тодруулахад 73.4 хувь нь үйл ажиллагаа буурсан, 11.9 хувь нь түр хугацаанд хаасан гэжээ (Зураг 57).

Зураг 57.

► **Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан аж ахуйн нэгж/ажлын байрны үйл ажиллагааны өөрчлөлт /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл ялгаатай байгаа нь ажиглагдлаа (Хүснэгт 25). Бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн (67.1 хувь), дараа нь боловсруулах үйлдвэрлэл (61.1 хувь), "бусад үйлчилгээ" салбарт (60.5 хувь) үйл ажиллагаа буурсан байх магадлал өндөр байна. Харин түр хаагдсан гэж мэдээлэх нь зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээ (28.9 хувь), бусад үйлчилгээ (28.6 хувь), боловсруулах үйлдвэрлэлд (21.2 хувь) хамгийн өндөр байв. Тээвэр, агуулахын үйл ажиллагааны ажилчдын тавны нэг, барилгын салбарын 16.3 хувь, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарын 16.2 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон гэжээ.

► **Хүснэгт 25. Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар /хувь/**

ЭЗҮА-ны салбар	Үйл ажиллагаа буурсан	Түр хугацаанд хаасан	Өөрчлөлт ороогүй	Сайжирсан/ өссөн	Үйл ажиллагаа бүрэн зогссон	Ажилгүй болсон
Боловсруулах үйлдвэрлэл	61.1	21.2	6.9	0.5	8.3	2.0
Барилга	51.2	18.7	8.9	0.0	16.3	4.9
Бөөний болон жижиглэн худалдаа	67.1	19.1	6.4	0.3	6.4	0.7
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	45.8	20.3	7.3	0.0	20.2	6.5
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний	50.0	28.9	3.8	1.1	16.2	0.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	60.5	28.6	1.6	0.0	6.3	3.0
Бусад	47.3	18.5	14.9	0.0	14.5	4.9

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хүнсний худалдаа эрхлэгчдээс бусад ажил бизнес эрхлэгчдийн хувьд цар тахал ихээхэн бэрхшээл учруулж буйг өмнө нь дурдсан. Жишээ нь улирлын чанартай бэлэн хувцас зардаг иргэд зээл аваад өвлүүн хувцас татсан, хөл хорио тогтоогоод бараа зарж чадаагүй, улирал нь дууссан, хавар бараагаа дахин татсан ч 4 дүгээр сард дахин хөл хорио тогтоосон учир борлуулалт байхгүй болсон байна. Үйл ажиллагаа явуулаагүй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд гудамж, захын худалдаа эрхлэгч, гар урлал түүнтэй холбоотой ажил эрхлэгч, оёдлын үйл ажиллагаа эрхлэгч, ачаа, хүн тээврийн үйлчилгээ эрхлэгчид түлхүү байна.

Цар тахлын үед үйл ажиллагаагаа явуулаагүй, түр зогссон эсвэл үйл ажиллагаа явуулахаа больсон албан бус хөдөлмөр эрхлэгчдийг оноор нь харахад түр хугацаанд хаасан иргэдийн 46.3 хувь нь 2020 оноос, 53.7 хувь нь 2021 оноос үйл ажиллагаа эрхлэхээ зогсоосон байна.

Царт тахлын үед ажил хөдөлмөр эрхлээгүй, ажлаа бүрэн зогсоосон эсвэл бизнесээ хаасан иргэдийн 72.7 хувь нь 2020 онд, 27.3 хувь нь 2021 онд ажлаа зогсоосон байна. Ажилгүй болсон иргэдийн 67.2 хувь нь 2020 онд, 32.8 хувь нь 2021 онд ажлаа алдсан байна (Хүснэгт 26).

► **Хүснэгт 26. Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан аж ахуйн нэгж/ажлын байрны үйл ажиллагааны түвшний өөрчлөлт, оноор /хувь/**

Он	Түр хугацаанд хаасан	Үйл ажиллагаа бүрэн зогссон	Ажилгүй болсон
2020	46.3	72.7	67.2
2021	53.7	27.3	32.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.


Судалгааны үед ажил үйлчилгээгээ явуулж байгаа болон хөл хорионоос болоод ажил үйлчилгээгээ явуулаагүй ч тогтмол ажилтай байгаа албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 98.0 хувь нь Ковид-19 цар тахлаас өмнө хийж байсан ажил, үйлчилгээгээ өөрчлөлтгүй хийж байгаа гэж хариулсан.

ЦАР ТАХЛЫН АЖЛЫН ЦАГ БА ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Судалгаанд цар тахлын үеэс өмнөх (2020 оны 1-р сараас өмнө) болон судалгааны хугацаанд (2021 оны 4-р сард) ижил ажил хийж байсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дундаж ажлын цагийг харьцуулахад долоо хоногийн дундаж ажлын цаг 6-7 цагаар буурсан байна (Зураг 58).

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар бага зэрэг ялгаа ажиглагдсан бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажил олгогчид ажлын цаг арай илүү буурсан байна. Хүйс, ажил эрхлэлтийн байдлаас нь авч үзвэл эмэгтэйчүүдийн ажлын цаг нь ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд илүү буурсан боловч ажил олгогчдын бага хэмжээгээр буурчээ.

► **Зураг 58.
7 хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, хүйсээр /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Долоо хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлтийг бүс, хөдөлмөр эрхлэлтийн статусаар тодруулахад зарим мэдэгдэхүйц ялгаа гарчээ (Хүснэгт 27). Хангайн бүсийн ажлын цаг ажилтнуудын хувьд 9 цагаар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 10 цагаар, ажил олгогчдын хувьд 12 цагаар буурсан байна.

► Хүснэгт 27. Долоо хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, бүс, ХЭ-ийн статусаар /цаг/

Бүс	Ажиллагч			ХХЭ			Ажил олгогч		
	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт
Баруун	64	65	0	57	52	-5	57	52	-5
Хангайн	55	46	-9	54	44	-10	59	48	-12
Төвийн	57	54	-3	60	52	-7	64	57	-6
Зүүн	83	76	-7	56	51	-6	59	55	-5
Улаанбаатар	60	53	-7	57	51	-6	61	55	-6
Бүгд	59	53	-6	57	50	-7	61	54	-7

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил мэргэжлээр нь авч үзвэл, тавилга болон модон эдлэлийн мужааны чиглэлийн ажилтнуудын долоо хоногийн ажлын цаг хамгийн ихээр буюу дунджаар 17 цагаар буурчээ. Мөн тавилга болон модон эдлэлийн мужааны чиглэлийн ажил үүрэг гүйцэтгэдэг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн долоо хоногийн ажлын цаг дунджаар 11 цагаар, машин, механизмын засвар, цай хоол байр буудлаар үйлчлэх чиглэлийн ажил үүрэг гүйцэтгэдэг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 10 цагаар буурсан байна (Хүснэгт 28).

Барилгын засал, будаг гагнуурын чиглэлийн ажилчдад мөн хүнд туссан ба тэдний долоо хоногийн ажлын цаг дунджаар 16, зорчигч болон ачаа тээврийн чиглэлийн ажил үүрэг гүйцэтгэдэг ажил олгогчдын ажлын цаг 15 цагаар буурсан байна.

► Хүснэгт 28. Цар тахлын өмнөх үеэс цар тахлын үеийн 7 хоногийн ажлын цагийн өөрчлөлт, ажил үүрэг, ХЭ статусаар /хувь/

Ажил, үүрэг	Ажиллагч			ХХЭ			Ажил олгогч		
	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт
Барилгын засалчин, будагчин гагнуурчин	62	55	-7	55	55	-1	66	50	-16
Зорчигч болон ачаа тээвэр	62	58	-4	59	52	-6	62	47	-15

Машин, механизмын засварчин	69	64	-5	58	49	-10	64	54	-10
Оёдол, гар урлал, дархан	57	51	-7	52	47	-6	57	49	-8
Мужаан, тавилга болон модон эдлэлийн	62	44	-17	51	40	-11	61	53	-8
Үсчин, гоо сайханч	58	52	-6	54	47	-7	59	52	-7
Жижиглэн болон бөөний худалдаа	58	51	-7	58	52	-6	61	55	-6
Цай хоол байр буудлаар үйлчлэх	53	52	-1	52	42	-10	62	57	-5
Бусад	57	52	-5	54	49	-5	59	54	-5
Бүгд	59	53	-6	57	50	-7	61	54	-7

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, ажлын цагийн хувьд хамгийн их өртсөн нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд (есөн цагаар буурсан), барилгын салбарын хувиараа хөдөлмөр эрхлэгчид (найман цагаар буурсан), барилгын салбарын ажил олгогчид (15 цагаар буурсан), мөн тээвэр, агуулахын салбарын ажил олгогчид (12 цагаар буурсан) байв. Хүснэгт 29-г үзнэ үү.

► **Хүснэгт 29. Цар тахлын өмнөх үеэс цар тахлын үеийн 7 хоногийн ажлын дундаж цагийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар /цаг/**

ЭЗҮСалбар	Ажиллагч			ХХЭ			Ажил олгогч		
	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт
Барилга	64	57	-7	62	54	-8	69	54	-15
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	62	57	-5	58	53	-5	58	47	-12
Боловсруулах үйлдвэрлэл	57	48	-9	53	46	-6	58	51	-7
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	63	66	3	48	44	-4	63	56	-7
Үйлчилгээний бус үйл ажиллагаа	58	54	-4	53	46	-7	59	52	-7
Бөөний болон жижиглэн худалдаа	57	50	-7	58	51	-7	61	55	-6
Бусад	56	50	-6	57	47	-10	56	50	-6
Бүгд	59	53	-6	57	50	-7	61	54	-7

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Мөн цар тахлын өмнөх болон цар тахлын үед ажиллаж байсан ажилчдын цалин буюу цэвэр орлогыг харьцуулсан (Зураг 59). Ажилтнуудын дундаж цалин 380,400 төгрөгөөр (40.2 хувиар) буурсан байна. Харин цэвэр орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 797,100 төгрөгөөр (55.3 хувь), ажил олгогчдын хувьд 1,253,600 төгрөгөөр (57.1 хувиар) буурсан байна.

Эрэгтэй ажилчдын цэвэр орлого дунджаар илүү их хэмжээгээр буурсан харагдаж байна: эрэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн цэвэр орлого 825,200 төгрөгөөр буурсан бол эмэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого 776,800 төгрөгөөр буурсан байна. Харин эрэгтэй ажил олгогчдын цэвэр орлого 1,372,400 төгрөгөөр буурсан бол эмэгтэй ажил олгогчийн цэвэр орлого 1,162,100 төгрөгөөр буурчээ.

Зураг 59.
► Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн цалин эсвэл цэвэр орлогод үзүүлсэн нөлөө, ХЭ-ийн статусаар /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсээр харахад хангайн болон Улаанбаатарын албан бус салбарт ажилтнууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн цалин, орлого хамгийн их буюу 400 гаруй мянган төгрөгөөр буурчээ. Харин Улаанбаатар, баруун, хангайн бүсийн ажил олгогчдын бизнесийн цэвэр орлого бүр ч огцом буюу 1.1-1.4 сая төгрөгөөр буурсан нь бусад бүстэй харьцуулахад хамгийн өндөр байна.

Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд, оёдол, гар урлал, дархан, барилгын засал, будаг, гагнуурын чиглэлийн ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтнуудын цалин хамгийн их буюу 500 гаруй мянган төгрөгөөр буурчээ. Харин ажил олгогчдын бизнесийн цэвэр орлогод гарсан өөрчлөлтийг авч үзвэл мужаан, тавилга болон модон эдлэл, машин, механизмын засвар, барилгын засал, будаг, гагнуурын чиглэлийн бизнес эрхлэгчдийн сарын дундаж орлого хамгийн их буюу 1.5 саяас дээш төгрөгөөр буурсан байна.

Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар бизнесийн орлогод гарсан өөрчлөлтийг харахад барилгын салбарын ажил олгогчдын орлого 2131.6 мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчдын орлого 1345.0 мянга, барилгын салбарын хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого 1,329,7 мянган төгрөгөөр буурсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Үүнийг Хүснэгт 30-с дэлгэрүүлэн үзнэ үү.

► Хүснэгт 30. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогод үзүүлсэн нөлөө, ХЭ-ийн статус, ЭЗҮА-ны салбараар /мян.төг/

ЭЗҮСалбар	Ажиллагч			ХХЭ			Ажил олгогч		
	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт	Цар тахлын өмнө	Цар тахлын үеийн	Өөрчлөлт
Барилга	1 415.9	853.7	-562.2	2 249.1	919.4	-1 329.7	2 915.7	784.1	-2 131.6
Боловсруулах үйлдвэрлэл	933.5	572.0	-361.5	969.7	419.1	-550.6	2 148.4	803.3	-1 345.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1 204.5	706.2	-498.4	1 480.7	960.3	-520.4	2 807.7	¹ 488.9	-1 318.8
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	738.0	400.1	-337.8	1 336.7	1 062.7	-274.0	2 156.8	866.8	-1 290.0
Бөөний болон жижиглэн худалдаа	704.6	450.9	-253.7	1 488.1	650.4	-837.7	2 231.2	¹ 038.1	-1 193.2
Үйлчилгээний бус үйл ажиллагаа	1 127.3	527.2	-600.1	975.3	422.6	-552.7	1 437.7	491.2	-946.4
Бусад	1 049.8	606.6	-443.2	3 221.2	742.8	-2 478.4	2 187.1	980.1	-1 207.0
Бүгд	947.4	567.0	-380.4	1 442.1	645.0	-797.0	2 197.1	943.6	-1 253.6

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хэрэв албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувь хүний цалин буюу цэвэр орлогын оронд өрхийн сарын дундаж орлогод үзүүлэх нөлөөллийг авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн орлого хамгийн огцом буурсан байна (53.6 хувиар буюу 975,000 төгрөгөөр). Харьцуулбал, ажил олгогчдын өрхийн сарын дундаж орлого 47.7 хувиар (963.200 төгрөг) буурсан бол ажилтнуудын өрхийн орлого 40.5 хувиар (514.800 төгрөг) буурчээ. Зураг 60-д харуулав.

Үүнд цалин/цэвэр орлогын харьцуулалт хийсэн шиг цар тахлын үед ажил эрхэлж буй иргэдийн өрх биш, нийт өрх хамрагдаж байгааг анхаарна уу. Хөдөлмөр эрхлэлтийн статусыг цар тахлын өмнөх мэдээлэлд үндэслэн авсан.


Зураг 60.
 ► Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн орлогын өөрчлөлт, ХЭ-ийн статус, /хувь, мянган төгрөгөөр/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Албан бус хөдөлмөр эрхэлдэг нийт өрхөд эзлэх хувийн жинд 11.6 хувь нь өрхийн орлого 25 хүртэл хувиар буурсан; 28.9 хувь нь өрхийн орлого 25-50 хувиар буурсан; 30.1 хувь нь өрхийн орлого 50-75 хувиар буурсан; 21.4 хувь нь өрхийн орлого 75-100 хувиар буурсан гэж хариулжээ. Үлдсэн найман хувь нь өрхийн орлого буураагүй гэж хариулсан байна.

Зураг 61.
 ► Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өрхийн орлогод гарсан өөрчлөлт / хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

5.2 ТУСЛАМЖИЙН ТӨРӨЛ, ЭХ СУРВАЛЖ, ҮР НӨЛӨӨ

Цар тахлын үед амьжиргааны зардлаа хангахад өрхийн орлого нь хүрэлцээтэй байгаа эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын 50.9 хувь нь хүрэлцээтэй, 49.1 хувь нь хүрэлцээгүй байна гэжээ. Эдийн засгийн салбараар, бөөний болон жижиглэн худалдааны салбар, бусад салбарын албан бус хөдөлмөр эрхлэгчдээс бусад салбарт дийлэнх нь цар тахлын үед амьжиргааны зардлаа хангахад өрхийн орлого нь хүрэлцээгүй байгааг илэрхийлжээ (Зураг 62). Гэхдээ бөөний болон жижиглэн худалдааны салбар, бусад салбарт ч 50 орчим хувь нь өрхийн орлогоо хүрэлцэхгүй гэж үзжээ.

Зураг 62.

► Амьжиргааны зардлаа хангахад өрхийн орлого нь хүрэлцээтэй эсэх, ЭЗҮА-ны салбараар /хувь/




Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Тусlamж, дэмжлэг авсан иргэдийн нийт дүнгээс, 37.8 хувь нь амьжиргааны хэрэгцээний зардлаа хангахад шаардлагатай тусlamж авсан бол 62.2 хувь нь шаардлагатай тусlamж аваагүй гэжээ.

Тусlamж, дэмжлэг авсан иргэдийн 93.7 хувь нь санхүүгийн дэмжлэг, 8.6 хувь нь хүнсний хангамж, 3.2 хувь нь хамгаалах хэрэгслийн дэмжлэг авсан байна. Ажилтнуудын багахан хэсэг нь санхүүгийн тусlamж авсан гэж мэдээлсэн. Эдгээр мэдээллийг хүснэгт 63-т танилцуулав.

► **Зураг 63.**
Авсан тусlamж, төрөл, хөдөлмөр эрхлэлтийн статусаар /хувь/



■ Санхүүгийн тусlamж ■ Хүнсний хангамж ■ Хамгаалах хэрэгслийн дэмжлэг

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Санхүүгийн болон хамгаалалтын хэрэгслийн тусlamж авсан иргэн дийлэнх нь засгийн газраас авсан байна. Хүнсний тусlamж авсан иргэдийн олонх нь найз нөхөд, хамаатан саднаасаа авдаг.

► **Хүснэгт 31. Санхүүгийн дэмжлэг, төрөл, эх сурвалжаар /хувь/**

Эх сурвалж	Санхүүгийн тусlamж	Хүнсний хангамж	Хамгаалах хэрэгслийн дэмжлэг
Засгийн газар	86.9	39.1	61.6
Орон нутгийн захиргаа	1.7	16.6	25.9
Ажил олгогч	0.9	2.3	17.4
Төрийн бус байгууллага/хандив	0.6	5.4	2.8
Найз нөхөд/хамаатан садан (өрхийн гишүүн биш)	11.9	42.2	27.5
Бусад	3.9	25.2	25.5

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

5.3 ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Судалгаанд албан бус хөдөлмөр эрхлэгчдээс тэдний амьжиргаа, бизнест нь засгийн газраас хэрэгжүүлсэн цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан гарч байгаа хүндрэлийг үнэлүүлсэн (хүснэгт 32). Дийлэнх нь тэдний амьжиргааг дараах байдааар хүндрүүлсэн эсвэл маш хүндрүүлсэн гэж хариулжээ. Үүнд:

- ажлын болон бизнесийн үйл ажиллагааны цагийг багасгах;
- ажил, бизнесээ түр хугацаагаар, бүр бүрмөсөн зогсоох;
- цалин эсвэл орлого буурах;

- ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийн үнийн өсөлт;
 - зайлшгүй шаардлагатай түүхий эдийн нийлүүлэлт тасалдах;
 - бизнес, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хүндрэл учруулах.
- **Хүснэгт 32. Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан хүндрэл / хувь/**

Хүндрэл	Огт хүндрэлгүй	Хүндрэлгүй	Дунд зэргийн хүндрэлтэй	Хүндрэлтэй	Маш хүндрэлтэй	Бүгд
Ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаанд	2.9	3.7	15.3	26.8	51.3	100.0
Ажил, бизнес түр зогсох	3.2	5.1	13.0	25.3	53.4	100.0
Ажлаа бүрэн алдсан, ажил үйлчилгээ зогссон	8.1	10.4	17.7	21.5	42.2	100.0
Цалин, орлого буурсан	2.2	3.2	12.3	27.1	55.3	100.0
Түүхий эдийн үнэ нэмэгдсэн	5.0	5.7	17.1	28.2	44.0	100.0
Ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийг	9.6	7.3	16.2	25.9	41.1	100.0
Бизнес, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад	15.9	7.9	16.1	25.0	35.1	100.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажил олгогчид ерөнхийдөө хүндрэлийн түвшин илүү өндөр байгааг мэдээлсэн (хүснэгт 33). Бүх тохиолдолд хамгийн их тулгардаг бэрхшээл нь цалин, орлого буурах, ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаа багассан явдал байв.

- **Хүснэгт 33. Ковид -19-с сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалсан хүндрэл (дундаас маш хүнд хүртэл хосолсон), ХЭ статусаар /хувь/**

Хүндрэл	Ажилтан	ХХЭ	Ажил олгогч	Бүгд
Ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаанд	89.9	93.9	93.5	93.4
Ажил, бизнес түр зогсох	86.5	93.5	90.9	91.7
Ажлаа бүрэн алдсан, ажил үйлчилгээ зогссон	77.8	83.2	80.5	81.5
Цалин, орлого буурсан	88.4	95.7	94.6	94.6
Түүхий эдийн үнэ нэмэгдсэн	77.2	89.9	90.6	89.3
Ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийг	61.1	85.0	84.7	83.1
Бизнес, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад	57.6	76.7	78.3	76.1

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

5.4 ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАМРАГДАЛ БА ҮР ДУНГИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ хэсэгт Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хамрагдсан байдал, түүний үр ашгийг тодорхойлсон юм.

ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭ

Албан бус хөдөлмөр эрхлэгчид (эсвэл тэдний ажиллаж байсан аж ахуйн нэгж) дараах арга хэмжээнүүдэд хамрагдсан гэж мэдэгдсэн. Үүнд:

- ▶ цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээнд 98.6 хувь;
- ▶ хүүхдийн мөнгөн тэтгэмж (100000 төг) арга хэмжээнд 71.7 хувь;
- ▶ зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан арга хэмжээнд 21.0 хувь;
- ▶ НДШ-ийг бүрэн тэглэсэнд 14.4 хувь;
- ▶ орлогоос шалтгаалан ААНОАТ авахгүй чөлөөлсөн арга хэмжээнд 5.5 хувь;
- ▶ цалингаас орлогын албан татвар авахгүй чөлөөлсөн арга хэмжээнд 2.6 хувь.

Төрөөс авч хэрэгжүүлсэн нийтийг хамарсан арга хэмжээнүүдэд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хамрагдалт өндөр байгаа ч, фокус бүлгийн ярилцлагад оролцсон мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар зарим тусламж, дэмжлэгт хамрагдах шаардлагыг хангаж чадахгүй байгаа юм. Учир нь албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалд хамрагдаагүй тул өмнө нь бүртгүүлсэн байхыг шаарддаг засгийн газрын зарим арга хэмжээний үр шимийг хүртэх боломжгүй, зохион байгуулалтгүй тул санаа зовоосон асуудлаа засгийн газарт шууд хүргэх боломжгүй байдаг. Тиймээс цар тахлаас үүдсэн хүндрэлд хамгийн их өртсөн.

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл мэдэгдэхүйц ялгаа гэвэл нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэсэн (албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тодорхойлолтоос үзвэл ийм үр дүн хүлээгдэхээр байгаа), зээлийн төлбөрийг хойшлуулсан, ААНОАТ-аас чөлөөлсөн арга хэмжээнээс ажилтнууд ашиг бага хүртсэн байна. Харин хүүхдийн мөнгөн тэтгэмж ажилтнуудад илүү их өгөөжтэй байсан бололтой.

► **Хүснэгт 34. Эдийн засгийг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээнд хамрагдсан байдал, ХЭ статусаар /хувь/**

Арга хэмжээ	Ажилтан	ХХЭ	Ажил олгогч	Бүгд
НДШ-ийг бүрэн тэглэсэн	10.1	20.8	13.6	14.4
Цалингаас орлогын албан татвар авахгүй чөлөөлсөн	2.9	2.0	2.7	2.6
Орлогоос шалтгаалан ААНОАТ авахгүй чөлөөлсөн	2.0	5.1	5.8	5.4
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	77.9	68.9	71.6	71.7
Цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэсэн	97.6	99.5	98.5	98.6
Зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан	15.3	25.5	20.7	21.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь эдийн засгийг дэмжсэн засгийн газрын арга хэмжээнүүдийг дараах үр дүнд хүрсэн гэж хариулжээ. Үүнд:

- өрхийн орлогыг дэмжсэн (80.9 хувь);
- ашиглалтын зардал буурсан (60.5 хувь); ба
- цалин, цэвэр орлогыг дэмжсэн (50.2 хувь).
- ажлын байраа хадгалж үлдсэн (37.5 хувь);
- бизнесээ үргэлжлүүлэн хийх боломж олгосон (33.3 хувь);
- гэрээс ажиллах боломжтой болсон (11.9 хувь);
- бараа, түүхий эдийн үнэ тогтвортойсон (8.9 хувь).

Мэдээллийг Зураг 64-т танилцуулав.

► **Зураг 64.
Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн /хувь/**



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажил олгогчдыг бодвол ажлаа хадгалах боломж олгох, гэрээсээ ажиллах боломжтой болгох, цалинг дэмжих, тэр ч байтугай хэрэглээний зардлыг бууруулах зэрэг зарим арга хэмжээг үр дүн багатай гэж үнэлсэн нь анхаарал татаж байна (Хүснэгт 35).

► Хүснэгт 35. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн , ХЭ статусаар /хувь/

Үр дүн	Ажиллагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Ажил олгогч	Бүгд
Цалин, цэвэр орлогыг дэмжсэн	45.0	49.8	51.2	50.2
Өрхийн орлогыг дэмжсэн	80.7	83.2	79.1	80.9
Бараа, түүхий эдийн үнэ тогтвортойсон	7.7	9.3	8.8	8.9
Ажлын байраа хадгалж үлдсэн	20.6	36.4	40.8	37.5
Гэрээс ажиллах боломжтой болсон	5.7	12.0	12.7	11.9
Ашиглалтын зардал буурсан	49.5	60.7	61.9	60.5
Бизнесээ үргэлжлүүлэн хийх боломжтой	11.8	32.2	37.3	33.3

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харахад барилгын салбарын албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд бусад салбартай харьцуулахад өрхийн орлогыг дэмжсэн, цалин, цэвэр орлогыг дэмжсэн, ашиглалтын зардал буурсан зэрэг арга хэмжээ илүү үр ашигтай байжээ. Гэрээсээ ажиллах боломжтой болгосноор арга хэмжээ үр дүнтэй болсон гэж боловсруулах үйлдвэрлэлийн салбарын албан бус хөдөлмөр эрхлэгчид үзэж байна.

Ажил мэргэжлээр нь авч үзвэл жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчид, оёдол, гар урлал, дархан, мужаан, тавилга болон модон эдлэлийн чиглэлийн ажил эрхлэгчдийн хувьд ажлын байраа хадгалж үлдэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээ илүү үр дүнтэй байсан. Харин оёдол, гар урлал, дархан, мужаан, тавилга болон модон эдлэлийн чиглэлийн ажил эрхлэгчдийн хувьд гэрээсээ ажиллах боломж бусдаасаа илүү үр дүнтэй байсан байна (хүснэгт 36).

▶ Хүснэгт 36. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн /хувь/

Үр дүн	Цай хоол байр буюцаар үйлчлэх	Үсчин, гоо сайханч	Жижиглэн болон бөөний худалдаа	Барилгын засалчнын, будагчин	Оёдол, гар Урлал, Дархан	Машин, механизмын засварчин	Мужаан, тавилга болон модон эдлэлийн	Зорчигч болон ачаа тээвэр	Бусад	Бүгд
Цалин, цэвэр орлогыг дэмжсэн	53.7	54.5	50.9	56.2	50.7	48.0	55.3	48.2	44.5	51.0
Өрхийн орлогыг дэмжсэн	80.2	86.9	81.5	86.6	83.2	78.4	86.0	82.7	80.3	82.3
Бараа, түүхий эдийн үнэ тогтвортойсон	9.7	5.9	9.6	9.9	8.9	2.4	10.7	9.3	7.8	9.1
Ажлын байраа хадгалж үлдсэн	38.1	37.5	40.7	24.2	42.3	32.7	43.0	27.9	28.0	38.1
Гэрээс ажиллах боломжтой болсон	9.9	1.3	8.4	10.6	27.1	17.3	26.0	7.3	11.5	12.1
Ашиглалтын зардал буурсан	58.8	60.3	63.9	48.4	62.9	62.8	64.3	55.4	54.6	61.5
Бизнесээ үргэлжлүүлэн хийх боломжтой	32.0	26.7	36.8	20.0	35.5	28.0	49.0	23.5	25.1	33.8

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

5.5 ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (АЖИЛ ОЛГОГЧ БА ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД)

Цар тахлаас сэргийлэх арга хэмжээний дараа ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 95.8 хувь нь ажил үйлчилгээгээ үргэлжлүүлэн явуулах бодолтой байгаагаа илэрхийлсэн. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 61.4 хувь нь хөнгөлөлттэй зээл, 42.0 хувь нь зээлийн хүү бууруулах, 26.1 хувь нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг дэмжлэгийг төр, засгаас хүссэн байна. Зураг 65-аас үзнэ үү.


► **Зураг 65.**
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дэмжлэгийн хэрэгцээ /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Судалгаагаар мөн цар тахлаас шалтгаалан цаашид тулгарч болзошгүй гэж үзэж буй бэрхшээлийг тодруулсан юм (Зураг 66). Дийлэнх нь (65.0 хувь) санхүүгийн хомсдол, дараа нь бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт бага (26.7 хувь), түүхий эд материалын үнэ өндөр (23.6 хувь) зэргийг дурдажээ.

► **Зураг 66.**
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд цар тахлын үед цаашид тулгарч болзошгүй бэрхшээл /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсийн түвшинд санхүүгийн Эх сурвалж дутагдаж байна гэж дурдсан иргэд бусад бүстэй харьцуулахад зүүн бүсэд (77.3 хувь) илүү өндөр, төвийн бүсэд (50.6 хувь) мэдэгдэхүйц бага байна. Харин баруун болон төвийн бүсийн ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид улсын бусад бүстэй харьцуулахад түүхий эдийн үнэ өндөр байнсныг илүү их нэрлэжээ.

Хүснэгт 37.

► Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд цар тахлын үед цаашид тулгарч болзошгүй бэрхшээл бүсээр /хувь/


Бэрхшээлийн төрөл	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд
Санхүүгийн хомсдол	67.9	67.3	50.6	77.3	66.2	65.0
Түүхий эд материалын үнэ өндөр	39.9	23.3	39.2	22.7	27.9	30.0
Бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт бага	31.5	30.1	19.3	26.2	26.7	26.7
Нийлүүлэлт эсвэл үйлчилгээний хүртээмж муу	33.2	15.3	17.0	13.9	21.3	20.6
Зах зээлд хүрч, нэвтэрч чадахгүй	18.7	19.6	17.9	11.5	15.0	16.4
Дижитал технологи ашиглах чадвар дутмаг	5.7	10.5	6.5	4.6	4.9	6.1
Бусад	17.1	18.5	14.5	7.1	16.9	16.1

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Цар тахлын үед ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад хүндрэлтэй байгаа талаар тодруулахад 31.4 хувь нь хил гааль, ачаа тээврийн үйлчилгээ, бараа түүхий эдийн татан авалттай холбоотой хүндрэл, 14.9 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ, 10.0 хувь нь банкны үйлчилгээ бэрхшээл учруулсан байна (Зураг 67).

Зураг 67.

► Цар тахлын үед бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад тохиолдож буй зонхилох бэрхшээл /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүх бүсэд хил, гааль, тээврийн үйлчилгээтэй холбоотой асуудлаас үүдэн бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэхэд гол бэрхшээлүүд гарсан байна (Хүснэгт 38). Баруун болон төвийн бус болон Улаанбаатар хотод эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байгаа нь хоёрдугаарт бичигдсэн байна. Зүүн бүсийн хувьд банкны үйлчилгээ хоёр дахь хүндрэлтэй асуудал байв.

Хүснэгт 38.

► Цар тахлын үед бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад тохиолдож буй зонхилох бэрхшээл, бүсээр /хувь/

Хүндрэл	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар	Бүгд
Хил гааль, ачаа тээврийн үйлчилгээ, бараа түүхий эдийн татан авалт	36.2	32.8	37.0	39.5	26.7	31.4
Эрүүл мэндийн үйлчилгээ	16.0	8.0	16.1	5.9	17.4	14.9
Банкны үйлчилгээ	7.9	10.0	8.9	14.1	10.5	10.0
Ачаа тээвэр, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт	7.9	6.8	8.6	14.1	8.7	8.5
Хөл, хорио, зорчих хөдөлгөөн, зөвшөөрөл QR код	4.4	10.8	4.1	12.2	5.1	6.1
Бүх төрлийн үйлчилгээ	4.1	9.6	3.8	1.5	5.1	5.2
Хүнсний бүтээгдэхүүн	8.2	3.2	5.5	3.9	4.9	5.1
Төрийн үйлчилгээ	2.8	3.6	3.1	2.0	6.7	4.8
Санхүүгийн хомсдол	4.1	4.8	0.7	2.4	4.2	3.6


Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

5.6 ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ (АЖИЛ ОЛГОГЧ БА ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД)

Судалгаагаар албан бусаар үйл ажиллагаа явуулж буй хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажил олгогчдын 38.6 хувь нь ажил үйлчилгээндээ дижитал технологи ашиглаж байна гэж дүгнэв.

Боловсролын түвшин нэмэгдэх тусам дижитал технологийн хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна (Зураг 68). Дээд боловсролтой иргэдийн талаас илүү нь (52.8 хувь) бизнестээ дижитал технологи ашигладаг. Энэ хувь нь техникийн болон тусгай дунд боловсролтой иргэдийн хувьд 37.8 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн хувьд 32.6 хувь, бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролтой иргэдийн хувьд ердөө 28.2 хувь болж буурчээ.


Зураг 68.
Дижитал технологийн хэрэглээ, боловсролоор /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Харин дижитал технологийн хэрэглээ нь насны бүлгээс урвуу хамааралтай байсан (зураг 69). 15-35 насныхны 54 хувь нь дижитал технологи ашигладаг бол хэрэглээ нь 36-45 насны дунд 41.2 хувь, 46-55 насны дунд 34.6 хувь, 56 ба түүнээс дээш насныханд 23.8 хувь болж буурчээ.


Зураг 69.
Дижитал технологийн хэрэглээ, насаар /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Дижитал технологийн хэрэглээ нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажилласан жилтэй урвуу хамааралтай байсан: бизнес удаан эрхлэх тусам ажилчин дижитал технологийг ашиглах магадлал багасдаг (Зураг 70).


► **Зураг 70.**
Дижитал технологийн хэрэглээ, үйл ажиллагаа явуулсан жилээр /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Ажил мэргэжлээрээ үсчин, гоо сайхны чиглэлийн ажил эрхлэгчид, цай хоол буудлаар үйлчлэх ажилчид, бөөний болон жижиглэнгийн худалдаачид дижитал технологийг хамгийн их ашигладаг байв (Зураг 71). Харин зорчигч, ачаа тээврийн ажилчид, машин механизм засварын ажилчид дижитал технологийг хамгийн бага ашигладаг байна.

► **Зураг 71.**
Дижитал технологийн хэрэглээ, ажил мэргэжил /хувь/



Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Судалгаанд ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс тэдний ашигладаг олон нийтийн цахим сүлжээ болон дижитал технологийн хэрэглээний талаар тодруулсан (Хүснэгт 39). Хамгийн их ашиглагддаг олон нийтийн цахим сүлжээ бол Facebook (74.5 хувьд дунд зэргийн хэрэглээ) болон WeChat (29.3 хувьд дор хаяж дунд зэргийн хэрэглээ) байв. Бусад цахим сүлжээнүүдийн хэрэглээ бага байсан. Дижитал технологийн хувьд дийлэнх нь мобайл мөнгөн гүйлгээ эсвэл ATM (93.8 хувьд дор хаяж дунд зэргийн хэрэглээ), харьцангуй олон нь цахим худалдаа (47.7 хувьд дор хаяж дунд зэргийн хэрэглээ), компьютер (31.2 хувь) ашигладаг байна.

► **Хүснэгт 39. Дижитал технологийн хэрэглээ, төрөл /хувь/**

Дижитал технологийн төрөл	Хэзээ ч үгүй	Заримдаа	Дунд зэрэг	Ихэвчлэн	Үргэлж	Бүгд
Facebook	22.1	2.0	7.9	9.2	57.4	100.0
Twitter	90.2	4.7	2.5	1.1	1.4	100.0
Skype	94.1	3.0	1.4	0.4	1.0	100.0
WhatsApp	94.1	2.7	1.1	0.3	1.7	100.0
WeChat	66.3	4.4	6.8	5.7	16.8	100.0
Instagram	83.5	5.3	4.2	2.7	4.3	100.0
YouTube	83.1	3.0	6.1	4.6	3.2	100.0
Мобайл мөнгө /ATM/	4.5	1.6	5.3	18.1	70.4	100.0
Вэб хуудас	79.0	4.6	4.0	3.0	9.4	100.0
Блог	93.4	3.5	0.7	0.6	1.8	100.0
Цахим арилжаа	47.4	4.8	7.3	12.5	27.9	100.0
Компьютер	63.7	5.1	6.9	4.8	19.5	100.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Бүсээр авч үзвэл, мобайл мөнгө, карт /ATM/-ыг хангайн бүсийн ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 92.6 хувь нь, Улаанбаатарын иргэдийн 69.8 хувь нь, баруун бүсийн иргэдийн 64.5 хувь нь, төвийн бүсийн иргэдийн 64.4 хувь нь, зүүн бүсийн иргэдийн 47.3 хувь нь үргэлж ажил үйлчилгээндээ ашиглаж байна (Хүснэгт 40). Харин цахим арилжааг хангайн бүсийн ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 82.0 хувь нь, Улаанбаатарын 45.0 хувь нь, баруун бүсийн 45.5 хувь нь, зүүн бүсийн 36.0 хувь нь, төвийн бүсийн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 20.7 хувь нь хэрэглэдэггүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил үүргээр нь авч үзвэл үсчин, гоо сайхан, оёдол, гар урлал, дархан, мужаан, тавилга болон модон эдлэлийн чиглэлийн ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд фейсбүүкийн хэрэглээ хамгийн өндөр байна.

► Хүснэгт 40. Дижитал технологийн хэрэглээ, бус /хувь/

Төрөл / түвшин		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар	Бүгд
Мобайл мөнгө/ ATM	Хэзээ ч үгүй	5.0	0.8	4.6	9.3	4.7	4.5
	Заримдаа	1.7	0.0	1.1	1.3	2.1	1.6
	Дунд зэрэг	8.3	1.6	3.4	14.7	4.9	5.3
	Ихэвчлэн	20.7	4.9	26.4	27.3	18.4	18.1
	Үргэлж	64.5	92.6	64.4	47.3	69.8	70.4
	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цахим арилжаа	Хэзээ ч үгүй	45.5	82.0	20.7	36.0	45.0	47.4
	Заримдаа	8.3	2.5	5.7	2.7	4.9	4.8
	Дунд зэрэг	4.1	0.8	16.1	14.0	7.2	7.3
	Ихэвчлэн	10.7	0.0	23.0	20.7	13.2	12.5
	Үргэлж	31.4	14.8	34.5	26.7	29.7	27.9
	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Компьютер	Хэзээ ч үгүй	76.9	72.1	39.1	83.3	61.0	63.7
	Заримдаа	3.3	1.6	10.3	4.7	5.4	5.1
	Дунд зэрэг	4.1	0.8	13.8	1.3	8.5	6.9
	Ихэвчлэн	1.7	0.0	8.0	4.0	6.0	4.8
	Үргэлж	14.0	25.4	28.7	6.7	19.1	19.5
	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж. 2021 оны Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг ашигласан зохиогчдын тооцоо.

Шигтгээ 3

Цар тахлын үеийн албан бус хөдөлмөр эрхлэлт

Цар тахлын үеийн албан бус хөдөлмөр эрхлэлтийн эмзэг байдал

Цар тахлын энэ үед албан бус хөдөлмөр эрхлэгчид, өргөн утгаараа албан бус эдийн засагт ажиллагчид илүү эрсдэлтэй нөхцөлд байна.

- Ихэвчлэн бага орлоготой учраас хадгаламжтай байх магадлал багатай бөгөөд ажил, орлогоо гэнэт алдсан тохиолдолд ядуурал, өлсгөлөнд илүү амархан автах эрсдэлтэй гэсэн үг.
- Цар тахлын болон, цар тахлын эсрэг арга хэмжээнд илүү ихээр өртөх үйл ажиллагаа, ажил мэргэжил эрхэлж байх магадлал өндөр байдаг.
- Албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн хамгааллын тогтолцооны гадна үлдсэн байдаг.
- Ихэнх нь засгийн газрын мэдээллийн санд бүртгэлгүй тул тусlamж, дэмжлэгт хамрагдах боломж хязгаарлагдмал.

Улс орнуудад цар тахал, хорио цээрийн хөл хорионоос улбаалан эдийн засгийн ихэнх салбарууд өндөр эрсдэлтэй байгаа бөгөөд тэдгээрт олон мянган албан бус хөдөлмөр эрхлэгчид ажиллаж байна.

Судалгааны тоон өгөгдөл, шинжээчдийн дүгнэлтийн дагуу хамгийн өндөр эрсдэлтэй салбарт зочид буудал, хүнсний үйлчилгээний үйл ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, агуулах, урлаг, үл хөдлөх хөрөнгийн бизнес багтаж байна. ОУХБ-ын мэдээлснээр дэлхийн хэмжээнд эдгээр өндөр эрсдэлтэй салбарт 922 сая албан бус хөдөлмөр эрхлэгчид ажилладаг.

Олон улсад хийгдсэн судалгааны үр дүнгээр албан бус эдийн засгийн салбарын ажилчдад цар тахал янз бүрийн үр дагавар үзүүлж байна. Тухайлбал, ажилгүй болох эсвэл бизнесээ хаах. ОУХБ-ын саяхны шинжилгээгээр дундаж орлоготой орнуудын албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг ажилтнуудын тоо дунджаар 22 хувиар, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 18 хувиар буурсан байна.

ЗАРИМ ОРНЫ ЖИШЭЭ

Цар тахлын эхэн үед Энэтхэгийн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 44 хувь нь ажилгүй байв. Филиппинд бичил аж ахуйн нэгжийн 23 хувь нь үйл ажиллагаагаа зогсоосны бараг бүгд албан бус салбарынх байна. Тайландад 2020 оны 4-р сарын байдлаар бария засалчид 100 хувь, гудамжны худалдаачдын 55 хувь нь ажилгүй болжээ.

Цар тахлын үед ажлын цагаа/бизнесийн үйл ажиллагаагаа багасгах явдал түгээмэл тохиолдож байна. Жишээнбэл, Филиппинд бичил аж ахуйн нэгжийн 19% нь ажлын цагаа багасгасан.

Цар тахал албан бус хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй өөр нэг хэлбэр нь орлогоо алдах. Тайланд, Индонезийд зэрэг орнуудад албан бус салбарын ажилчдын орлого 70-80 хувь хүртэл буурсан гэж тэмдэглэгджээ.

Өлслөлөн нэрвэгдэх тохиолдож байна. Тайландад бария засалчдын 19%, мотоциклийн жолооч нарын 18% нь өлсгөлөнд нэрвэгдсэн гэж мэдээлжээ. Филиппинд өрхийн бичил бизнес эрхлэгчдийн 31% нь өлсгөлөнд нэрвэгдсэн байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид цар тахлын нөлөөнд хамгийн их хэлмэгдэж байгаа боловч бүх нийтэд олгох мөнгөн тусlamжийг эс тооцвол тэдэнд хүртэх дэмжлэг тусlamж байхгүйтэй адил байна.

Албан бус салбарт ажилладаг учраас ажилтан ажлын байраа хадгалах ерөнхий зохицуулалтад хамрагдах боломжгүй байдаг. Түүнчлэн албан бус хөдөлмөр эрхлэгчид ихэвчлэн ажилгүйдлийн даатгалд хамрагддаггүй. Мөн зээлийн баталгаа, жижиг бизнесийн буцалтгүй тусlamж авах боломж хязгаарлагдмал байдаг.

ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Зарим орны засгийн газар албан бус эрхлэгчдэд чиглэсэн тусгайлсан хариу арга хэмжээ авсан:

- **Мөнгөн тэтгэмж.** Албан бус эдийн засгийн ажилчдад зориулагдсан яаралтай мөнгөн тэтгэмжийг хэдэн сарын хугацаанд олгодог. Үүнийг жишээлбэл Тайланд, Вьетнам, Бангладеш, Перу, Марокко, Египет, Энэтхэгт хэрэгжүүлсэн.
- **Хэрэгцээт бараа бүтээгдэхүүний буцалтгүй тусламж.** Өөр нэг арга хэмжээ бол Руанда, Судан зэрэг оронд хэрэгжүүлсэн хоол хүнс, саван болон бусад хэрэгцээт бараа бүтээгдэхүүний буцалтгүй тусламж юм.
- **Ажилгүйдлийн тэтгэмжийг өргөжүүлэх.** Индонез, Багамын арлуудад ажилгүйдлийн тэтгэмжийг өргөжүүлэн албан бус салбарын ажилчдыг хамруулсан. Цар тахлын өмнө ажилгүйдлийн даатгалд зөвхөн албан салбарын ажилчдыг л хамруулдаг байжээ.
- **Цалин хөлс олгож ажиллуулах хөтөлбөр.** Филиппин улсад засгийн газраас хорио цэрийн улмаас ажилгүй болсон албан бус салбарын ажилчдад цалин хөлс олгож ажиллуулж олон нийтийн цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийн ажил хийлгэн, оролцсон хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хоногт тэнцэх мөнгө олгосон.
- **Хөнгөлөлттэй зээл.** Мексик улс ихэвчлэн албан бус салбарт ажилладаг бичил аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгож байсан.
- **Бүртгэлийн дүрэм журам.** Ерөнхийдөө дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ямар нэг байдааар бүртгэлжүүлэх шаардлагатай тулгарсан.

Монгол Улсын хувьд дараах үр дүнг тодруулбал сонирхолтой байх болно. Үүнд:

- албан бус ажилчид бусад бүлэгтэй харьцуулахад цар тахалд үнэхээр илүү их өртсөн эсэх;
- засгийн газраас хэрэгжүүлсэн цар тахлын үр нөлөөг бууруулах болон цар тахлын эсрэг арга хэмжээнүүд үр дүнтэй байсан эсэх; ба
- албан бус ажилчдад тусгайлан чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай эсэх.

Эх сурвалж: ASEAN Secretariat (2019); ILO (2004); Bosio et al. (2020) ; CGAP (2020); FAO (2020); ILO (2020); Komin et al. (2021); Octavia (2020); Parisotto (2021); WIEGO (2021).

5.7 НЭМЭЛТ СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар ба боловсролын түвшин цар тахлын үед ажлын байраа алдах үзэгдэлтэй хүчтэй хамааралтай байв. Зочид буудал, бусад (боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбараас бусад аж үйлдвэрийн салбар, түүнчлэн өөрөөр ангилаагүй бусад салбурууд), тээвэр, бусад үйлчилгээ (худалдаа засвар, тээвэр, зочид буудал, байр сууцаас бусад үйлчилгээ), барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын дээд, техникийн мэргэжлийн эсвэл бүрэн дунд боловсролтой иргэд ажилгүй болох магадлал хамгийн өндөр байсан.

Өрхийн орлогод үзүүлэх цар тахлын нөлөөлөл хөдөлмөр эрхлэлтийн статус, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсрол, насын бүлэгтэй хүчтэй хамааралтай байв. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажил олгогчид ажилтнуудаас илүү өртсөн. Зочид буудал, тээвэр, барилга, бусад үйлчилгээний салбарынхан, дээд боловсролтой, 40-49 насын бүлгийн хүмүүсийн өрхийн орлого илүү ихээр өртсөн байна.

Цар тахлын эсрэг арга хэмжээ нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид, тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс (ихэвчлэн зочид буудал, бусад үйлчилгээ), залуу, эрэгтэйчүүдэд ажлын цаг, бизнесийн үйл ажиллагааны цагийг багасгах, ажлаа эсвэл бизнесээ түр эсвэл бүрмөсөн хаах, цалин хөлс бизнесээ бууруулах зэргээр илүү хүндээр туссан байх магадлалтай байв.

Шаардлагатай түүхий эдийн үнийн өсөлт, түүхий эдийн нийлүүлэлтэд тулгарч буй бэрхшээл, бизнесийн болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхой бус байдал хэрхэн нөлөөлж буйг авч үзвэл, цар тахлын эсрэг арга хэмжээ нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч, залуу, дээд боловсролгүй хүмүүст илүү хүнд нөлөөлсөн байх магадлалтай байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх, орлогын албан татвараас чөлөөлөх, цалингаас орлогын албан татвар авахгүй байх зэрэг арга хэмжээнээс хүртэх үр ашиг хүйс, насын бүлэг, хөдөлмөр эрхлэлтийн статусаас хүчтэй хамааралтай байв. Тодруулбал, эмэгтэйчүүд эрчүүдээс илүү үр ашиг хүртсэн магадлалтай байсан; 60 ба түүнээс дээш насын иргэд насын бүлгээрээ үр ашиг хүртэх магадлал хамгийн бага; мөн ажил олгогчид ажилтнуудыг бодвол үр ашиг хүртэх магадлал илүү өндөр байв.

Орлогын албан татвараас түр чөлөөлөгдсөний үр ашиг зөвхөн хүйтэй хамааралтай буюу эмэгтэйчүүд эрчүүдээс бага ашиг хүртэх магадлалтай байсан. Хөдөлмөр эрхлэлтийн статус, эдийн засгийн үйл ажиллагааны салбар ААНОАТ-аас чөлөөлөгдсөнөөс хүртэх үр ашигтай хамааралтай байсан. Ажил олгогчид ААНОАТ-аас чөлөөлөгдсөнөөс үр ашиг хүртэх магадлал нь ажилтнуудаас хамаагүй илүү байсан ба боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхны хувьд үр ашиг хүртэх магадлал нь бөөний болон жижиглэнгийн худалдааныхаас хамаагүй бага байсан.

Нэмэлт шинжилгээгээр цахилгаан, дулаан, усны төлбөрийг тэглэсэн, зээлийн төлбөрийг хойшлуулсан арга хэмжээг хүйс, насын бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбартай ямар хамааралтай байсныг авч үзсэн. Хүйс, насын бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбар хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй хүчтэй

хамааралтай байсан. Тодруулбал, эмэгтэйчүүдийн үр ашиг хүртэх магадлал эрэгтэйчүүдээс бага; 60 ба түүнээс дээш насны иргэд насны бүлгээрээ үр ашиг хүртэх магадлал хамгийн бага; мөн зочид буудал, байр сууцны салбарынхны үр ашиг хүртэх магадлал нь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдээс хамаагүй бага байв.

Цахилгаан, дулаан, усны төлбөрийг тэглэсэн арга хэмжээнээс үр ашиг хүртэх нь аль ч тайлбарлагч хувьсагчтай хамааралгүй байсан, өөрөөр хэлбэл тус арга хэмжээнээс бүгд адилхан үр ашиг хүртсэн гэсэн үг.

Хүйс, насны бүлэг, хөдөлмөр эрхлэлтийн статус нь зээлийн төлбөрийг хойшлуулсан арга хэмжээнээс үр ашиг хүртэхтэй хүчтэй хамааралтай байна. Тодруулбал, эмэгтэйчүүд эрчүүдээс илүү үр ашиг хүртэх магадлалтай байсан; хамгийн өндөр насны бүлэг (60 ба түүнээс дээш насны) үр ашиг хүртэх магадлал хамгийн бага; мөн ажил олгогчид ажилтнуудаас илүү үр ашиг хүртэх магадлал өндөр байсан юм.

Эдийн засгийг дэмжих арга хэмжээний үр өгөөж нь цар тахлын үзүүлсэн нөлөөтэй таарахгүй байна. Жишээ нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажил олгогчидтой бараг адилхан нөлөөнд өртсөн боловч шинжилгээнээс харахад эдийн засгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнээс ажил олгогчидтой адил үр ашиг хүртэж чадаагүй байна. Боловсролын түвшний хувьд бас өртсөн нөлөө, хүртсэн үр ашгийн хооронд үл нийцэл байсан. Тухайлбал, бүрэн дунд боловсролтой иргэд хямралд хамгийн их өртсөн бүлгийн нэг байсан боловч дэмжлэгийн арга хэмжээнээс хангалттай үр ашиг хүртсэн бүлгийн тоонд орж чадаагүй байна.

ДҮГНЭЛТ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР ХАРЬЦУУЛАХ НЬ (СУДАЛГААНЫ ҮЕД/ЦАР ТАХЛЫН ҮЕД)

Ажилгүй болох. Судалгааны мэдээлэл цуглувалт цар тахлын үетэй давхацсан. Цар тахлаас шалтгаалж хөл хорио тогтоосноос албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү нь ажил үйлчилгээгээ явуулаагүй гэжээ. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, ажил олгогчидтой харьцуулахад ажилтнууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь ажил үйлчилгээ явуулаагүй байв. Ажил үйлчилгээ явуулаагүй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас арай илүү нь засгийн газраас авсан хөл хорионы арга хэмжээний улмаас ажил бизнесээ хязгаарлахаас өөр аргагүй байсан гэж хариулжээ.

Хөдөлмөр эрхлэлт буурсан. Судалгааны хугацаанд ажилтай байсан хүмүүсийн 70 хувь нь тэдний аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны түвшин буурсан, аравны нэгээс арай илүү нь аж ахуйн нэгж нь түр хаагдсан гэж хариулжээ. Бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагааны түвшин буурах нь тулхүү ажиглагдсан. Харин зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа түр хаах нь илүү тохиолджээ. Судалгааны хугацаанд ажиллаж байсан бараг бүх оролцогчид цар тахлын өмнө эрхэлж байсан ажлаа үргэлжлүүлэн эрхэлж байна.

Долоо хоногийн дундаж ажлын цаг. Цар тахлын үед долоо хоногийн дундаж ажлын цаг 6-7 цагаар буурчээ. Эмэгтэй ажилтан болон эмэгтэй хувиараа хөдөлмөр

эрхлэгчдийн ажлын цаг нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү буурсан байна. Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, хамгийн их өртсөн нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд, барилгын салбар дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажил олгогчид байв.

Цэвэр орлого. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл бүгдийнх нь цэвэр орлого буурсан байна: ажил олгогчдын хувьд 57 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 55 хувиар, ажилтнуудын хувьд 40 хувиар буурав. Эрэгтэйчүүдийн цэвэр орлого эмэгтэйчүүдийнхээс илүү буурчээ. ЭЗҮА-ны салбар болон хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл барилгын салбарын ажил олгогчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид хамгийн их бууралттай байна.

Амьжираанд орлого хүрэлцэхгүй байх. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бараг тал нь цар тахлын үед өрхийн орлого нь амьжирааны зардлаа нөхөхөд хүрэлцэхгүй байна гэжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны зургаагаас илүү нь амьжирааны хэрэгцээний зардлаа нөхөхөд хүрэлцээтэй хэмжээний тусlamж аваагүй гэжээ.

Дийлэнх нь хөл хорионы арга хэмжээний улмаас:

- ▶ ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаа багассан;
- ▶ ажил, бизнесээ түр хугацаанд эсвэл бүрмөсөн зогсоосон;
- ▶ цалин орлого нь буурсан;
- ▶ ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийн үнэ өссөн;
- ▶ зайлшгүй шаардлагатай түүхий эдийн нийлүүлэлт тасалдсан;
- ▶ бизнес, хөрөнгө оруулалтын үр дүнтэй шийдвэр гаргахад хүндрэлтэй болсон гэж хариулжээ.

Засгийн газрын тусlamж. Албан бус хөдөлмөр эрхлэгчид бараг бүгд цахилгаан, дулаан, усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээнд, аравны долоогоос илүү нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид, зээлийн эргэн төлөх хугацааг хойшуулсан арга хэмжээнд тавны нэг орчим нь хамрагджээ. Ихэнх нь засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээг өрхийн орлогыг дэмжсэн, ашиглалтын зардал бууруулсан, цалин, цэвэр орлогыг дэмжсэн зэргээр үр дүнтэй болсон гэж үзсэн, харин ажилтнуудын хувьд ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бага үр ашиг хүртсэн байна.

Ажил олгогч, хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд бараг бүгдээрээ бизнесээ үргэлжлүүлэх бодолтой байна. Гэхдээ ихэнхэд нь хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг хэрэгцээтэй, учир нь цар тахлын үед санхүүгийн хомсдол хамгийн ноцтой асуудал болох хүлээлттэй байна.

Дижитал технологийн хэрэглээ. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны дөрөв хүрэхгүй нь бизнестээ дижитал технологийг ашигладаг. Дижитал технологийн хэрэглээ боловсролын түвшин ахих тусам нэмэгдэж, нас, бизнес эрхэлсэн хугацаа ахих тусам буурч байсан.

Хамгийн их ашиглагддаг олон нийтийн цахим сүлжээ бол Facebook, түүнээс хамаагүй бага боловч дараагийнх нь WeChat байв. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны ес гаруй нь мобайл мөнгө, карт (ATM) ашигладаг бөгөөд бараг тал нь онлайн худалдаа хийдэг байна.

Нэмэлт статистик дүн шинжилгээгээр дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

- ▶ Зочид буудал, тээвэр, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг болон харьцангуй өндөр боловсролтой иргэд цар тахлын үеэр ажилгүй болох магадлал өндөр байна.

Засгийн газрын цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- ▶ Зочид буудал, тээвэр, барилгын ажил эрхэлдэг, илүү боловсролтой болон ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өрхийн орлогод илүү хүнд нөлөөлсөн.
- ▶ Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид, голчлон байр сууц, тээвэр болон бусад үйлчилгээ эрхэлдэг хүмүүс, залуу, эрэгтэйчүүдийн ажлын цаг, бизнесийн үйл ажиллагааг багасгах, түр эсвэл бүрмөсөн хаах, цалин эсвэл бизнес буурах зэрэгт илүү нөлөөлсөн.
- ▶ Ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийн үнийн өсөлт, зайлшгүй шаардлагатай түүхий эдийн нийлүүлэлтийн тасалдал, бизнес болон хөрөнгө оруулалтын шийдвэрт тодорхой бус байдал нэмэгдсэн зэргээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид, залуу ажилчид, дээд боловсролгүй, бүрэн дунд боловсролтой иргэдэд илүү хүчтэй нөлөөлж байв.
- ▶ Цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд НДШ-ийг бүрэн тэглэсэн арга хэмжээ нь эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд, ажилтнуудаас илүү ажил олгогчдод үр өгөөжтэй байсан бол 60 ба түүнээс дээш насны иргэд насны бүлгээрээ хамгийн бага ашиг хүртсэн байх магадлалтай.
- ▶ Орлогын татвараас чөлөөлсөн нь эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдэд ашигтай байсан байж болох шинжилгээний дүн гарсан.
- ▶ Ажил олгогчид ажилтнуудтай харьцуулахад ААНОАТ-аас чөлөөлгэдсөнөөс үрашиг хүртэх магадлал илүү өндөр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдээс хамаагүй бага үр ашиг хүртэх магадлалтай байсан.

ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ

ҮР ДҮН

ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

Судалгааны үр дүнгээр албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд хөдөлмөрийн дараах таатай бус нөхцөлийг онцолмоор байна. Үүнд:

- ▶ Ажил олгогчтой албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй нь ажилтнуудын хувьд ноцтой асуудал. Тэдний 75.5 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй эсвэл ажил олгогчтойгоо зөвхөн амаар тохиролцон ажилладаг.
- ▶ Албан бус хөдөлмөр эрхлэгчид долоо хоногт дунджаар 58.1 цаг ажилладаг нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цагийн ажлын долоо хоногоос хавьгүй илүү байна.

ЭЗҮА-НЫ САЛБАРААР. Судалгаа мөн ЭЗҮА-ны салбараар ажлын нөхцөлийн ялгааг харуулсан. Ажилтнуудын хувьд боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээврийн салбарын дундаж цалин илүү өндөр байсан бол ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд зочид буудал, тээврийн салбар өндөр ашигтай байна. Харин барилга, тээврийн салбарын ажилтан болон ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, боловсруулах үйлдвэрлэлийн ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч ажлын цагийн хуваарьтай байх магадлал багатай, барилга, тээврийн салбарын ажилтнууд тогтмол хуваарийн дагуу цалин авах магадлал бага байв.

Хүйсээр. Хүйсийн ялгаа нь хөдөлмөрийн нөхцөлтэй мөн уялдаатай байв. Эмэгтэй ажилтнууд тогтмол цалинтай, тогтмол ажлын хуваарьтай байх магадлал өндөр. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд ердийн цагийн хуваарийн дагуу, арай бага цагаар ажиллах магадлал өндөр. Харин эмэгтэй ажил олгогч, эмэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамаагүй бага ашиг олдог.

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн том сул тал. Ажилтнуудын хувьд гол сул тал нь нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй, тогтмол бус цалин, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу зэрэг байв. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд орлого ашгийн тогтвортгүй байдал, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй, мөн ажлын байрны баталгаат байдал дутмаг зэрэг нь гол сул тал байсан. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд голчлон анхаарах шаардлагатай юм.

АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД: АЛБАН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ

Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь албан эдийн засагт шилжих сонирхолтой байгаагаа илэрхийлж, албан ёсны хөдөлмөр эрхлэлт үр ашигтай байна гэсэн тодорхой хулээлттэй байв. Энэ нь тэдний хөдөлмөр эрхлэлтийг албан болгох санаачилгыг нэвтрүүлэх эсвэл өргөжүүлэхэд тохиромжтой эхлэлийн цэг болно.

Барилга, үйлдвэрлэлийн салбарын ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид бизнесээ бүртгүүлэх илүү сонирхолтой байсан бол тээврийн салбарынхан бизнесээ

бүртгүүлэх сонирхол бага байсан. Үүнээс гадна залуучууд, ажил бизнесээ болино хугацаанд эрхэлж буй ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид албан эдийн засагт шилжих сонирхол илүү илэрхийлсэн.

Тэдтатвар, нийгмийн даатгалын шимтгэлийг албан эдийн засагт шилжихэд хүлээгдэж буй хамгийн том саад бэрхшээл гэж мэдэгджээ. Түүнчлэн татвар, хураамжийн тухай хууль тогтоомжийн мэдлэг дутмаг, нягтлан бодох бүртгэлийн асуудал, бүртгэлийн дүрэм журмын төвөгтэй байдал зэрэг байв. Хувиараа бизнес эрхлэгчид бизнесээ албан хэлбэрт шилжүүлэхэд хамгийн их шаардлагатай дэмжлэг бол бага хүйтэй зээл гэж мэдээлсэн.

Ажил олгогчдын үзэж байгаагаар дараах арга хэмжээ нь бизнесээ бүртгүүлэхэд хамгийн их түлхэц болно гэсэн. Үүнд:

- ▶ орлогын албан татвараас тодорхой хугацаагаар чөлөөлөх;
- ▶ НӨАТ-аас чөлөөлөх;
- ▶ нийгмийн даатгалын төлбөрөөс чөлөөлөх;
- ▶ ажлын байрны түрээсийн хөнгөлөлт;
- ▶ бичил бизнест зориулсан бага хүйтэй зээл;
- ▶ териин худалдан авалтад хамрагдах.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг илүү их дурдсан. ЭЗҮА-ны салбараар үзвэл барилгын салбарынхан орлогын албан татвараас чөлөөлөгдөх, төрийн худалдан авалтад хамрагдах боломжийн талаар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхан төрийн худалдан авалтад хамрагдах боломжийг илүү их дурдсан.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн олонх нь бизнесээ албан ёсоор бүртгүүлэх хүсэл сонирхолд цахим бүртгэл хэрхэн нөлөөлөхийг мэдэхгүй байсан. Тэдний аравны гурав нь бүртгүүлэх хүсэлд нь нөлөөлнө гэж хариулсан бол дөрөвний нэг нь ямар ч нөлөө үзүүлэхгүй гэж хариулжээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар мэдлэггүй байна. Мэдлэггүй байдал боловсролын түвшин доогуур хүмүүсийн хувьд өндөр байх хандлага ажиглагдсан.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны нэг гаруй нь л хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан. Ажилтнуудын дөнгөж хорин хүний нэг нь л хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн тавны нэг орчим нь ямар ч ашиг хүртээгүй гэж мэдээлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хамгийн их дурдагдсан сул тал бол санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал байсан гэжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны долоо орчим нь төрөөс ямар нэгэн дэмжлэг авах шаардлагатай гэж хариулсан бөгөөд хамгийн их дурдагдсан дэмжлэг нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, бичил бизнесийн зээл, гарааны бизнесийг дэмжих дэмжлэг зэрэг байв. Төрөөс ямар нэгэн дэмжлэг хэрэгтэй гэж хариулсан оролцогчдын тал хувь нь бизнес эрхлэх сургалт хэрэгцээтэй байгааг дурджээ.

ЦАР ТАХЛЫН АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Өмнө дурдсанчлан цар тахлын үед явуулсан судалгааны хугацаанд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тал орчим нь ажил үйлчилгээгээ явуулаагүй байв. Байр сууц, тээвэр, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг болон харьцангуй дээд боловсролтой иргэд цар тахлын үеэр ажилгүй болох магадлал өндөр байна.

Судалгааны мэдээлэл цуглувалт цар тахлын үетэй давхацсан. Цар тахлаас шалтгаалж хөл хорио тогтоосноос албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү нь ажил үйлчилгээгээ явуулаагүй гэжээ. Бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагааны түвшин буурах нь тулхүү ажиглагдсан. Харин зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа түр хаах нь илүү тохиолджээ.

Цар тахлын үед долоо хоногийн дундаж ажлын цаг 6-7 цагаар буурчээ. Эмэгтэй ажилтан болон эмэгтэй хувиараах хөдөлмөр эрхлэгчдийн нажлын цаг нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү буурсан байна. Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, хамгийн их өртсөн нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд, барилгын салбар дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажил олгогчид байв.

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл бүгдийнх нь цэвэр орлого буурсан. Ажил олгогчдын хувьд 57 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 55 хувиар, ажилтнуудын хувьд 40 хувиар орлого буурсан гэсэн. Эрэгтэйчүүдийн цэвэр орлого эмэгтэйчүүдийнхээс илүү буурчээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бараг тал нь цар тахлын үед өрхийн орлого нь амьжирааны зардлаа нөхөхөд хүрэлцэхгүй байна гэжээ. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн аравны зургаагаас илүү нь амьжирааны хэрэгцээний зардлаа нөхөхөд хүрэлцээтэй хэмжээний тусламж аваагүй гэжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх хувь нь хөл хорионы арга хэмжээ дараах байдааар тэдний амьжирааг хүндрүүлсэн эсвэл маш хүнд байдалд хүргэсэн гэж үзжээ. Үүнд:

- ▶ ажлын цаг, бизнесийн үйл ажиллагаа багассан;
- ▶ ажил, бизнесээ түр хугацаанд эсвэл бүрмөсөн зогсоосон;
- ▶ цалин орлого нь буурсан;
- ▶ ажил үйлчилгээнд шаардлагатай түүхий эдийн үнэ өссөн;
- ▶ зайлшгүй шаардлагатай түүхий эдийн нийлүүлэлт тасалдсан;
- ▶ бизнес, хөрөнгө оруулалтын үр дүнтэй шийдвэр гаргахад хүндрэлтэй болсон.

Монгол Улсын Засгийн газраас цар тахлын эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн нөлөөлөл нийгмийн дэд бүлгүүдэд ялгаатай байдлаа нөлөөлсөн байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид бараг бүгд цахилгаан, дулаан, усан хангамжийн төлбөр тэглэсэн арга хэмжээнд, аравны долоогоос илүү нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид, зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан арга хэмжээнд тавны нэг орчим нь хамрагджээ.

Эрэгтэйчүүд болон ажил олгогчид ААНОАТ-аас чөлөөлсөн арга хэмжээнээс илүү үр ашиг хүртсэн.

Ихэнх нь засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээг өрхийн орлогыг дэмжсэн, ашиглалтын зардал бууруулсан, цалин, цэвэр орлогыг дэмжсэн зэргээр үр дүнтэй болсон гэж үзсэн, харин ажилтнуудын хувьд ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бага үр ашиг хүртсэн байна.

Ажил олгогч, хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд бараг бүгдээрээ бизнесээ үргэлжлүүлэх бодолтой байна. Гэхдээ ихэнхэд нь хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг хэрэгцээтэй, учир нь цар тахлын үед санхүүгийн хомсдол хамгийн ноцтой асуудал болох хүлээлттэй байна.

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны дөрөв хүрэхгүй нь бизнестээ дижитал технологийг ашигладаг. Дижитал технологийн хэрэглээ боловсролын түвшин ахих тусам нэмэгдэж, нас, бизнес эрхэлсэн хугацаа ахих тусам буурч байсан.

Хамгийн их ашиглагддаг олон нийтийн цахим сүлжээ бол Facebook, түүнээс хамаагүй бага боловч дараагийнх нь WeChat байв. Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аравны ес гаруй нь мобайл мөнгө, карт (ATM) ашигладаг бөгөөд бараг тал нь онлайн худалдаа хийдэг байна.

ЗӨВЛӨМЖ

Таагүй хөдөлмөрийн нөхцөлийн асуудлыг шийдвэрлэх. Судалгаагаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөл тааламжгүй байгааг нотолсон.

Ажилтнуудын хувьд дийлэнх нь албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй, мөн олон тооны ажилтан цалин хөлсөө тогтсон хуваарийн дагуу авдаггүй нь санаа зовоосон асуудал хэвээр байна.

Ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд бас нэг санаа зовоосон асуудал бол хэт урт ажлын цаг юм.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх, эрх ашгаа хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх замаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой. Хөдөлмөрийн харилцааны гурван талт байгууллагууд энэ ажилд идэвхтэй оролцох ёстой.

Судалгаагаар албан эдийн засагт шилжих сонирхол давамгайлж байгаа нь үүнийг дэмжсэн хөтөлбөрийг нэвтрүүлэх эсвэл өргөжүүлэх боломжийг харуулж байна. Ингэхдээ судалгааны үр дүнгээс харгалzan үзэх ёстой.

- ▶ Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбартай харьцуулахад барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынхны хувьд албан хэлбэрт шилжих сонирхол өндөр байв.
- ▶ Шилжих сонирхол залуу, өндөр боловсролтой ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд илүү байсан.
- ▶ Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй харьцуулахад ажилтнуудын дунд илүү байсан.

Албан эдийн засагт шилжих хөтөлбөрүүдийг сурталчлах. Ийм арга хэмжээг төлөвлөхдөө албан бус хөдөлмөр эрхлэгчдийн албан хэлбэрт шилжихэд тулгарна гэж хүлээж буй гол бэрхшээлийг хэрхэн үзэж буйг харгалзан үзэх ёстой. Энэхүү судалгаагаар, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд гол бэрхшээлд дараах зүйлийг дурдсан болно. Үүнд:

- ▶ татвар, нийгмийн даатгалын шимтгэл;
- ▶ татвар, хураамжийн тухай хуулийн мэдлэг дутмаг;
- ▶ нягтан бодох бүртгэлийн асуудал болон
- ▶ бүртгэлийн дүрэм журмын төвөгтэй байдал.

Судалгааны үр дүнгээр албан эдийн засагт шилжих үр дүнтэй арга хэмжээнүүдэд дараах зүйлс орох ёстой. Үүнд:

- ▶ сургалт, жишээлбэл, нягтан бодох бүртгэлийн, татварын хуулийн, ажлын ур чадварын;
- ▶ холбогдох мэдээлэл түгээх;
- ▶ бүртгэлийн журмыг хялбаршуулах болон
- ▶ нийгмийн даатгалын шимтгэл, татварын төлбөрөөс түр хөнгөлөх буюу чөлөөлөх.

Энгийн бөгөөд үр дүнтэй бүртгэл нь дараах журмыг агуулж болно:

- ▶ Цахим бүртгэлийн тогтолцоог бий болгох,
- ▶ Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн олонх нь цахим бүртгэлийн үр нөлөөг тодорхой үнэлж мэдэхгүй байсан учраас бүртгэлийн тогтолцоог хэрхэн ашиглах талаар мэдээлэл түгээж, сургалт зохион байгуулах,
- ▶ Цахим бүртгэлийн үр дүнтэй тогтолцооны цогц загвар нь нийгмийн туслалцаа авах шаардлагатай өрх, хувь хүнийг (бүх төрлийн ажлын байрнаас) бүртгэх боломжийг олгоно,
- ▶ Бүртгэлийн тогтолцоог (цахим бүртгэлийг оруулаад) эхлээд эмзэг бүлгийг, дараа нь бичил аж ахуйн нэгжүүдийг, дараа нь дагаж мөрдөх үүрэг хариуцлага өндөртэй томоохон компаниуд гэсэн дарааллаар зохион байгуулж болно. Судалгааны үр дүнгээс харахад ажилтнууд цар тахалтай

холбоотой тусламжаас ажил олгогчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс бага хэмжээнд үр ашиг хүртсэн нь харагдсан.

Албан эдийн засагт шилжихэд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ялгаатай дэд бүлгүүдэд ялгаатай хөшүүрэг шаардагдах нь судалгаагаар тогтоогдсон:

- ▶ **Ажил олгогчид ба илүү өндөр боловсролтой хувиараа хөдөлмөр эрхлэгчид.** Эдгээр дэд бүлгүүдэд орлогын албан татвар, НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх аргах эмжээголхөшүүрэг бол ногэж дурджээ. Өөрөөр хэлбэл тавигдах шаардлага, дүрэм журам нь хялбарчлагдвал энэ бүлэг илүү хурдан албан хэлбэрт шилжих боломжтой байж болно. Ажил олгогчид, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарынхан төрийн худалдан авалтад хамрагдах боломжийг урамшуулалт хөшүүрэг гэж үзсэн.
- ▶ **Ажилтан.** Энэ дэд бүлгийн дунд хамгийн их дурдагдсан бэрхшээл бол боловсрол, шаардлагатай ур чадвар дутмаг, ажлын байр хомс зэрэг байв. Мөн өндөр цалинтай ажлын байр, ажилд зуучлах үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илэрхийлж байсан.

Холбогдох мэдээллийг түгээх. Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь хөдөлмөр эрхлэлтийн хууль, бодлого, хөтөлбөрүүдийн талаар мэдлэг дутмаг байгаагаа илэрхийлсэн тул эдгээр чиглэлийн мэдлэг, мэдээлэл олгох шаардлагатай нь тодорхой. Судалгааны үр дүнгээс харахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар илүү их мэдлэгтэй байх нь тэдний оролцоог нэмэгдүүлэх сайн талтай бөгөөд дашрамд дурдахад оролцоо нь маш бага байсан.

Мэдээлэл түгээх хөтөлбөрүүдэд судалгаагаар илэрсэн дараах дүгнэлтийг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- ▶ боловсролын түвшин багатай иргэд хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрийн талаар мэдлэг багатай байх хандлагатай байсан;
- ▶ ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг бодвол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт ажилтан хамрагдах магадлал бага байсан.

Хөтөлбөрүүдийг зохиохдоо албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ихэвчлэн ашигладаг мэдээллийн суваг, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг (онлайн болон утас, телевиз, радио, Facebook болон WeChat) харгалзаж үзэх хэрэгтэй.

Цар тахлын үед хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь бизнест нь дэмжлэг шаардлагатай, ялангуяа хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүгийн тусламж авах шаардлагатай байна гэсэн. Засгийн газраас ийм дэмжих арга хэмжээг төлөвлөхдөө хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хэрэгцээ, төсвийн боломж, хязгаарлалт, засгийн газрын бусад хэрэгцээ, зарим бизнесийн цар тахлын үед үйл ажиллагаа явуулах чадвар зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

Дижитал технологийг сурталчлах. Дижитал технологи нь цар тахлын үед бизнесээ тогтвортой байлгахад чухал хүчин зүйл боловч ажил олгогч, хувиараа бизнес эрхлэгчдийн бизнестээ дижитал технологийг хэрэглэх нь хязгаарлагдмал хэвээр байна. Цар тахлын үед бизнест туслах арга хэмжээний нэг үр ашигтай хэлбэр бол ийм технологийг ашиглах зохих хэмжээний сургалт байж болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Alzúa, Laura Alzúa, Soylomaa Batbekh, Altantsetseg Batchuluun, Batbekh Dalkhjav, and José Galdo. 2019. "Demand-Driven Youth Training Programs: Experimental Evidence from Mongolia." Policy Research Working Paper 9226. In *The World Bank Economic Review*.
- Anderson, James H. 1998. *The Size, Origins, and Character of Mongolia's Informal Sector during the Transition*. World Bank Publications.
- ASEAN (Association of Southeast Asian Nations) Secretariat. 2019. *Regional Study on Informal Employment Statistics to Support Decent Work Promotion in ASEAN*. Jakarta.
- Bank of Mongolia. 2018. *Small and Medium Enterprise Development and Financing Status Survey*. In Mongolian.
- Bikales, Bill, Chimed Khurelbaatar, and Karin Schelzig. 2000. *Mongolian Urban Informal Sector*. Development Alternative Inc. for Economic Policy Support Project (EPSP/USAID).
- Bosio, Erica, Filip Jolevski, Joseph Lemoine, and Rita Ramalho. 2020. "Survival of Firms in Developing Economies during Economic Crisis." In *COVID-19 in Developing Economies*, edited by Simeon Djankov and Ugo Panizza. London, Centre for Economic Policy Research (CEPR).
- CGAP (Consultative Group to Assist the Poor). 2020. *Relief for Informal Workers: Falling through the Cracks in the COVID-19 Crisis*.
- Chacaltana, Juan, Vicky Leung, Miso Lee. 2018. *New Technologies and the Transition to Formality: The Trend towards E-formality*. Working Paper No. 247, Employment Policy Department, ILO (Geneva).
- FAO (Food and Agriculture Organization). 2020. *Impact of COVID-19 on Informal Workers*.
- FRC (Financial Regulatory Commission of Mongolia). 2020. *A Study of Small and Medium Enterprises and Their Financing*. In Mongolian. Available at:
- Gassmann, Franziska, Daphne Francois, and Lorena Zardo Trindade. 2015. *Improving Labour Market Outcomes for Poor and Vulnerable Groups in Mongolia*. World Bank.
- Gérxhani, Klarita. 2004. "The informal sector in developed and less developed countries: A literature survey." In *Public Choice* 120(3-4): 267-300.
- Heintz, James. 2010. Defining and measuring informal employment and the informal sector in the Philippines, Mongolia, and Sri Lanka. ESCAP Working Paper.
- Hussmanns, Ralf. 2004. *Statistical Definition of Informal Employment: Guidelines Endorsed by the Seventeenth International Conference of Labour Statisticians*. ILO.
- Komin, Wichaya, Rungnapa Thepparp, Borvorn Subsing, and David Engstrom. 2021. "COVID-19 and Its Impact on Informal Sector Workers: A Case Study of Thailand." In *Asia Pacific Journal of Social Work and Development*, 31:1-2: 80-88, DOI: 10.1080/02185385.2020.1832564.
- ILO (International Labour Office). 2004. *Statistical Definition of Informal Employment: Guidelines Endorsed by the Seventeenth International Conference of Labour Statisticians (2003)*. Bureau of Statistics.

- ILO (International Labour Organization). 2015. Recommendation No. 204, *Transition from the Informal to the Formal Economy*.
- . 2013. *The Informal Economy and Decent Work: A Policy Resource Guide Supporting Transitions to Formality*.
- . 2020. *Impact of lockdown measures on the informal economy*. ILO Brief.
- Mehrotra, Santosh. 2019. *From Informal to Formal: A Meta-Analysis of What Triggers the Conversion in Asia*. Background Paper for the GEPR chapter on informality. ILO.
- Morris, Elizabeth. 2001. *The Informal Sector in Mongolia*. ILO.
- NSO (National Statistical Office of Mongolia). 2019. Labour Force Survey.
- Octavia, Joanna. 2020. *Building Back Better: COVID-19 and Informal Workers in Indonesia*. LSE Southeast Asia Blog.
- Parisotto, Aurelio. 2021. *Gaps, Challenges and Progress Made in Employment Creation*. ILO. Presentation made at the Inter-agency EGM on Implementation of the Third UN Decade for the Eradication of Poverty (2018–27) on 26 May 2021.
- Shatz, Howard J., Louay Constant, Francisco Perez-Arce, Eric Robinson, Robin L. Beckman, Haijing Crystal Huang, Peter Glick, and Bonnie Ghosh-Dastidar. 2015. *Improving the Mongolian Labor Market and Enhancing Opportunities for Youth* [Product Page]. Rand Corporation.
- Slonimczyk, Fabián. 2014. *Informal Employment in Emerging and Transition Economies*. IZA World of Labour.
- WIEGO (Women in Informal Employment Globalizing and Organizing). 2021. *COVID-19 Crisis and the Informal Economy: Informal Workers in Bangkok, Thailand*.
- World Bank. 2020. *Doing Business in 2020: Comparing Business Regulation in 190 Economies*.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. 2013. *Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүтэц, төлөв байдлын судалгааны тайлан*, ХНХСИ, Улаанбаатар.
- С.Галбадрах. 2011. *Албан бус секторт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн өнөөгийн байдлын судалгаа, Шинэ толь, #71*.
- Үндэсний статистикийн хороо. 2009. *Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгааны тайлан 2007-2008 он*. YCX, Улаанбаатар.
- Үндэсний статистикийн хороо. 2013. *Далд эдийн засгийг тооцох судалгааны нэгдсэн тайлан, 2010 он*. YCX, Улаанбаатар.
- Үндэсний статистикийн хороо. 2020. *Далд эдийн засгийг хэмжих судалгаа, тооцоо 2015–2018 он*. YCX, Улаанбаатар.

